

3-р сарын 22. 2003 он

Хүний Эрхийн Үндэсний Комисс  
НҮБХХ-ийн хүний эрхийн хангах төсөл

**“Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал,  
нийгмийн хамгаалал” судалгаа**

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

Монгол улс, Улаанбаатар хот, 2003

**“Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгаалал”  
сэдэвт судалгаа**

**Агуулга**

Оршил

Нэгдүгээр хэсэг

**Арга зүй**

- 1.1. Судалгааны арга зүй, аргачлал
- 1.2. Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн байдал

Хоёрдугаар хэсэг

**Тахир дутуу хүний эрх, нийгмийн байдал**

- 2.1. Тахир дутуу иргэдийн эрхийн зөрчил
- 2.2. Тахир дутуу иргэдийн эрх зөрчигдөхөд нөлөөлж буй хүчин зүйл
- 2.3. Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын хүртээмж

Гуравдугаар хэсэг

**Тахир дутуу хүний эрх, нийгмийн байдлыг сайжруулах арга зам**

- 3.1. Тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалах байгууллага
- 3.2. Тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох нь

Дүгнэлт, зөвлөмж

---

© Хүний эрхийн үндэсний комисс. 2003 он

**Судалгааны тайлан бичсэн**

Ц.Одгэрэл

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## Оршил

Сүүлийн жилүүдэд тахир дутуу болох явдал нэмэгдсээр байгаа<sup>1</sup> бөгөөд энэ нь тахир дутуу иргэдэд тавих анхаарал, нийгмийн халамж, үйлчилгээ тэдний эрхийг хамгаалах асуудлыг давхар хөндөж байгаа билээ.

Монгол улсын Үндсэн хууль, холбогдох чиглэлийн хуулинд зааснаар бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэл ярианы болон бие эрхтний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлтэй болох нь тогтоогдсон бол тахир дутуу иргэнд тооцож байна.

Тахир дутуу иргэдийн талаар гаргасан төрийн бодлого, шийдвэр, тэднийг нийгмийн амьдралд татан оролцуулж нийгмийн баталгааг хангах асуудлууд МУ-ын үндсэн хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмжийн төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль, 1998 онд баталсан Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр, засгийн газар болон холбогдох яамдын тогтоол шийдвэрт тусгалаа олон хэрэгжих үндэслэлийг буй болгосон юм.

Гэвч өнөөгийн байдлаар тахир дутуу иргэд хуулинд заасан тэгш эрхээ эдлэх нийгэм эдийн засгийн нөхцөл, хууль эрх зүйн орчин тахир дутуу хүний эрхийг хангахуйц түвшинд бүрэлдэж чадаагүй байна. Албан ёсны тоо баримтанд дурьдсанаар улсын хэмжээгээр (Үндэсний Статистикийн газар, Эрүүл мэндийн яам) 45.000-100.000 тахир дутуу иргэд байна гэсэн тооцоо судалгааг гаргаад байгаагийн 15% нь харааны өөрчлөлттэй, 19.5% нь сонсгол, хэл ярианы өөрчлөлттэй, 36.5% нь оюун ухааны хомсдолтой, 30% нь бусад шалтгааны улмаас тахир дутуу болсон тооцоо судалгааг гаргасан байна

Иймд хууль эрх зүйн орчин бүрдсэнээр эдгээр хууль, тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилт бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаа, тэдний нийгмийн хамгаалал, халамж, хөнгөлөлт, үйлчилгээг хэрхэн үзүүлж, эрхийн хэрэгжилт ямар байгаа, энэ талаар эрх зүйн болон эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн, зохион байгуулалтын орчин нөхцөл хэрхэн бүрдэж, ямар түвшинд буйг улсын хэмжээнд судлан тогтоох зорилгоор энэхүү судалгааны ажлыг явууллаа.

Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллын асуудлыг хөндсөн үндэсний хэмжээний цогцолбор судалгаа хомс байгаа энэ мөчид энэхүү судалгааг хийсэн нь ач холбогдлын хувьд ч, дараа дараагийн судалгааны ажлуудад суурь мэдээлэл болно гэдэгт найдаж байна.

Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгаалал шалгалт судалгааны ажлыг УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо, Хүний эрхийн үндэсний комисс хамтран бүх аймаг болон нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл, комисс, итгэмжлэгдсэн төлөөлөгчид, мэргэжлийн хяналтын алба, Монголын тахир дутуу иргэдийн холбоо, мэргэжлийн судлаачдын оролцоотойгоор хийлээ.

<sup>1</sup> Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал, 2001

## Нэгдүгээр хэсэг : Судалгааны арга зүй

### 1.1. Судалгааны арга зүй, аргачлал

#### *Судалгааны зорилго*

Тахир дутуу хүний эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллыг шалган судлах ажлын хүрээнд тэдэнд үзүүлдэг нийгмийн хамгаалал, халамж, хөнгөлөлт, үйлчилгээ, эрхийн хэрэгжилтийн байдал, эрх зүйн болон эдийн засаг, нийгэм, сэтгэл зүй, зохион байгуулалтын орчин нөхцлийг үндэсний хэмжээнд судлахад тогтооход энэхүү судалгааны зорилго оршино.

#### *Судалгааны зорилтууд*

- Тахир дутуу иргэдийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх
- Тахир дутуу иргэдийн тахир дутуугийн хэлбэр төрлийг судлах
- Тахир дутуу иргэдэд тохиолдож буй бэрхшээл, нийгмийн тулгамдсан асуудлыг судлах
- Тахир дутуу иргэдийн эрхийн зөрчил хаана, аль байгууллагад зөрчигдөж буйг тогтоох
- Тахир дутуу иргэд нийгмийн халамж үйлчилгээг хүртэхэд юу саад болж буйг тогтоох
- Тахир дутуу иргэдийн эрхийн зөрчлийг бууруулахад ямар байгууллага үүрэгтэй байж болохыг судлах
- Тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалж буй өнөөгийн хууль эрх зүйн орчин ямар байгаа, цаашид сайжруулах боломжийг судлахад оршлоо.

Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллын ерөнхийн байдалд өгч байгаа тахир дутуу иргэдийн санал бодлыг тодорхойлж, тэдний эрх, нийгмийн хамгааллын баталгааг хангах бололцоо, нөхцөл, арга замын талаар санал, дүгнэлт гаргах улмаар шаардлагатай бол холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах саналыг дэвшүүлэн тавих болно.

#### *Судалгаанд хэрэглэсэн арга*

Судалгааны зорилго, ач холбогдолтой уялдан нийгмийн судалгааны уламжлалт аргуудын нэг болох санал асуулга, хоёрдогч эх үүсвэрийн статистик мэдээллийг ашиглан судалгааны үндсэн мэдээллийг цуглууллаа.

Судалгааны асуулгын бүтэц нь 1) судалгаанд оролцогчдын талаарх ерөнхий мэдээлэл, 2) тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгаалал хэмээх 2 хэсгээс бүрэлдэж байна.

Судалгааны асуулгыг ХЭҮК-ын гишүүд, Тахир дутуу иргэдийн байгууллагын төлөөлөгчидтэй санал солилцон асуумжийн логик бүтэц, хариултын хувилбаруудын үндэслэл зохимжтой эсэхийг шалган, дахин нягтлан боловсрууллаа.

#### *Судалгааны хамрах хүрээ, хугацаа*

Энэхүү судалгааны шинжилгээний нэгж нь тахир дутуу иргэд болж байгаа бөгөөд тахир дутуу иргэдийг түүврийн нэгжээр сонгохдоо Рэндомийн буюу санамсаргүй түүвэрлэлтийн аргыг хэрэглэв.

<i>Хүснэгт 1.1 түүврийн нэгж</i>		
Аймаг нийслэл	Судалгаанд оролцсон хүн ам	
	Тоо	Хувь
Улаанбаатар		
Сүхбаатар	79	12.1
Чингэлтэй	53	8.1
Хан-Уул	72	11.0
Баянзүрх	71	10.9
Сонгинохайрхан	63	9.6
Баянгол	22	5.8
Налайх	21	3.1
<b>Бүгд</b>	<b>381</b>	<b>100.0</b>
Сэлэнгэ	10	8.6
Хэнтий	68	7.9
Өвөрхангай	39	4.6
Баянхонгор	67	7.8
Хөвсгөл	36	4.2
Дорнод	144	16.8
Булган	102	11.9
Говь-Алтай	25	2.9
Дундговь	52	8.0
Увс	50	7.6
Дорноговь	49	7.5
Говьсүмбэр	34	5.2
Завхан	64	10.0
Төв	41	6.3
<b>Бүгд</b>	<b>856</b>	<b>100.0</b>
<b>Нийт</b>	<b>1237</b>	<b>100.0</b>

Судалгаанаас харахад хот хөдөөгийн 1237 тахир дутуу иргэд оролцсон бөгөөд түүврийн төлөөлөх чадвар, мэдээллийн үнэн бодитой байх магадлал хангалттай гэж үзлээ.

Респондентуудын хэмжээг тогтоохдоо улсын хэмжээнд нийгмийн бүтцэд тахир дутуу иргэдийн эзлэх хувь хэмжээг баримжаалан түүврийн бүтцийг тогтоов.

Судалгаанд тахир дутуу иргэд гэдэг ойлголтыг хэрэглэхдээ ДЭБМ, МУ-ын үндсэн хууль болон холбогдох чиглэлийн заасанчилан "бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэл ярианы болон бие эрхтний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлтэй болох нь тогтоогдсон монгол улсын иргэнийг тооцож тахир дутуу иргэн гэж үзлээ.

#### *Судалгааны мэдээлэл боловсруулалт*

Судалгааны мэдээллийг нэгтгэн боловсруулахдаа SPSS 10.0 программыг ашиглан гүйцэтгэлээ. Судалгааны мэдээллийг шалган, хагас нээлттэй болон задгай хэлбэрийн асуултуудыг кодлох, бүлэглэх, судалгааны анкетийн логик бүтцийг оруулах, шивэх, мэдээллийг дан болон нэг ба хоёр хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг эмперик түвшний судалгааг явуулдаг горимын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны мэдээллийг боловсруулахад гарч ирсэн нэг бэрхшээлтэй асуудал бол хот хөдөөгийн судалгааны асуулга 2 бүтцээр хийгдсэн нь ажлын цаг, ачааллыг нэмэгдүүлж байсныг дурьдах нь зүйтэй болов уу.

Судалгааны мэдээллийг хот, хөдөөгөөр тус тусад нь боловсруулсан тул үзүүлэлтүүд хот хөдөөгөөр гарч байгаа болно.

## 1.2. Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн амын төлөв байдал

*Нийгэм, хүн амын төлөв байдлын үзүүлэлтүүд*

Улаанбаатарын судалгаанд оролцсон тахир дутуу иргэдийн 51.4% нь эрэгтэй, хөдөөгийн оролцогчдын 48.6% нь эрэгтэйчүүд тус тус эзэлж байна. Хөдөөгийн респондентуудын 49.7% нь эрэгтэй, үлдсэн хувийг эрэгтэйчүүд.

Судалгаанд хамрагдагчдын хувийн шинжтэй мэдээллүүдийг хүснэгт 1.2-т үзүүлэв.

Хүснэгт 1.2

Паспортын үзүүлэлтүүд	Улаанбаатар		Хөдөө		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
<b>Насны бүлэг</b>					
13-15	16	4.2	18-30	200	23.4
16-19	23	6.3	31-40	253	29.6
20-29	61	16	41-50	245	28.6
30-39	90	23.6	51-60	110	12.9
40-49	111	29.1	61+	48	5.6
50+	80	21			
<b>Боловсрол</b>					
Дээд	55	14.4	75	8.8	
Тусгай дунд	67	17.6	132	15.4	
Бүрэн дунд	94	24.7	242	28.3	
Бүрэн бус дунд	84	22	182	21.3	
Бага	35	9.2	104	12.1	
Боловсролгүй	40	10.5	121	14.1	
Сурагч	6	1.6			
<b>Гэрлэлтийн байдал</b>					
Гэрлээгүй	117	30.7			
Гэрлэсэн	167	43.8			
Салсан	47	12.3			
Бэлбэсэн	42	11			
Бусад	8	2.1			
<b>Тахир дутуугийн хэлбэр</b>					
Хараа	57	15			
Хэл ярианы	53	13.9			
Бие бялдрын	149	39.1			
Унадаг	32	8.4			
Сэтгэцийн	21	5.5			
Оюун ухааны хоисдол	14	3.7			
Бусад	55	14.4			

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 42.3% нь нийгмийн халамжид 14.4% нь хөдөлмөрийн чадвараа 80 хувь алдсан, 11.5% нь ажилгүй, 12.1% нь тэтгэвэрт, үлдсэн хэсэг нь төрийн болон хувийн хэвшилд ажил эрхэлж байна.

Хүснэгт 1.3


Тахир дутуу иргэдийн ам бүлийн тоо (Улаанбаатар)

	Тоо	Хувь
1-3	112	29.4
4-5	144	37.8
6+	125	32.8
Дүн	363	100.0

Хөдөөд тахир дутуу иргэдийн эдийн засгийн идэвхийг Зураг 1.1-ээр харууллаа.

Зураг 1.1.

**Хөдөөгийн судалгаанд оролцогчдын эдийн засгийн идэвхийн байдал, ажил эрхлэлтээр**



Дээрх байдалд шинжилгээ хийж үзвэл хөдөөд тахир дутуу иргэд хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл тааруу байгаа нь харагдаж байна.

Эдийн засгийн чадамжийн байдлыг хоттой харьцуулж үзвэл хөдөөд илүү ажилгүйдэл байгаа нь тод харагдлаа. Мөн хотод тахир дутуу иргэдийн 14.4% нь хөдөлмөрийн чадвараа алдсан байхад хөдөөд 23.1% нь хөдөлмөрийн чадвараа алдсан байна, үүнд хөдөөнийхөн судалгаанд ихээхэн хэмжээгээн хамрагдсантай холбоотой.

Тахир дутуу иргэдийн амьдран суудаг сууцны төрөлийг сонирхож үзэхэд судалгаанд оролцсон тахир дутуу иргэдийн (Улаанбаатарт) 33.1% нь орон сууцанд, 46.5% нь гэр буюу хашаа байшинд, 5.5% нь нийтийн байранд, 10.5% нь айлын хажууд буюу түрээсийн байр, гэрт, 4.5% нь өөрийн гэсэн орон гэргүй байлаа.

#### Эдийн засгийн чадавхийн байдал

Судалгаанд оролцогчдын (улаанбаатар) өрхийн орлогын дийлэнх хувийг буюу 44.4 хувийг тэтгэмж эзэлж байна.

Зураг 1.2



Сүүлийн жилүүдэд өрхийн орлого нь тахир дутуу иргэдийн эдийн засгийн идэвхийн байдал, тахир дутуугийн хэлбэр, хүнд хөнгөнөөс хамаараад тахир дутуу иргэдийн аж байдал, амьдралын түвшин буурах төлөвтэй байгаа үзүүлэлт давамгайлж байна. **Сүүлийн жилүүдэд танай ахуй амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ** гэсэн асуултад Улаанбаатар хотын оролцогчдын 13.1% нь сайн, 42% нь хэвийн, үлдсэн хэсэг нь буюу 44.8.1% нь амьдралын дундаас доогуур түвшинд амьдарч байна.

Амьдралын чадамж, орлогын хүрэлцээ тааруу байгаа нь дараах асуултаар ч давхар нотлогдож байгаа билээ. Үүнд тахир дутуу иргэдийн сэтгэл зовоосон бэрхшээлтэй асуудлын тоонд хамгийн өндөр хувьтай гарч ирсэн нэг үзүүлэлт бол орлого бага учраас амьдралд хүрэлцдэггүй гэж 39.4% нь үзсэн явдал. Үүний дараа өөрийн гэсэн орон гэр байхгүй, ажил олгогч нар ажилд авахаас цааргалдаг байдал гэжээ.

Хөдөөд дээрх байдал ялангуяа орлогын хүрэлцээгүй байдал 56.7%, тахир дутуу иргэдэд ажлын байрны хүрэлцээ хомсдол үүнээс үүдэлтэй орлогын эх үүсвэргүй болж (32.1%) байгаа нь анхаарал татсан асуудал болжээ.

Судалгааны үр дүнгээс харахад эхний ээлжинд тахир дутуу иргэдийн нас, хүйс болон тахир дутуугийн хүнд хөнгөн хэлбэрүүдийг харгалзан тэднийг хөдөлмөрлөх боломжоор хангах асуудал нэн тулгамдсан асуудал болон хувирч энэхүү асуудлаар төрийн хэмжээнд зохицуулахаас өөр аргагүй бөгөөд хүмүүнлэгийн болон нийгмийн салбарын цогц суурь үйлчилгээнд системтэйгээр хамруулах асуудлыг хөндөн тавьж байгааг илтгэж байна.



## Хоёрдугаар хэсэг: Тахир дутуу хүний эрх, нийгмийн байдал

### 2.1. Тахир дутуу иргэдийн эрхийн зөрчил

Судалгааны зорилгоор дэвшигдсэн үндсэн асуудлын нэг бол тахир дутуу иргэдийн эрхийн зөрчил хаана илүүтэй гарч байгаа, энэ асуудаарх тахир дутуу иргэдийн санаа бодлыг тодруулах явдал байлаа.

Эл зорилгоор “**Тахир дутуу хүний ямар эрх илүү зөрчигдөж байна вэ?** Хэмээх асуултад нийт судалгаанд оролцсон тахир дутуу иргэдийн үнэлэмж баримжааллыг олонтаа давтагдсан хариултын хувилбаруудаар харуулая.

Хүснэгт 1.4

#### Тахир дутуу хүний эрхийн зөрчил, хувиар

	Хот	Хөдөө
Амьд явах	15	14.1
Хөдөлмөрлөх	58.5	59.9
Өмчлөх	8.9	5.3
Үзэл бодол, нийгмийн байдлаар ялгаварлах	32	6.8
Суралцах	23.4	3.2
Эмнэлгийн тусламж	28.3	4.6
Хуулийн өмнө адил тэгш байх	15.2	2.3
Халдашгүй чөлөөтэй байх	8.9	0.2
Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх	12.1	0.2
Соёл, угсаагаа дээдлэх	1.3	2.6
Сонгох сонгогдох	3.1	0.1
Оршин суух газраа чөлөөтэй сонгох	9.7	0.1
Шүтэх	-	0.1
Эвлэлдэн нэгдэх	0.8	0.2
Тайван жагсаал цуглаан хийх	1.3	0.2

Хүснэгтээс харахад **тахир дутуу иргэдийн хөдөлмөрлөх эрх** хамгийн ихээр зөрчигдөж байгаа нь ажиглагдлаа. Хөдөөд ч энэ байдал давтагдаж байна. Түүнчлэн үзэл бодол, нийгмийн байдлаар ялгаварлан гадуурхах хандлага хотод их байдаг нь жирийн иргэд тахир дутуу иргэдийн талаарх ямархуу үнэлэмж, бодол сэтгэгдэлтэй байдгийн нэг илрэл болж байна. Олон нийтийн дунд тахир дутуу иргэдийг жирийн иргэдээс ялгадаг, ямар нэгэн байдлаар дутуу, өрөөсгөл гэж үзэх хандлага түгээмэл байгааг харуулж байна.

Ялангуяа хөдөлмөрлөх эрхийг тахир дутуугийн хэлбэртэй харьцуулж үзэхэд бие бялдрын, хэл ярианы согогтой хүмүүст илүүтэй тохиолддог нь нийт судалгаанд оролцогчдын 66%-ийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх зөрчигдөж байгааг тайлбарлахдаа эмнэлгийн үйлчилгээний төлбөр, эмний үнэ өндөр гэдгээр илэрхийлж байлаа.

Судалгааны дүнгээс ажиглагдсан нэг зүйл бол тахир дутуу иргэдийн “Амьд явах” эрх зөрчигдөж байна гэдэг хариултыг судалгаанд хамрагдсан 15 хүн тутмын нэг нь өгч байсан. Үүний шалтгаан, юу нөлөөлж буйг, яагаад ингэж үзэхэд хүргэж байгааг гүнзгийрүүлэн судлах шаардлага байна гэдэг дүгнэлтийг хийхэд хүргэж байна.

Тахир дутуу иргэд эдийн засгийн чадваргүй, ажлын чадвараа алдсан байдал нь тэдний амьдрал ахуйд нөлөөлөв үү, нөгөө талаас тахир дутуу иргэдийн эрх ашиг ноцтой зөрчигдөж буй бусад шалтгаан, өвчлөлийн хүндрэлээс үү, сэтгэл санааны дарамт болоод сэтгэцийн хямралд орж байгаагаас уу гэх мэт асуудлыг тодруулан судлах шаардлагатай байна.

### Жишээ 1.

*Иргэн Мааяа сэтгэцийн өвчтэй, харж хандах хүнгүй ганц биерээрээ амьдардаг байсан. Нийгмийн халамжийн тэтгэмж 12.000 төгрөг авдаг, ажил эрхэлдэггүй, өөрийн орон гээгүй, хамаатныхаа гэрт амьдардаг. Саяхан өвчний улмаас нас барсан. Энэ эмэгтэй ЭМД-д ороогүй, даатгалын мөнгө төлөх чадваргүй. Нас барахад нь оршуулгын зардал олдоогүй учир нь улсад ажилласан жил байхгүй, хууль ч ажил эрхэлж байсан хүнд оршуулгын зардал олгоно гэсэн заалттай байдаг юм байна.*

(Чингэлтэй дүүрэг, 18-р хорооны нийгмийн ажилтан Лутсайхан)

Энэ байдлыг улам тодруулах үүднээс тахир дутуу хүний хувьд тохиолдож буй бэрхшээлийг тандахад дараах байдлаар хариулжээ.

Үүнд:

- Орлого бага, ажилд авахаас цааргалах хандлага (61.1%)
- Өөрийн гэсэн орон байргүй (18.9%)
- Тахир дутуу хүнийг ойлгох нийгмийн сэтгэл зүй бүрдээгүй, хамт олны дэмжлэг сул (12.%)
- Сурч боловсрох, мэргэжил эзэмшихэд (4.5%)
- Хуулийн хэрэгжилт тааруу (3.4%)

Өнөөгийн зах зээлийн харилцааны нөхцөлд тахир дутуу иргэдийг ажлаар хангах бололцоо улам хумигдаж байгаа бөгөөд энэ нь тэдэнд зориулсан ажлын тусгай байр өндөр өртгөөр босдог, ажил олгогч нарын зүгээс тахир дутуу иргэдийг хөдөлмөрийн бүтээмж муу гэдгээр ажилд авахыг хүсдэггүй зэрэг олон шалтгаануудтай холбоотой.


Ер нь асуудал бүрт тахир дутуу иргэдийн ажил эрхлэх байдал туйлын хангалтгүй байгааг илтгэсэн үзүүлэлтүүд өндөр давтамжтайгаар гарч байгаа ба үүнээс улбаатай тахир дутуу иргэдийн нийгмийн бусад асуудал шууд хамааралтайгаар доройтоход хүргэж байна.

Тахир дутуу хүний эрх ямар байгууллагын хүрээнд зөрчигдөж байгааг зураг 2-т харуулав.

УИМН  
СУДАЛГААНЫ САН

Зураг 2.1

Тахир дутуу хүний эрх зөрчигдөж буй байдал, байгууллагаар, хотоор



Хөдөөд тахир дутуу иргэдийн эрхийн зөрчил аль хүрээнд илүүтэй тохиолдож байгааг зураг 2.2-оор үзүүлэв.

**Жишээ 2.**

Би дүүргийн ЭМН-ийн хяналтанд байдаг. Анх групп 60%-иар тогтоолгосон. Гэтэл эмнэлгийн хурлаар хасагдаад 55 болсон. Намайг бараг өвдөх зовиурлах юмгүй эрүүл байна гэдэг. Гэтэл би байнга эмтэйгээ явдаг. Халамжаас тусдамж аюч байгаагүй. Нэг удаа түлээ нүүрс авъя гээд очиход хэсгийн дарга хуулинд нас заасан чи залуу хүн тул олгохгүй гэж хэлсэн. Манай гэр бүлийн хүн уушгины дэлбээгээ тайруулаад группэд орсон. Гэтэл хөдөө яваад иртэл группээс хассан байсан. Дахин сэргээх эсэхийг нь мэдэхгүй байна. Би өөрөө хүнд ажил хийж болохгүй. Халамжийн тэтгэмж хаанаа ч хүрдэггүй (Налайх дүүрэг, 3-р хороо, 32 настай эмэгтэй)

Зураг 2.2.

Тахир дутуу хүний эрх зөрчигдөж буй байдал, байгууллагаар, хөдөөгөөр



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Судалгаанаас харахад хотод тахир дутуу хүний эрх хувийн сектор, улсын үйлдвэрийн газар, байгууллагад илүүтэй зөрчигдөж байхад хөдөөд төрийн захиргааны байгууллага, улсын үйлдвэр аж ахуйн газар илүүтэй зөрчигдөж байна.

Хэдийгээр тахир дутуу иргэдэд хандах төр, нийгэм, хамт олны хандлага эерэг боловч тэдний ажил эрхэлж буй гол гол салбаруудад эрхийн зөрчил илүүтэй байгаа нь анхаарал татсан судлах шаардлагатай бас нэг асуудал болон дэвшигдэж байна. Зарим тахир дутуу иргэд, тэдэнтэй ажилладаг нийгмийн ажилтан нарын үзсэнээр цалин хөлс бага олгох/энэ нь хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой/, богино цагаар олгох, орон байр, болон бусад зардлыг нь байгууллагаас нь хөнгөлж байх ёстой хуулийн заалтыг мөрдөж ажилладаггүйтэй холбон тайлбарлаж байлаа. Ялангуяа ийм үзэгдэл хувийн хэвшлийн байгууллагуудад нийтлэг үзэгдэл болжээ.

Түүнчлэн цөөнгүй тохиолдолд нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчиход, хамт олон, гэр бүлийн хүрээнд тахир дутуу иргэдийн эрх зөрчигддөг болох нь энэхүү судалгаагаар илэрч байгаа юм.

## 2.2. Тахир дутуу иргэдийн эрх зөрчигдөхөд нөлөөлж буй хүчин зүйл

Тахир дутуу иргэдийн эрх зөрчигдөхөд олон хүчин зүйл, шалтгаан байгаа нь тодорхой. Энэ талаар тахир дутуу иргэдийн ойлголт төсөөллийг тодруулахыг эрмэлзлээ. Судалгаанд оролцогчдын үзсэнээр төрийн бодлого, шийдвэр амьдралд хэрэгждэггүйгээс 9.3%, тахир дутуу хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрэлдээгүйгээс 35.5%, эдийн засгийн тогтворгүй байдлаас 34.4%, эмнэлгийн үйлчилгээ тааруугаас 1.2%, иргэдийн хууль эрхийн мэдлэг боловсрол хомс тул 23.5%, тахир дутуу хүнийг ялгаварлан үздэг хандлага нийгэмд түгээмэл байгаагаас 37.3%, ажилгүйдэл, гэмт хэрэг, ядуурал гэх мэт нийгмийн сөрөг үзэгдлүүдээс болдог 30.2% тус тус үзжээ.

Хөдөөд 35.6% нь тахир дутуу хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрэлдээгүй, 35.4% эдийн засгийн тогтворгүй байдалтай холбон тахир дутуу хүний эрх зөрчигдөхөд хүргэдэг гол хүчин зүйлд тооцон үзжээ.

Судалгааны дүнгээс нийтлэг ажиглагдаж буй үндэслэл нь **тахир дутуу хүний эрх, нийгмийн хамгааллын асуудлаарх эрх зүйн орчин хангалттай бус байгаа явдал** нь тахир дутуу иргэдийн эрх зөрчигдөхөд нөлөөлж байгаа хүчин зүйл болж байгаа юм байна.

Тахир дутуу гэдгээр ялгаварлах үзэгдэл нийгэмд, хамт олонд, гэр бүлийн орчинд тохиолддог болох нь өмнөх судалгааны асуулгуудаас тодорхой харагдсан билээ. Энэ асуудлыг улам бүр тодруулах үүднээс “Тахир дутуу гэдгээр аль нэг албан тушаалтан ялгаварлах нь танд болон таны адил бусад хүмүүст тохиолдог уу” хэмээхэд нийт судалгаанд оролцогчдын 43.3% нь тохиолддог, 43.8 нь үгүй, үлдсэн хувь нь хариулт өгөөгүй байв. Хөдөөд ялгаварлах үзэл хандлага хоттой харьцуулахад бага байгаа нь судалгаанд оролцогчдын 60.8% нь үгүй гэж хариулснаас мэдрэгдэж байна.

### Жишээ 3.

*Үйлдвэрлэлийн ослоор тахир дутуу болсон хүмүүст өмнөх ажил олгогч нь нөхөн олговор төлдөггүй. Би зээл тусламж авах арга замаа мэддэггүй. Барьцаалах хөрөнгө байхгүй. Мөн хүүхдээс төлбөрийн зөрүү нэхээд сургуулиас нь хөөхөд хүрээд байна. 21%-ийн шимтгэлтэйгээр халамжийн тэтгэврийг 3 сараар урьдчилан олгож байна.*

(Баянзүрх дүүрэг, 54 настай эрэгтэй)

### 2.3. Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын хүртээмж

Тахир дутуу хүнд үзүүлэх нийгмийн хамгааллын хүртээмжийн асуудал нь төр засгаас зориуд анхаарах нийгмийн бүлэглэл гэдэг утгаараа ач холбогдлын хувьд өндөр байх ёстой юм.

Бодит амьдрал дээр тахир дутуу иргэдийн энэхүү эрхээ эдлэх, нийгмийн хамгаалал, халамж хүртэх байгаа эсэх, нийгмийн халамж, үйлчилгээ хүртэхэд тохиолдож буй бэрхшээлийг судлахад уг судалгаа судалгааны зорилтууддаа тусгасан билээ.

Энэхүү судалгаанд хамрагдсан тахир дутуу иргэдийн (хотод)53.5% нь, хөдөөд (57.6%) нь нийгмийн халамж хүртдэг гэж хариулсан явдал. Өөрөөр хэлбэл тахир дутуу 3 хүн тутмын 2 шахам нь ямар нэгэн байдлаар нийгмийн халамж, үйлчилгээ хүртдэг гэсэн үг.

Гэвч судалгаанд хамрагдсан тахир дутуу иргэдийн үзэж байгаагаар нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээ бага, өнөөгийн зах зээлийн харилцаанд амьдралын наад захын эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгааг дурьдаж байсныг хэлэх нь зүйтэй болов уу.

Тахир дутуу иргэдийн нийгмийн халамж, үйлчилгээ хүртэхэд тулгарч буй гол бэрхшээлүүдэд дараах зүйлсийг судалгаанд оролцогчид нэрлэсэн явдал. Үүнд:

- Халамжийн байгууллагын ажилтнууд хайхрамжгүй ханддаг (16.3%)
- Аливаа тусламж дэмжлэгийг танил талаараа шийддэг (11.8%)
- Хаана, хэнд хандахаа мэддэггүй (34.6%)
- Хөөцөлдөж явах бололцоо байдаггүй (19.4%)
- Бусад шалтгаан (17.8%) тус тус үзжээ.

Бусад шалтгаан гэдэгт мэдэхгүй буюу надад ийм шаардлага гардаггүй гэж үзсэн респондентууд болж байна.

Түүнчлэн хөдөөд төрөөс тахир дутуу иргэдийг дэмждэг хэмээн судалгаанд оролцогчдын 51.6% нь үзснээс харахад төрөөс тахир дутуу иргэдэд үзүүлдэг нийгмийн халамжийн тэтгэвэр, нийтийн тээврийн хөнгөлөлт зэргийг хамтад тооцож үздэгтэй холбоотой байх талтай.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

#### Жишээ 4

Тахир дутуу иргэдэд цогц хууль хэрэгтэй байна. Одоо хэрэгжиж байгаа нийгмийн даатгалын хууль, нийгмийн халамжийн хуулиар тахир дутуу хүний асуудлыг зохицуулдаг боловч энэ нь амьдралд хэрэгждэггүй.

Сонгинохайрхан дүүрэг, 43 настай эмэгтэй

Судалгаанаас харахад тахир дутуу иргэд эрхээ эдэлж нийгмийн халамж хүртэхэд мэдлэг мэдээллийн хүртээмжийн хомсдол ихээхэн сөргөөр нөлөөлдөг болох нь ажигдагдаж байна. Хоёрдугаарт тахир дутуу иргэд нийгмийн халамж хүртэхийг хүсдэг ч түүний гэр бүл, хамаатан садан, найз нөхөд, хамт олны зүгээс тэр болгон тусалдаггүй зөвхөн хувь хүний асуудал гэж хүнийсгэн үздэг нийгмийн сэтгэл зүй хүчтэй оршдгийг илтгэж байна.

#### Гуравдугаар хэсэг: Тахир дутуу хүний эрх, нийгмийн байдлыг сайжруулах арга зам


##### 3.1. Тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалах байгууллага

Судалгааны өмнөх хэсэгт тахир дутуу хүний эрхийн төлөв байдал, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг авч үзсэн билээ.

Судалгааны гуравдахь хэсэгт тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалах тогтолцооны асуудал зайлшгүй хөндөгдөх ёстой болж байгаа юм.

Эл зорилтын хүрээнд **“Таны эрхийг сэргээн хамгаалахад ямар байгууллага илүү чухал үүрэгтэй вэ? Хэрэв ийм байдал тохиолдвол Та хаана хандах вэ”** гэсэн асуултад хариулсныг зураг 3.1-ээр үзүүлье.

Зураг 3.1



Хөдөө орон нутагт тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалахад хамгийн ихээр итгэл хүлээлгэдэг байгууллагуудыг дараах байдлаар илэрхийлжээ. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комисс (28.2%)
- Тахир дутуу иргэдийг эрхийг хамгаалдаг ТББ (23.1%)
- Төрийн байгууллагууд (18.3%)
- Шүүхэд (16.4)
- Цагдаа, ИТХ (11%) тус тус хариулсан байна.

Судалгаанаас харахад хот хөдөөгөөр ялгаатай үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд хотод шүүх, төрийн захиргааны байгууллагыг сонгосон байхад хөдөөд хүний эрхий үндэсний комисс, ТББ-уудыг тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалахад чухал үүрэгтэйд тооцсон байна.

Тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалахад хамгийн бага хувийг хот хөдөөд аль алинд нь иргэдийн төлөөлөгчдийн хурал болж байна.

### **3.2. Тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох нь**

Тахир дутуу иргэдийн эрх, нийгмийн хамгааллын талаарх өнөөгийн тогтолцоог сайжруулахад юуны өмнө хууль эрх зүйн орчныг эргэж харах, шаардлагатай бол холбогдох чиглэлийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах гэх зэргээр төрийн бодлогыг тодорхой, бодит амьдрал дээр хэрэгжихүйц хэмжээнд өөрчлөх нь зүй ёсны асуудал болон дэвшигдэж байна.

Тахир дутуу иргэдийн эрх, нийгмийн хамгааллын асуудал нь төр засгийн анхаарлын гадна орших ёсгүй асуудал.

Энэ талаарх тахир дутуу иргэдийн санал бодлыг тандан судлах зорилгоор одоо мөрдөгдөж буй тахир дутуу иргэдийн эрх ашигтай холбоотой ямар хуулийн, ямар заалтад өөрчлөлт оруулах саналтайг сонирхоход нийт судалгаанд оролцсон респондентуудын 31.8% нь санал оруулах, өөрчлөх сонирхол, үнэлэмж баримжаалалтай байхад үлдсэн хэсэг нь үгүй буюу мэдэхгүй гэж хариулсан явдал.

Хөдөөд энэ асуудалд туйлын хангалтгүй хариулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 73.9% нь огт хариулт өгөөгүй байлаа. Энэ нь мэдээлэл цуглуулах шатны ажилд мэдээлэл цуглуулагчид хайхрамжгүй хандсаных уу, эсвэл тахир дутуу иргэд санал бодлоо илэрхийлж чадаагүйх үү гэдгийг танихад бэрхшээлтэй байсан болно.

Тахир дутуу иргэдийн эрх ашигтай холбоотой асуудлаар саналыг тодруулахдаа задгай асуултын хэлбэрээр хариулт авсан бөгөөд энэхүү хариултуудыг багцлан хот хөдөөгөөр үзүүлье

### Хүснэгт 3.1

#### Тахир дутуу иргэдийн санал бодол

	Хот	Хөдөө
Хуулийн орчныг сайжруулах	<b>10.5</b>	<b>8.5</b>
Төрийн захиргааны байгууллагын хүнд суртал	2.1	0.8
Төрөл бүрийн хөнгөлөлт	3.1	3.7
Ажилд орох боломж	4.2	1.8
Сургалт, мэдээлэл	1.8	1.1
Зээл, тусламж, төсөлд хамрагдах	3.1	3.0
Бусад	7.6	5.5
Хариулт өгөөгүй	67.5	76.6

Хүснэгтээс харахад судалгаанд оролцсон 3 хүн тутмын 1 нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахыг чухалчлан үзсэнд оршиж байна.

Үүнд :

#### **Хуулийн орчныг сайжруулах гэдэгт:**

- Нийгмийн халамжийн тухай хуулинд нэн ядуу гэсэн заалт оруулах
- Тахир дутуу хүүхдийг асран хамгаалагчдад тэтгэмж олгох
- Хуулийн 111-р зүйлд 50 дээш бус 30-дээш гэсэн заалт оруулах
- Тахир дутуу иргэдийн эрх ашгийг хөндсөн цогц хуультай болох
- Хараагүй хүүхдэд зориулсан хуультай болох
- Тахир дутуу хүний нийгмийн халамжийн тухай хуулийн 11-р заалтад 1 хүнд гэснийг хасах
- Тахир дутуу хүний хөдөлмөрийн чадвар тогтоох журамд өөрчлөлт оруулах
- Тахир дутуу иргэдийн утас, цахилгааны төлбөрийг хөнгөлөх заалт хэрэгжихгүй байна
- Хуулинд тахир дутуу иргэд улсын үйлдвэр, аж ахуйн газар хөдөлмөр эрхлэх асуудлыг нээлттэй болгох асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах
- Тахир дутуу иргэдэд хэрэгцээтэй хуулийг сурталчлах, гэгээрүүлэх гэх мэт тодорхой саналуудыг гарган дэвшүүлжээ.

*Тахир дутуу хүний хөдөлмөр эрхлэхтэй холбогдсон Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийг боловсронгуй болгох. Жишээ нь 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж байгууллага гэдгийг 25 ба түүнээс дээш гэж оруулах санал байна.*

#### **Төрийн захиргааны байгууллагын хүнд суртал**

- Бичиг баримт бүрдүүлэх гэх мэтээр цаг хугацаа их бардаг, чирэгдүүлдэг
- Тахир дутуу иргэдийн ажлын цагийг багасгах
- ТББ-ууд хүндээ хүрч ажиллах

#### **Төрөл бүрийн хөнгөлөлт**

- Микроавтобусанд хөнгөлттэй зорчих
- Хараагүй хүнд байрны хөнгөлөлт үзүүлэх



- Татварын талаар тахир дутуу жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлт үзүүлэх

#### **Ажилд орох боломж**

- Тахир дутуу хүмүүст тохирсон ажлын байраар хангах
- Ямар нэгэн байгууллагад албан тоотоор ажилд оруулдаг байх

#### **Сургалт, боловсрол, мэдээлэл**

- Тархины гажигтай хүүхдэд боловсрол олгох
- Тахир дутуу хүүхдийг сургуулиас завсардуулахгүй байх
- Тахир дутуу иргэдэд хууль эрх зүйн талаар мэдээлэл өгөх

#### **Зээл, төсөл, эрүүл мэндийн үйчилгээ, амралт сувилалд хамрагдах**

- Тахир дутуу иргэдийг тоног төхөөрөмжөөр хангах

**Бусад** гэдэгт их төлөв тахир дутуу иргэдийн тэтгэмжийг нэмэх, тэтгэмж авч байсан улсад ажил эрхэлж байгаагүй тахир дутуу иргэдийг нас барсан тохиолдолд тусламж үзүүлж байх гэх зэргээр тодруулан тайлбарлажээ.

Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллыг хөндсөн энэхүү асуудалд нийт судалгаанд оролцогчдын гуравны хоёр шахам нь хариулт өгөөгүй болно.

Шинжилгээний нэгж нь тахир дутуу иргэд байсан нь мэдээлэл авагчаас тахир дутуу иргэдээс хангалттай мэдээлэл авахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч байсныг харуулж байна. Гэвч судалгаагаар тахир дутуу иргэдэд хуримтлагдсан эрхийн болоод нийгмийн халамж үйлчилгээний олон асуудал байгаа нь өмнөх хэсгүүдээс тодорхой харагдсан.

Дээрх судалгааны баримт сэлтэд дүн шинжилгээ хийж үзвэл хот хөдөөд аль алинд нь тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж нэн тулгамдсан асуудал болоод байгаа бөгөөд дараах эрхүүдийн хэрэгжилтийг төр болон ТББ-уудын оролцоотойгоор бодит амьдралд хянаж, үнэлгээ шинжилгээ хийх хэрэгцээ байгааг илтгэж байна

- Хөдөлмөрлөх эрх
- Боловсрол эзэмших эрх
- Эмчилгээ үйлчилгээ хүртэх эрх
- Өмчлөх эрх /байр орон сууц, тоног төхөөрөмжтэй байх/

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## Дүгнэлт, зөвлөмж

“Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгаалал” сэдэвт судалгааны ажлыг Улаанбаатар хотын 7 дүүрэг, орон нутгийн 14 аймгийг хамруулан явууллаа. Судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтийг дэвшүүлж байна.

- Энэхүү судалгаанд хот хөдөөгийн 856 тахир дутуу иргэд оролцсон бөгөөд албан ёсны статистикийн тооллуулсан тахир дутуу иргэдийн 0.5-10 хувьтай тэнцэх тооны тахир дутуу иргэдийг хамруулсан тул түүврийн бүтцийн хангалттай төлөөлөл болсон гэж үзэж байна.
- Судалгаанд тахир дутуу иргэд гэдэг ойлголтыг хэрэглэхдээ ДЭБМ, МУ-ын үндсэн хууль болон холбогдох чиглэлийн заасанчилан “бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэл ярианы болон бие эрхтний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлтэй болох нь тогтоогдсон монгол улсын иргэнийг тооцож тахир дутуу иргэнл хамруулан судалгаанд оролцууллаа.
- Судалгааны зорилго, ач холбогдолтой уялдан нийгмийн судалгааны уламжлалт аргуудын нэг болох санал асуулга, хоёрдогч эх үүсвэрийн статистик мэдээллийг ашиглав.
- Улаанбаатар хотын судалгаанд оролцсон тахир дутуу иргэдийн 52.1% нь эрэгтэй, хөдөөгийн оролцогчдын 49.7% нь эрэгтэйчүүд тус тус эзэлж байгаа бөгөөд 43.0% нь нийгмийн халамжид 14.0% нь хөдөлмөрийн чадвараа 80 хувь алдсан, 11.6% нь ажилгүй, 11.3% нь тэтгэвэрт, үлдсэн хэсэг нь төрийн болон хувийн хэвшилд ажил эрхэлдэг байна.
- Хөдөөгийн судалгаанд хамрагчдагчдын 27.1% нь ажилгүй, 23.1% нь хөдөлмөрийн чадвараа 70 хувь алдсан, 14.5% нь тэтгэвэр тэтгэмжид үлдсэн хувь нь л хөдөлмөр эрхэлдэг байна.
- Судалгаанаас харахад хөдөөд тахир дутуу иргэд хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл тааруу байгаа нь харагдлаа.(59.9%)
- Судалгаанд оролцогчдын Уулаанбаатар) өрхийн орлогын дийлэнх хувийг буюу 44.4 хувийг тэтгэмж эзэлж байна.
- Тахир дутуу иргэдийн хөдөлмөрлөх эрх (58.1%)хамгийн ихээр зөрчигдөж байгаа нь судалгааны дүнгээс тодорхой харагдлаа. Ялангуяа хөдөлмөрлөх эрхийг тахир дутуугийн хэлбэртэй харьцуулж үзэхэд бие бялдын, хэл ярианы согогтой хүмүүст илүүтэй тохиолддог нь нийт судалгаанд оролцогчдын 66%-ийг эзэлж байгаагаас харагдаж байна.
- Тахир дутуу хүний эрх хувийн сектор (39.99), улсын үйлдвэрийн газар, байгууллагад илүүтэй зөрчигдөж байхад хөдөөд төрийн захиргааны байгууллага(20.4%), улсын үйлдвэр аж ахуйн газар(17.1%) илүүтэй зөрчигдөж байна.

- Судалгаанд оролцогчдын үзсэнээр төрийн бодлого, шийдвэр амьдралд хэрэгждэггүйгээс 51%, тахир дутуу хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрэлдээгүйгээс 44.9%, хөдөөд 35.5% нь тахир дутуу хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй, 34.5% эдийн засгийн тогтворгүй байдалтай холбон тахир дутуу хүний эрх зөрчигдөхөд хүргэдэг гол хүчин зүйлд тооцон үзжээ.

Судалгааны дүнгээс нийтлэг ажиглагдаж буй үндэслэл нь **тахир дутуу хүний эрх, нийгмийн хамгааллын асуудлаарх эрх зүйн орчин хангалттай бус байгаа явдал** нь тахир дутуу иргэдийн эрх зөрчигдөхөд нөлөөлж гэж үзэхэд хүргэж байгаа юм байна.

- “Тахир дутуу гэдгээр аль нэг албан тушаалтан ялгаварлах нь үзэгдэл нь тохиолддог 40.1% нь үзжээ. Хөдөөд ялгаварлах үзэл хандлага хоттой харьцуулахад бага байгаа нь судалгаанд оролцогчдын 60.8% нь үгүй гэж үзснээс харагдаж байна.
- Тахир дутуу иргэдийн (хотод)52.6% нь, хөдөөд (57.6%) нь нийгмийн халамж хүртдэг гэж хариулсан нь 3 хүн тутмын 2 нь нийгмийн халамж, үйлчилгээ хүртдэг нь харагдлаа.
- Тахир дутуу иргэдийн нийгмийн халамж, үйлчилгээ хүртэхэд тулгарч буй гол бэрхшээл хаана, хэнд хандахаа мэддэггүй (34.5%) гэж хариулсан явдал.
- Тахир дутуу иргэдийн эрхийг сэргээн хамгаалахад хотод шүүх (21%), хөдөөд Хүний эрхийн үндэсний комисс (28.2%), Тахир дутуу иргэдийг эрхийг хамгаалдаг ТББ (23.1%) илүү үүрэгтэй гэж тахир дутуу иргэд үзжээ.
- Тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох асуудалд нь тахир дутуу иргэдийн эрх ашигтай холбоотой хуулиудад өөрчлөлт оруулахыг судалгаанд оролцогчдын оруулах 32% нь дэмжиж байгаа бөгөөд энэ нь судалгаанд оролцсон 3 хүн тутмын нэг нь болж байна.

## Зөвлөмж

1. Тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалсан хууль болон холбогдох чиглэлийн хуулийн зүйл заалтыг өнөөгийн зах зээлийн нийгмийн нөхцөл байдалд тохируулан өөрчлөлт оруулах, улмаар хуулийн орчин нөхцөл сайжирна гэж үзжээ
2. Тахир дутуу иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжоор хангах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр авсан арга хэмжээг бодит амьдрал дээр хэрэгжүүлэх (төрөл бүрийн хөнгөлөлтүүд)
3. Тахир дутуу иргэдийн амьдрал ахуйд туслах төрийн бодлого, нийгмийн хамгаалалд юуны өмнө тэдэнд зориулсан ажлын байр бий болгох, нийгэм хамт олны дунд амьдрах нийгэм сэтгэл зүйн орчин бүрдүүлэх
4. Тахир дутуу иргэдийн халамжийн тэтгэврийг зах зээлийн нийгмийн хэрэглээнд ойртуулах, нийцүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд нэмэгдүүлэх
5. Тахир дутуу иргэдийн боловсрол, мэдлэг мэдээлэл олж авах хэрэгцээг хангах зорилгоор эрүүл мэнд, сургалт мэдээллийн төвийг байгуулах
6. Тахир дутуу иргэд төр нийгмийн бодлогын анхаарлын төвд байх ёстой нийгмийн бүлэг тул эмчилгээ сувилалд хөнгөлттэй хамруулах, эмнэлгийн үйлчилгээний үнийг улсаас бүрэн хариуцах

**Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв  
болон нийгмийн хамгааллын байдалд сийсэн  
судалгааны урьдчилсан хураангуй дүнгийн  
тухай товч тайлан**

ХЭҮК-ын дарга, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, МТДИБҮХ-ны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу тус комисс, МТДИБҮХ, МТДЭХ-той хамтарч аймгуудын ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг дарга нарын оролцоо дэмжлэгтэйгээр 21 аймгийн зарим сумд, нийслэлийн налайх ба төвийн 6 дүүргийг хамруулан судалгаа тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал болон нийгмийн хамгааллын байдалд судалгаа хийж, НХХ-ын яам, БСШУ-ны яам, ЭМ-ийн яам, холбогдох агентлагууд, Нийслэлийн засаг даргын дэргэдэх зарим албад, тамгын газрын холбогдох хэлтэст танилцав.

Урьдчилсан байдлаар 18 аймаг, нийслэлийн 6 дүүрэг судалгаанд хамрагдаж судалгааны явцад нийтдээ 820 хүнээс тусгай хуудсаар асуумж авч нэгтгэн дүгнэв.

**Нэг. Судалгааны арга зүйн талаар**

Судалгааг ХЭҮК-ын гишүүд, ажилтнууд, судлаачид, МТДИБҮХ-ны болон МТИЭХ-ны ажилтнууд, аймаг, нийслэл дэх ХЭҮК-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчид, нийслэл, аймгуудын төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын ажилтнууд оролцож холбогдох газруудаас эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд, тайлан, судалгаа, зохиосон ажлын баримт мэдээлэл болон бусад холбогдох бүх баримт бичгүүдийг судлан шинжилж, тахир дутуу хүмүүстэй биечлэн уулзаж холбогдох ажилтнуудаас удирдамжид дурдсан зүйлүүдийн талаар танилцах замаар явуулав.

**Хоёр. Тахир дутуу хүний эрхийг  
хэрэгжүүлэх эрх зүйн орчин**

Монгол Улсын тахир дутуу иргэдийн талаар явуулах төрийн бодлого нь 1948 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганаар баталсан Тахир дутуу хүмүүст адил боломж олгох үндсэн зарчим, 1993 онд баталсан Тахир дутуу иргэдийн тэгш эрхийн тухай НҮБ-ын хэм хэмжээний дүрэм, 1983 онд ОУХБ-аас баталсан Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон мэргэжлийн нөхөн сэргээлтийн тухай 159 дүгээр конвенц, Ази номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос 1993-2002 оныг Ази-Номхон далайн бүс нутгийн тахир дутуу иргэдийн 10 жил болгон тунхагласан шийдвэрүүд зэрэг НҮБ-ын бага хурлууд болон дээд хэмжээний уулзалтуудын үзэл санаа, тахир дутуу иргэдийн

аж байдлаг дээшлүүлэх талаар олон улсын хэмжээнд зөвшөлцсөн үндсэн зарчмуудад тулгуурлан хэрэгжиж байна.

Тахир дутуу иргэдийн талаар гарсан төрийн бодлого, шийдвэр, тэднийг нийгмийн амьдралд оролцуулах, амьдралын баталгааг хангах асуудлууд нь Монгол Улсын Үндсэн хууль, “Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай”, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Нийгмийн халамжийн тухай хууль”-иуд болон 1998 онд Засгийн газраас баталсан “Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, 2002 оны 7 дугаар сард баталсан “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын тушаал, шийдвэр, дүрэм, журам зэрэг хууль зүйн актуудад тусгалаа олж хэрэгжиж байна.

Ялангуяа тахир дутуу иргэдийн аж байдал, боловсролыг дээшлүүлэх замаар нийгмийн амьдралд тахир дутуу иргэд эрүүл хүмүүсийн нэгэн адил тэгш эрхтэйгээр оролцох бололцоог хангах нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, . . . эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлон байгуулах нэг гол зорилт гэж үзэж тахир дутуу иргэдэд, нийгмийн хамгааллын чиглэлийн багц хуулиудаар тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, сэргээн засалтын үйлчилгээ үзүүлж байгаагийн зэрэгцээ доорх бусад хуулиудад хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлж адил тэгш эрх эдлэх боломжийг хуульчлан баталгаажуулж өгсөн болно. Үүнд:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулиар тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгслийг үйлдвэрлэх болон импортолж борлуулсан тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;
2. Гаалийн тарифийн тухай хуулиар тахир дутуу хүнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, түүхий эд, хүмүүнлэгийн буюу буцалтгүй туслажийн барааг гаалийн татвараас чөлөөлөх;
3. Боловсролын тухай хуулинд зааснаар Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх бөгөөд иргэдэд сурч боловсроход нь адил тэгш эрх эдлүүлэх, суралцагчид суралцах нөхцөл бололцоогоор хангуулах зэрэг эрхээр хангагдсан байх;
4. Дээд боловсролын тухай хуулинд тахир дутуу суралцагчдад буцалтгүй тусламж, сургалтын төлбөрт зориулан хөнгөлөлттэй зээл олгох;
5. Хөдөлмөрийн тухай хуульд ажил үйлчилгээний онцлогт харшлахгүй тохиолдолд 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа 3, түүнээс орон дээш тоонд тахир дутуу буюу одой хүнийг ажиллуулах, хэрэв ажиллуулаагүй бол ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлбөр төлж, энэхүү төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн уг хөрөнгийг тахир дутуу буюу одой хүнд зориулах нийгмийн

хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэхээр заасны дагуу хэрэгжүүлж байна.

Энэ мэтээр Монгол оронд тахир дутуу иргэдийн тэгш эрхийг хангах, нийгмийн амьдралд татан оролцуулах, хөдөлмөр эрхлүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн баталгааг хангах талаар хууль эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн гэж үзэж болохоор байна.

**Гурав. Тахир дутуу хүний эрхийн  
төлөв байдал, нийгмийн хамгааллын анхаарал  
татсан, тулгамдсан асуудал**

Тахир дутуу хүмүүсийн эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллын тухай асуудал нь хууль тогтоомжийн заалт, тахир дутуу хүний талаарх олон улсын хүний эрхийн үндсэн зарчимын хүрээнд хэрэгжих шатанд ямар дутагдал, бэрхшээл байгаатай холбон авч үзье.

1. Тахир дутуу хүний хэвийн аятай нөхцөлд амьдрах, хөдөлмөрлөх, сурч боловдох асуудалд улс орны хэмжээнд санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээл, ажилгүйдэл, ядуурал ихэссээр байгаа явдал ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа нь илт байна.

Энэ хүндрэл, бэрхшээлээс үүдэн тахир дутуу хүмүүсийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж, хөнгөлөлт үйлчилгээг хүртээмтэй болгож, хөдөлмөрлөх чадвартай тахир дутуу иргэдийг ажлын байраар хангаж чадахгүй байна.

Тиймээс ч хөдөлмөрлөх чадвартай тахир дутуу иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-д “ажил үйлчилгээний онцлогт харшлахгүй тохиолдолд 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа 3, түүнээс орон тоонд тахир дутуу буюу одой хүнийг ажиллуулна”, 111.2-д “аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” гэж заасан байдаг.

Энэ заалтыг төв, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа зарим үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хангалтгүй биелүүлж байна.

Тухайлбал Дорнод аймагт 50 ба түүнээс дээш ажилтантай 16 аж ахуйн нэгж, байгууллага тахир дутуу иргэдийг авч ажиллуулаагүй бөгөөд түүнийгээ төлөө улсын төсөвт төлөх ёстой 29,836,5 мянган төгрөгийн төлбөрийг төлөөгүй байна. (Дорнод аймагт хийсэн судалгааны материалаас)

2. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар аймаг нийслэлийн засаг дарга нар тахир дутуу хүмүүсийн нийгмийн хамгааллын талаар орон нутгийн хэмжээнд авах арга хэмжээний талаар асуудал боловсруулж ИТХ-д оруулах, энэ тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах арга

хэмжээг авах, тахир дутуу хүмүүсийг нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэр гаргахаар заасан.

Энэ заалтын дагуу тахир дутуу хүнийг нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэр гаргаж хэрэгжүүлэх ажил нийслэлийн болон ихэнх аймгийн хэмжээнд үндсэндээ хэрэгжиж байгаа юм байна. Харин нийт аймгуудын дөнгөж 20 орчим хувь нь сүүлийн 2 жилд тахир дутуу хүний нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээний асуудал боловсруулж ИТХ-д оруулж хэлэлцүүлсэн, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авсан байна. Судалгааны дүнгээс үзвэл: төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд тахир дутуу хүмүүсийн талаар явуулах бодлого, хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тэдэнд олгож буй тэтгэвэр, тэтгэмж, бага хэмжээний хөнгөлөлт, тусламж үзүүлснээр хязгаарлагдаж санаа нь амардаг гэж үзэж болохоор байна.

Тахир дутуу хүмүүст үзүүлж буй дээрх тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ нь тэдний өдөр тутмын амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй байна.

3. Мөн хуулийн 5 дугаар “зүйлд өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид ажиллаж байгаад тахир дутуу болсон хүмүүстээ байнга анхааран халамжилж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, орон сууцтай болоход нь туслах арга хэмжээ авна” гэж заасан.

Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд тахир дутуу хүмүүст тэтгэмж тусламж үзүүлж байдгийн зэрэгцээ орон гэргүй тахир дутуу хүмүүст нийслэлийн хэмжээнд 42 гэр, 7 аймаг 25 гэр, 5 аймаг 11 хүнд орон сууц тус тус олгосон. Мөн Орхон аймгийн “Уулын баяжуулах Эрдэнэт” зэрэг цөөн газар тахир дутуу хүндээ орон сууц авахад нь тусалсныг эс тооцвол судалгаанд хамрагдсан газруудаас ажиллаж байгаад тахир дутуу болсон хүмүүстээ гэр, орон сууц олгосон буюу гэр, орон сууцтай болоход нь тусалсан аж ахуйн нэгж, байгууллага байхгүй байна. Хэсэгчилсэн судалгаагаар нийслэлийн зарим дүүрэгт болон 12 аймагт орон сууцгүй буюу орон гэргүй тахир дутуу айл өрх 553 байна.

4. Мөн хуулийн 9.1-д “тахир дутуу хүн ажиллах чадвар, мэргэжил, бололцоондоо тулгуурлан хөдөлмөр, үйлчилгээ эрхлэхэд төрийн зүгээс бүх талын дэмжлэг үзүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөрлөх чадвартай тахир дутуу хүнд мэргэжил олгож, хөдөлмөр эрхлэлтийн газрын шугмаар 3300 хүнийг ажилд зуучлан оруулж, хэсэгчилсэн судалгаагаар хөдөлмөрлөх чадвартай тахир дутуу 7100 хүн хөдөлмөр эрхэлж, одоо 14300 хүн ажил олдохгүй учир ажилгүй байна.

Олон улсын болон гадаад улс орны хандив, тусламж, төслийн хүрээнд 579 хүнд аж ахуй эрхлэхэд нь зориулж зээл олгосон байна.

Тахир дутуу иргэдийг аж ахуйн нэгж байгуулан ажиллахад нь бүх талаар дэмжлэг тусалцаа үзүүлдэг байгууллагууд цөөнгүй байна.



Жишээ нь: Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг болон тус эмнэлгийн дарга Золбоот нь тахир дутуу иргэдийн байгууллагад үйл ажиллагаа явуулахад нь эмнэлгийнхээ подвалыг 2005 он хүртэл үнэ төлбөргүйгээр эзэмших зөвшөөрөл олгосон байна. (Дархан-Уул аймгийн судалгааны материалаас)

Дархан-Уул аймгийн “Монгол алт” ХХК, Дулааны шугам сүлжээний газар, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх Монгол Гонконгийн хамтарсан “Вейл-Трейд” ХХК нь ажиллагсдынхаа 12,5 хувьд тахир дутуу иргэд ажиллуулж байгаа зэрэг тахир дутуу хүмүүст хүмүүнлэг сэтгэлээр ханддаг газрууд цөөнгүй байна.

Гэтэл төрийн захиргааны байгууллагын зүгээс хөдөлмөрийн чадвартай тахир дутуу хүмүүсийг дэмжих, тэдэнд аж ахуй эрхлэхэд нь хөрөнгийн ямар туслалцааг хэрхэн яаж үзүүлэхийг тодорхой хуульчлаагүйгээс тахир дутуу иргэдэд аж ахуй эрхлэхэд багагүй саад учирч байна. Тахир дутуу хүмүүс ихэвчлэн нэн ядуу, ядуувтар амьдралтай байдаг учир тэдэнд зээлийн барьцаанд тавих хөрөнгө байдаггүй байна.

5. Мөн хуулийн 9.2-д Тахир дутуу хүн ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлнэ. Хараагүй, дүлий болон эрхтэн дутуу хүмүүсийн санаачлагаар, эсвэл тэдэнд зориулан төрөөс үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй шаардлагатай бол Засгийн газрын болон аймаг нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлэх буюу улс, орон нутгийн төсвөөс зохих алдагдлыг нөхөн санхүүжүүлж болно гэсэн заалтыг нийслэл дэх Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийг Нийслэлийн Засаг даргын харьяалалд шилжүүлж, Засгийн газраас энэ үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, санхүүгийн бусад талын дэмжлэг үзүүлэх зорилгоор 2001 онд 25,0 сая төгрөг олгож, Японы Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрөөс тус үйлдвэрийн оёдлын цехэд 27,5 мянган ам долларын төсөл хэрэгжүүлж байгаа зэрэг олон талын туслалцаа үзүүлж байгаагийн үр дүнд энэ үйлдвэрийн үр ашиг дээшилж хараагүйчүүдийн амьдралд тус нэмэр болж, тэдэнд эрхээ эдэлж хэрэгжүүлэх аятай боломж бий болсон байна.

Нийслэлийн “Агни трейд” ХХК-ний захирал Цэцгээ санаачлан 30 гаруй тахир дутуу иргэнээс бүрдсэн үйлдвэр байгуулан жижиг үйлдвэрлэл явуулж олон тахир дутуу хүмүүсийн амьдрал ахуйг сайжруулахад хувь нэмэр оруулсан сайхан үйлс бүтээж байгаа боловч төрийн захиргааны холбогдох байгууллагуудын дэмжлэг дутсанаас сүүлийн үед түрээслэх байр олдохгүйгээс үйлдвэрлэл нь зогсоход хүрч байгаа юм байна.

Энэ мэтчилэн хараагүй, дүлий болон эрхтэн дутуу хүмүүсийн санаачлага оролцоотой ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад дорвитой туслалцаа дэмжлэг үзүүлэхгүй байгаагаас тэдгээр аж ахуйн нэгж байгууллага цаашид оршин тогтнож ажиллахад хүндрэлтэй болж байна. Энэ нь төр засгийн байгууллагын зүгээс тахир дутуу иргэдийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх

зохистой тогтолцоо бий болгоогүй, тэднийг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрэн хуульчилж өгөөгүйтэй холбоотой байна.

Тахир дутуу хүмүүсийн биеийн эрүүл мэндийн хэвийн бус байдлаас шалтгаалж эрүүл хүмүүстэй харьцуулахад хөдөлмөрийн бүтээмж бага, тусгай хэрэгцээт зүйлийг хэрэглэдгээс хамаарч үйлдвэрлэч буй бүтээгдэхүүний өртөг, зардал өндөр байдаг онцлогтой юм байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 91.1-д “Энэ хуулийн хүрээнд дараах үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө”, 9.2.7-д “Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл”-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас, Гаалийн тарифын тухай хуулийн 21.1.4-д “Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл”-ийг гаалийн татвараас чөлөөлөхөөр заасан нь бага ч гэсэн тахир дутуу хүмүүст үр дүнгээ өгч байгаа боловч энэ нь тэдэнд аж ахуй эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад эдийн засгийн нааштай хөшүүрэг болж чадахгүй байна. Тэд үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад гаднаас тоног төхөөрөмж, бараа, материал түүхий эд оруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ борлуулаад олсон орлогоо татварт өгдөг учир ашиг, орлогогүй болж үйлдвэрлэл нь зогсоход хүрч байна. Аж ахуй эрхэлж үйлдвэрлэл явуулахад байр олдохгүй, олдсон байрны түрээсийн үнэ өндөр байдаг нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулаг байна.

Жишээ нь: Завхан аймгийн Улиастай суманд Италийн Засгийн газрын бус байгууллагын “АИФО”-ын төслөөс тахир дутуу иргэдэд ундаа, зайрмаг үйлдвэрлэх цех байгуулж ажиллуулсан боловч хувь хүний түрээсийн байранд цэвэр, бохир ус, халаалт, цахилгаан гэх мэтийн төлбөр хэт өндөр учраас зардал нь хэтэрч үйл ажиллагаа нь зоссон байна. (Завхан аймгийн судалгааны материалаас)

6. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17.2-д “Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн (гэмтлийн) эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ (протез, ортопед)-ыг гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг олгож болно” гэж заасан байдаг.

Гэтэл зарим үйлдвэр, аж ахуйн байгууллагууд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон хүмүүстээ гадаад оронд нөхөн сэргээх эмчилгээ, засал хийлгэх гэхэд зардлыг нь олгохгүй байна.

Жишээ нь: Дархан-Уул аймагт Эрэл цементийн үйлдвэр нь иргэн Э-г илүү цагаар ажиллуулж байгаад үйлдвэрлэлийн осолд орж өрөөсөн гар, хөлөө тайруулж хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, цаашид гадаад улс оронд явж хиймэл гар, хөл хийлгэхэд 9,000,0 мянган төгрөг шаардлагатай болсон байхад үйлдвэрийн дарга Цэрэнбалжир “чиний буруугаас осол гарсан учир үйлдвэр төлбөр өгөхгүй” гэж байжээ. (Дархан –Уул аймгийн судалгааны

7. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 8.3-д “Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага нь тухайн байгууллагад хүмүүжиж чадах бэлтгэл хангасан сүрье зэрэг архаг халдварт өвчний халдвартай үеэс бусад тохиолдолд эрүүл хүүхэдтэй хамт өсгөж хүмүүжүүлнэ.”, 8.6-д “Тусгай нөхцөлд сургалт-хүмүүжлийн болон үйлдвэрлэл-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг ясли, цэцэрлэг, үйлдвэрлэл-сургалтын аж ахуйн нэгж байгууллага (цаашид “тусгай сургалтын байгууллага” гэх )-д тахир дутуу хүүхэд, насанд хүрэгчдийг тусгай сургалтанд хамруулна” гэж тус тус заасан байдаг. Ерөнхий боловсролын хот хөдөөгийн нийт сургуулиудад 2001-2002 оны хичээлийн жилд харааны согогтой 19159, сонсох, өгүүлэх эрхтний согогтой 10586, оюун ухааны хомсдолтой 2723, тулах эрхтний согогтой 2705, бусал гэм согогтой 4406 бүгд 39579 сурагч сурч байна. (БСШУЯамны Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын газрын танилцуулгаас)

Энэ удаагийн нийслэлийн болон аймгуудын судалгаагаар сургууль завсардсан тахир дутуу хүүхэд олон байгаа нь тэд сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байгааг харуулж байна. Хөдөө орон нутугт тахир дутуу хүүхэд сурч боловсрох сургууль, орчин нөхцөл бий болоогүй, согог зүйч мэргэжлийн багш бэлтгэгдээгүй, сурах бичиг байхгүй, эцэг эх нь хүүхдээ сургах эдийн засгийн боломж байхгүй зэрэг бэрхшээлүүдээс шалтгаалан сурч чадахгүй байна.

Тусгай хэрэгцээт боловсрол шаардсан хүүхдүүдийн болон багийн заах аргач багш Нямжав: тусгай хэрэгцээт хүүхдийг хамт олны дунд нь сургах зарчмаар ажиллаж байна. Хүнд согогтой хүүхдүүд нь ихэвчлэн гэртээ байдаг. Тийм хүүхдүүдийн талаар нарийн судалгаа байхгүй ба тахир дутуу хүүхдүүдийн ар гэр нь ихэвчлэн ядуу, хөрөнгийн боломжгүй хүмүүс байдгаас материаллаг хэрэгцээ дутмаг байдаг. (Говь-Алтай аймгийн судалгааны материалаас)

Баянхонгор аймагт л гэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 208 хүүхэд буюу нийгмийн эмзэг буюу тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн 60 гаруй хувь нь хамрагдаж, 40 хувь нь сургууль, цэцэрлэгийн хүрээнээс гадуур байна.

Тахир дутуу хүүхдүүдийн ар гэрийн 80 гаруй хувь нь нэн ядуу амьдралтай байгаа учир хүнд согогтой, бичиг үсэг мэдэхгүй хүүхдүүд гэртээ амьдардаг. Сонсголгүй хүүхдүүдэд сонсголын аппарат нэн шаардлагатай байна. (Говь-Алтай аймгийн судалгааны материалаас)

Холбогдох хуулийн “сургуулийн насны өмнөх хүүхдийн байгууллага нь тухайн байгууллагад хүмүүжиж чадах бэлтгэл хангасан сүрье зэрэг архаг халдварт өвчний халдвартай үеэс бусад тохиолдолд эрүүл хүүхэдтэй хамт өсгөж хүмүүжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх тусгай журам байхгүйгээс уг заалтыг хэрэгжүүлэхдээ тухайн ангийн багш, цэцэрлэгийн эрхлэгчийн үзэмжээр шийдэж байна. Өмнөговь аймагт хараагүй, дүлий зэрэг согогтой хүүхдүүдийн хөрөнгийн боломжтой эцэг эх өөрсдийн зардлаар хүүхдүүдээ Улаанбаатар хотын 29-р тусгай сургуульд суралцуулдаг. 1994 онд тусгай сургуулийг туршилтын журмаар ажиллуулж байгаад хаасан. (Өмнөговь аймгийн судалгааны материалаас)

Тахир дутуу хүүхдүүдийг цэцэрлэгт хүмүүжээд гарсан ч сургуульд авахдаа таагүй ханддаг. Жишээ нь Улиастай сумын 10 жилийн 3-р сургуулийн 1-р ангид хэлгүй, дүлий 2 хүүхдийг өгөх гэтэл татгалзаж байв. Аймгийн тахир дутуу иргэдийн аймгийн салбар зөвлөлд сард ирдэг өргөдөл, хүсэлтийн 80-90 хувийг нь хэлгүй дүлий хүүхдийг сургуульд суралцуулж өгөөч гэсэн хүсэлт байдаг. Мөн тус аймагт байсан тусгай сургуулийг татан буулгасан нь тахир дутуу хүүхдийн сурах эрхийг нь хаах, улмаар дээрх хүүхдүүдийг оюуны хомсдолд оруулж байна. (Завхан аймгийн судалгааны материалаас)

8. Хөдөөгийн алслагдсан сумдаас нэн ядуу иргэд тахир дутуу болсноо тогтоолгохоор аймгийн төвд ирэхэд эдийн засгийн болон цаг хугацааны хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна.

Жилд 2 удаа буюу жил бүр тахир дутуугийн хугацааг сунгуулах гэж хөдөөнөөс аймгийн төвд ирэхэд зардал чирэгдэл их гарах юм. Дахин эмчлэгдэж нөхөн сэргээгдэхгүй өвчнийг дахин давтан ЭХМК-оор оруулах шаардлагагүй шүүдээ. (Тэлмэн сумын иргэн Цэдэндамба, Завхан аймгийн судалгааны материалаас )

Судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэн, тахир дутуу болохоо тогтоолгож чадахгүй байгаа нь ихэвчлэн хөдөөнөөс аймгийн төвд ирэхэд мөнгө, хугацааны хүндрэл гардаг, хаана хэнд хандахаа мэддэггүй, ЭХМК-оос асуудлыг нь хурдан шийдэж өгдөггүй зэрэг шалтгаанаас үүдэж байна.

Урьдчилсан судалгаагаар 15 аймаг, нийслэлийн 5 дүүргийн хэмжээнд тахир дутуу болохыг тогтоох шаардлагатай боловч Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор ороогүй 1955 хүн байна.

Тахир дутуу болохыг нь тогтоох шаардлагатай боловч ЭХМК-оор ороогүй 54 хүнийг судлахад татаж унадаг, хэлний согогтой, түлэгдсэн, оюуны хомсдолтой гэх мэт өвчтэй авч санхүүгийн боломжгүй, хэнд яаж хандахаа мэдлэггүй, хөөцөлдөх чадваргүй зэрэг шалтгааны улмаас хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас авах тэтгэвэр, тэтгэмжинд хамрагдаж чадахгүй байна. (Дундговь аймгийн судалгааны материалаас)

Жишээ нь Ховд аймгийн Дөргөн сумын иргэн Э оюуны хомсдолтой 2 хүүхэдтэй, тэд нар нь нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамрагдаагүй, тахир дутуу болсноо тогтоолгох боломж чадваргүй байна. (Ховд аймгийн судалгааны материалаас)

Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 4.1-д “Тахир дутууг тухайн иргэний оршин суугаа аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.” гэсэн нь Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2

дугаар зүйлд “. . . уг комисс аймаг, нийслэлийн дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд байна” гэж заасны зэрэгцээ Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолд “хүн амын нягтрал, аж ахуйн нэгж байгууллагын төвлөрөл, эмнэлэг үйлчилгээний материаллаг бааз, нарийн мэргэжлийн эмч нарын хангамж зэрэгтэй уялдуулан суманд ЭХМК-ыг байгуулж болно” гэж нэмэлт оруулсныг аймгууд хэрэгжүүлэхгүй байгаагаас удаан хугацаагаар өвчилсөн, гэмтсэн, төрөлхийн болон удамшлийн согог, өвчтэй хүмүүс тахир дутуу болохоо тогтоолгож чадахгүй чирэгдэж үүнээс шалтгаалан тэтгэвэр, тэтгэмжээ авах эрхээ эдэлж чадахгүй байна.

9. Засгийн газрын 1999 оны 36-р тогтоолоор баталсан журмын 3 дугаар зүйлд “Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт оршин суудаг бол нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй нэн ядуу амьдралтай өрхийн тахир дутуу гишүүн өвчний улмаас аймгийн мэргэжлийн эмнэлгийн хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх зайлшгүй тохиолдолд зохих баримт бичгийг үндэслэн нэг талын унааны зардлыг орон нутгийн нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний сангаас жилд нэг удаа нөхөн олгоно.” гэж заасан байдаг.

Энэ заалтаар бол бүх тахир дутуу иргэд бус нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй, нэн ядуу амьдралтай өрхийн тахир дутуу гишүүн гэсэн 2 шалгүүр тогтоожээ. Үүнээс шалтгаалж нийслэлээс алслагдсан нутгийн ядуу амьдралтай өрхийн тахир дутуу гишүүн, ялангуяа хүүхэд мэргэжлийн эмнэлгийн хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай бол нэг талын унааны зардлыг НХАҮ-ний сангаас нөхөн авах эрхгүй учир эмчилгээ, шинжилгээ хийлгэж чадахгүй эрүүл мэндээрээ хохирч байна.

Тахир дутуу өсвөр насны хүүхдийг эмчлэх эрүүлжүүлэх ажил хангалтгүй байна. Энэ ажил нь зөвхөн халамжийн байгууллагын ажил болсон бөгөөд эрүүл мэндийн байгууллагын оролцоо маш хангалтгүй байна. (Дундговь аймгийн судалгааны материалаас)

10. Засгийн газрын 1999 оны 36-р тогтоолоор баталсан журмын 3 дугаар зүйлд “Нэн ядуу амьдралтай өрхийн 16 хүртэлх насны (суралцаж байгаа бол 19 хүртэл) тахир дутуу хүүхэд болон . . . . . эрх үүсээгүй нэн ядуу амьдралтай тахир дутуу хүний протез, ортопедийн хэрэгсэл дотоодод хийлгэсний үнийг зохих баримтыг үндэслэн тухайн хүний оршин суугаа сум, дүүргийн НХАҮ-ний сангаас нэг удаа 100% нөхөн олгоно.” гэжээ. Гэтэл нэн ядуу өрхийн тахир дутуу хүн бол цаашид яаж төлөх вэ? 2-3 жил болоод л тэдгээр хэрэгслийг солоих шаардлага гардаг байна.

Нэн ядуу амьдралтай тахир дутуу хүний протез, ортопедийн хэрэгслийн үнийг нэг удаа нөхөн олгоод дараа нь эдэлгээний хугацаа дуусах, эвдэрч муудсан тохиолдолд дахин авах ямарч боломж байдаггүй байна. Судалгааны дүнгээс үзвэл тахир дутуу хүний протез, ортопедийн хэрэгслийг гадаад, дотоодын хандив тусламжийн шугамаар өгч байгаа болохоос бус үнээр нь худалдан авч байгаа тахир дутуу хүн байхгүй байна.

Сонсголын аппарат, тэргэнцэр, таяг олдоц муутай, нэг удаа хийдгэсэн протезууд нь шаарлага хангахгүй болсноос дахин хийлгэж чаддаггүй байна. Зарим сонсголын аппарат нь шуугиад чанарын шаардлага хангахгүй байгаа талаар хэд хэдэн сумдаас гомдол тавьж байна. (Булган аймгийн судалгааны материалаас)

Дүлий хүмүүст олгож байгаа Хятад улсад үйлдвэрлэсэн сонсголын аппарат нь хүний биед муугаар нөлөөлж сонсголыг нь улам муутгаж байна. Иймд ХБНГУ-д үйлдвэрлэсэн сонсголын аппаратын өгч байвал зүгээр байна. (Архангай аймгийн судалгааны материалаас)

11. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 12.3-д “Хүн ам олноор зорчиж, цуглардаг үйлчилгээ, үзвэрийн газар, гүүр болон утсан харилцааны хэрэгсэл тахир дутуу хүн зорчих, биеэ авч явахад зохицсон байх бөгөөд тэдгээрийн нэр, утсан харилцааны хэрэгсэл байрлах цэгийн жагсаалтыг сум, дүүргийн засаг дарга батлана.” гэж заасныг хэрэгжүүлж байгаа аймаг, дүүрэг маш цөөн байна. Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүрэг болон Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын төвийн орчимд, СБД-ийн 29-р тусгай дунд сургуулийн зарим хэсэгт хараагүй, хөлгүй хүмүүст зориулсан зам, хашлага хийснийг эс тооцвол дээрх заалт хэрэгжсэн газар байхгүй байна.

Жишээ нь: хөлгүй, тэргэнцэртэй зэрэг хүүхдүүд жирийн хүүхдүүдийн явдаг сургуульд явахад хүндрэлтэй, зам, талбай, хаалга, шат зэргээр тахир дутуу хүүхдэд зориулсан хаалга гэх мэт зүйл байхгүй болохоор маш хэцүү байдаг. (Говь-Алтай аймгийн судалгааны материалаас)

13. Засгийн газрын 1999 оны 36 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын 13 дугаар зүйлд “Нийтдээ 10-аас доошгүй жил хөдөлмөр эрхэлсэн бүрэн хараагүй, дүлий хүний эх орны рашаан сувилалд сувилуулах, аймгийн төв хүртэлх унааны болон зар бичгийн үнийн 50%-ийг зохих баримт бичгийг үндэслэн сум, дүүргийн НХАУ-ний сангаас жилд нэг удаа олгоно.”

Хараагүй, дүлий хүнийг хөдөлмөр эрхлээгүй бол рашаан сувилалд хөнгөлөлттэй сувилуулах эрхийг хязгаарласны зэрэгцээ нэн ядуу амьдралтай өрхийн насанд хүрээгүй хараагүй, дүлий хүүхэд рашаан сувилалд сувилуулах боломжгүй болж байна.

Би Дарханы хүнсний комбинатад 3 жил ажиллаад тархинд цус харвасны улмаас хэвтэрт орж хөдөлмөрийн задвараа бүрэн алдсан. Жилд нэг удаа шаргалжуутын рашаан сувилалд явж сувилуулдаг боловч унааны болон зар бичгийн үнийн 50%-ийг надад өгөхгүй юм. Эмийн болон нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх шаардлагатай боловч мөнгөгүйгээс хийлгэж чадахгүй байна. (Баянгол дүүргийн судалгааны материалаас)

Дээрх үндэслэлээр унааны болон зар бичгийн үнийн 50%-ийг хөнгөлж НХАУ-ний сангаас төлсөн ч гэсэн рашаан, сувилалд явж эмчлүүлж чадахгүй байгаа тахир дутуу иргэд маш олон байна.

Аймгийн НХАУТ-ийн захирал Чүлтэм хараагүй, дүлий болон бусад төрлийн тахир дутуу хүмүүсийн ихэнх нь ядуу, нэн ядуу тул унаа болон зар бичгийн зардлын 50%-ийг нь хөнгөлсөн ч сувилалд явж чаддаггүй. (Говь-Алтай аймгийн судалгааны материалаас)

14. Тахир дутуу хүний бие эрхтний нөхөн сэргээлтийг Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7.2-д “Тахир дутуугийн нөхөн сэргээлтийн эмчилгээ, сувилгаа, сургалт, биеийг тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа болон протез, ортопедын хэрэгслийн үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ” гэж заасан. Үүнээс үзэхэд тахир дутуугийн нөхөн сэргээлтийн эмчилгээ, сувилгааны үйл ажиллагааг эмнэлгийн байгууллагаас салгаж үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад хариуцуулсан нь буруу байна. Хуулийн энэхүү буруу зохицуулалтаас үүдэн тахир дутуу хүмүүсийн эмчилгээ, нөхөн сэргээлт, сувилгааны асуудал нь Эрүүд мэндийн яаманд үл хамааран энэ яамны мэргэжлийн удирдлага, туслалцаанаас хөндийрөхөд хүрсэн байна.

Хөдөөгийн сумдад амьдарч буй малчин өрхийн тахир дутуу иргэд эмнэлэгт нөхөн сэргээгдэх эмчилгээ хийлгэх боломжгүй байна.

ЭМД-ын төлбөрөө төлж чадахгүй байж байгаад үхэх юм байна. Манай хүүхэд унадаг өвчтэй бөгөөд 16 нас хүрээгүй учир тахир дутуугийн группэд ордоггүй. Эм тариа нь маш үнэтэй байдаг тул бидний амьдралд маш их хүндээр тусч байна. (Говь-Алтай аймгийн судалгааны материалаас)

Одоогоор нийслэлд тахир дутуу хүмүүсийн нөхөн сэргээлтийн эмчилгээ, сувилгаа, сургалтыг ХНХЯамны харьяа Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв эрхлэн гүйцэтгэж байна.

15. Засгийн газрын 1999 оны 36 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын 2.а-д “Орон сууцанд суугч хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүнтэй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн эзэмшиж буй орон сууцны байрны (талбай, халаалт, цэвэр, бохир усны) хөлсний 50%-ийг сар бүр олгох” тухай заагаад мөн журмын 2.б-д “дээрхийн адил айл өрх гэрт болон ердийн галалгаатай сууцанд амьдардаг бол 2 м<sup>3</sup> түлээ, 2 тонн нүүрсний үнэ (тээврийн хөлсний үнийг оруулан тооцсон)-ийг жилд нэг удаа олгоно” гэж заасан.

Баянхонгор аймгийн төв (Баянхогор сум)-д 2001 онд 320 өрх гэрт түлээ, нүүрс олгох ёстойгоос 65 өрхөд олгоогүй, 2002 онд 426 өрхийн 167-д нь олгоогүй байна. (Баянхонгор аймгийн судалгааны материалаас)

Судалгааны үеэр Архангай аймгийн Эрдэнэбулган сумын иргэн Жавзанбурмаа бидэнд “манай суманд тахир дутуу хүнтэй ядуу өрх 2 байхад түлээ өгөхгүй байна” гэж мэдээлж байв. (Архангай аймгийн судалгааны материалаас)

Нийслэл болон төв суурин газарт амьдарч байгаа бөгөөд дээрх хууль тогтоомжийн заалтанд хамаарах айл өрхөд түлээ, нүүрсийг нь шууд олгож байгаа сайн талтай боловч зохих хэмжээгээр нь бус дутуу өгдөг гэсэн гомдол багагүй гардаг байна.

Дүүргийн НХҮ-ний төвүүдийн “НарМон” ХХК-тай байгуулсан гэрээнд нэг тонн нүүрсийг 12 шуудай, нэг шуудай нүүрсийг 50 кг-аар тооцохоор тусгасныг Нийслэлийн хянан шалгах хорооны байцаагчид газар дээр нь хэмжиж үзэхэд 35-40 кг байснаар нь тооцоход иргэдэд 90,3-135,4 тонн нүүрс дутуу олгогдож, 1,8-2,7 сая төгрөгөөр хохироосон тоо гарч байна. Захуудын нүүрсний ченжүүд нэг шуудай нүүрсийг чанар байдлаас нь шалтгаалж 800-1200 төгрөгөөр зарж байгаа нь “НарМон” ХХК-ны бэлтгэдэг үнээс 837-473 төгрөгөөр хямд байна. (Төрийн хянан шалгах хорооноос (хуучин нэрээр) хийсэн шалгалтын материалаас)

Үүнээс үзэхэд НХҮТ-үүд өндөр үнээр авсан түлээ, нүүрсээ тахир дутуу иргэд эмзэг бүлгийнхэнд дутуу хэмжээгээр өгч хохироодог болох нь нотлогдож байна.

Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд тахир дутуу хүний эрхийг ханган хэрэгжүүлэх нийгмийн хамгааллын тогтолцоо бий болж, санхүү эдийн засгийн хувьд үйлчлэх механизмыг бүрдүүлж хөдөлмөрлөх чадвартай тахир дутуу хүнийг ажилд авах, тэдэнд үйлчлэх, тахир дутуу иргэдэд хөнгөлөлт, нөхөн сэргээлтийн үйлчилгээ үзүүлэх, сурч боловсрох бололцоогоор хангах тэднийг асрах, хүндэтгэх, туслах санаачлага зарим талаар өрнөж байгаа хэдий ч энэ талаар эдийн засаг, эрх зүй, нийгмийн сэтгэл зүйн орчин бүрэн бүрдэж чадаагүй байна.

Үүнээс үндэслэж дараах дүгнэлтийн хийж болмоор байна.

1. Тахир дутуу иргэдэд өгч буй тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгийн хэмжээ бага байгаагаас тэдний наад захын хэрэгцээг хангахгүй байна. Тэдэнд үзүүлж буй хөнгөлөлт, тусламж, үйлчилгээ хүртээмжтэй биш байна.

2. Тахир дутуу хүний эрхийг хэрэгжүүлэх, нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээг үзүүлдэг механизм боловсронгуй биш, тахир дутуу хүнд бүрэн хүрч үйлчилдэг, хяналт тавьдаг механизм байхгүйгээс танил талтай буюу овсгоотой, мэдээлэл сайн авч чадсан хэсэг нь үйлчлүүлж, мэдээллээс хөндий, эрхээ эдлэж хэрэгжүүлэх чадваргүй хэсэг нь хөнгөлөлт, үйлчилгээ авч чадахгүй хохирч байна.



3. Тахир дутуу иргэдэд үзүүлэх нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээ, зохих сангийн зарцуулалт, хөнгөлөлт, тусламж зохих журмаар явагдаж байгаа эсэхэд тавих олон нийтийн хяналт, оролцоо байхгүйгээс нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд зориулсан мөнгөн хөрөнгө зүй бусаар зарцуулагдах, эзэндээ хүрэхгүй байх, дутуу хагас олгогдох, зарим тахир дутуу иргэд үйлчилгээнд хамрагдахгүй хохирох тохиолдол гардаг байна.

4. Тахир дутуу иргэдийн хөдөлмөрлөх, сурч боловсрох, эмнэлгийн тусламж үзүүлэх, улс төрийн амьдралд оролцох зэрэг эрх нь зөрчигдөж, тахир дутуу гэдгээр нь шууд бусаар ялгаварлан гадуурхах хандлага нийгмийн тодорхой хэсэгт байсаар байна. Орон тоо байсаар байтал элдэв шалтгаан зааж ажилд авахгүй байна.

5. Тахир дутуу иргэдийн нөхөн сэргээлтийн эмчилгээг энгийн иргэдийн ердийн өвчинтэй адилтгаж үздгээс эмчилгээний үр дүн гарахгүй байхад эмчилгээгээг нь дуусгадаг, эрүүл мэндийн байгууллага Тахир дутуу иргэдийн эмчилгээ, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаанд мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна. Ялангуяа хөдөө, орон нутагт тахир дутуу хүнийг нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа хийх мэдлэг, чадвар мөхөс байна.

6. Тахир дутуу иргэд, ялангуяа хүүхдүүдийн эцэг, эхчүүдийн ихэнх нь нэн ядуу, ядуу байдаг учир тэдний протез, ортопедын үйлчилгээг нэг удаа л НХАҮ-ний сангаас үнийг нөхөн олгохоор заасан нь амьдралд огт нийцэхгүй байна.

Энэ мэтээр тахир дутуу хүний эрхийг хэрэгжүүлэх, нийгмийн хамгааллыг хангахад саад бэрхшээл учруулж буй хүчин зүйл, арилгавал зохих дутагдал, шийдвэрлэх асуудал цөөнгүй байна.

#### **Цаашид шийдвэрлэх асуудлын талаарх саналууд**


1. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль, нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар энэхүү хоёр хуулийг боловсронгуй болгох;

2. Засгийн газрын 1999 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Тахир дутуу иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний тухай” журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тахир дутуу хүний нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах;

3. Эрүүл мэндийн тухай, Гаалийн тарифын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудын зохих зүйл заалтууд тахир дутуу хүний нийгмийн хамгааллыг сайжруулах асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах;

4. Судалгаагаар илэрсэн зарим зөрчил, дутагдлыг арилгах талаар холбогдох газруудад зөвлөмж шаардлага гаргаж явуулах.

Судалгааны дүнг нэгтгэж  
товч тайлан бичсэн гишүүн

 Г. Далайжамц

Судлаач

 Д. Рагчаасүрэн

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## “ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН АЖЛЫН ЯВЦЫН ТУХАЙ

2001-11-02.

Монгол улсын Засгийн Газрын 2001 оны 16 дугаар тогтоолын дагуу “Тахир дутуу иргэдийг дэмжих жил”-ийн ажлыг нийслэлд зохион байгуулах салбар хороог байгуулах, жилийн ажлын төлөвлөгөөг батлах нийслэлийн Засаг даргын 115 тоот захирамж гарч, дүүргүүдэд салбар зөвлөл байгуулагдан ажиллаж байна.

“Тахир дутуу иргэдийг дэмжих жил”-ийн ажлын нээлтийн ажиллагааг 3 дугаар сарын 11 нээс 4 дүгээр сарын 12-ны хугацаанд нийслэл, дүүргүүдэд нийт 1600 гаруй хүнийг оролцуулан соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулан хийв.

Нийслэлийн салбар хорооны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хариуцах байгууллага, албад, дүүргийн салбар зөвлөлийн дарга нарыг оролцуулсан өргөтгөсөн хурал, нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөлгөөнөөс тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг даалгаврыг тогтмол өгч ажиллалаа.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах Үндэсний хороонд тогтоосон хугацаанд ажлаа тайлагнан, тус хорооны 11-р сарын 1-ний өдрийн хуралд Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдээс нэрэмжит жилийн ажлыг зохион байгуулж байгаа тухай сонсгол мэдээллийг хэлэлцүүлж хангалттай сайн ажиллаж байна гэсэн үнэлгээг өглөө..

### Нэг. Нийслэл дэх тахир дутуу иргэдийн өнөөгийн байдал

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистик, мэдээлэл судалгааны газрын 2001 оны эхний хагас жилийн мэдээгээр Улаанбаатар хотод нийт 14797 тахир дутуу хүн байгаа, үүнээс 7488 нь эмэгтэй, 605 нь хэлгүй, дүлий, үүнээс 249 нь эмэгтэй, хараагүй 282, үүнээс 101 нь эмэгтэй, 14696 нь бусад эрхтний согогтой тахир дутуу хүмүүс байна.

Нийт тахир дутуу хүмүүсийн 2588 нь төрөлхийн, 12209 нь олдмол шинж чанартай, үүнээс 1998 нь үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан, сэтгэцийн өвчтэй 3338, хөдөлмөрийн чадвараа 50-70 хувь алдсан 7226 хүн байгаа юм.

Тахир дутуу хүмүүсийг насны ангиллаар авч үзэхэд 0-15 насны 722, хөдөлмөрийн насны 13156, хөдөлмөрийн нас хэтэрсэн 919 хүн байна.

Цаашид тахир дутуу иргэдийн судалгааг бодитой болгох зорилгоор нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр нийгмийн хамгааллын албанаас Стастикийн албатай хамтран боловсруулсан аргачлалыг үндэслэн шинэчлэн гаргаж мэдээллийн сантай болов.

### Хоёр. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын талаар

Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд нийгмийн даатгалын сангаас 11967 тахир дутуу хүнд 1200,0 сая төгрөгийн, нийгмийн халамжийн сангаас 3293 хүнд 211,9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, үүнээс 542 иргэнд байнгын асрамжинд байдаг тахир дутуу хүүхдээ асарсны тусламжинд 56,9 сая төгрөгийн, 365 хүнд 6,2 сая төгрөгийн байрны талбайн хөлсний, 1064 хүнд 26,5 сая төгрөгийн түлээ нүүрсний, 265 хүнд 15,4 сая төгрөгийн протези ортопедийн хэрэгсэлийн үнийн хөнгөлөлт үйлчилгээг үзүүлж, “Нийгмийн

халамжийн тухай хууль"-ийн дагуу тэргэнцэр, магнитофон сонсголын аппарат олгох, телефон утасны, рашаан сувилалд сувилуулах зардлын 50 хувийн нэг удаагийн хөнгөлөлт зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд Олон улсын Энэрлийн байгууллагын тусламжаар 250 хүнд, бусад байгууллагын шугамаар 84 хүнд, бүгд нийт 138.4 сая төгрөгийн үнэтэй 334 тэргэнцэр, 187 хүнд 10,4 сая төгрөгийн сонсголын аппарат олгоод байна.

Одоогоор нийслэлийн хэмжээнд дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдлүүдийг түшиглэн тахир дутуу иргэдийн нөхөн сэргээх эмчилгээний 8 кабинет, төв ажиллаж байгаа бөгөөд энэ онд одоогийн байдлаар бүгд 6007 хүн эмчилүүлснээс, 4059 нь амбулаторийн, 1387 нь хэвтэж, 2705 нь нөхөн сэргээх эмнэлгийн үйлчилгээнд хамрагджээ.

Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших тулгар эрхтний согогтой хүүхдийн сувиллын 10-р яслийн үйл ажиллагааг өргөжүүлэн 2 анги нээн ажиллуулахад засгийн газраас 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээс 20,0 сая төгрөгийн санхүүжилт авч, дүүргийн төсвөөс 2,0 сая төгрөг гарган зарцуулав.

"Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль"-ийн холбогдох заалт, дэмжих жилийн ажлын хүрээнд нийслэлийн хот байгуулалт эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зайлшгүй шаардлага хэрэгцээтэй зарим байгууллага, нийтийн үйлчилгээний газруудад тахир дутуу хүмүүст зориулсан шат, зам гарц байгуулах ажлын зураг, төсөв төлөвлөн хэрэгжүүлснээр одоогийн байдлаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр эрхлэлтийн газар, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар, Улсын нийгмийн халамжийн газар, Сансрын үйлчилгээний төв зэрэг газруудад тахир дутуу иргэдийг зорчиход зориулсан шат, гарц байгуулагдав.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах Үндэсний хороонд нийслэл, дүүргүүдэд зайлшгүй шаардлагатай хийгдэх зарим ажлын талаар санал боловсруулж, албан тоот илгээсэн боловч хөрөнгийн дутагдлаас шалтгаалан шийдвэрлэгдэхгүй байна.

#### Гурав. Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын нэг үндсэн чиглэл нь тэдний ажиллах чадвар, мэргэжил бололцоонд тулгуурласан хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нийслэл, дүүргийн Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлэх явдал байв.

Тахир дутуу иргэдийг ажлын байраар хангах "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 111 зүйлийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба, дүүргийн Хөдөлмөрийн албадад тодорхой чиглэл өгч ажилласнаар энэ онд 50-иас дээш ажилтантай 438 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийж, 203 хүнийг хөдөлмөрт зуучлан, 154 хүнийг ажлын байраар хангаж, 74 хүнийг мэргэжлийн сургалтанд хамруулсан байна.

Үйлдвэрлэлийн осол, аваараас урьдчилан сэргийлэх, ажиллагсдын хөдөлмөрийн нөхцлийг хангах зорилгоор нийслэлийн бүх дүүргүүдэд "Хөдөлмөрийн аюулгүй орчин сэдэвт өдөрлөг, семинар-сургалтыг ажил олгогчдыг оролцуулан зохион байгуулав.

"Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн Үндэсний хорооны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Хараагүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн

Үйлдвэрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлийн төслийг нийслэлийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба, үйлдвэрийн захиргаатай хамтран боловсруулж, 25 сая төгрөгийн санхүүжилт авч үйлдвэрлэлийг өргөтгөхөд зарцуулан, тус үйлдвэрийн үйлдвэрлэлийн бүтээгдхүүний борлуулалт, чадавхийг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын 2001 оны 271 тоот захирамж гарган, нийслэлийн төсвөөс санхүүждэг сургууль, дэцэрлэг, эмнэлэг, хот тохижуулах үйлчилгээний хэрэгцээт ажлын хувцас, ор хөнжлийн даавуу, цэвэрлэгээний материал, багаж хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тахир дутуу иргэдийн эрхлэдэг зарим аж ахуйн нэгжид тоног төхөөрөмж, ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт туслалцаа үзүүлэх талаар анхаарал тавьж, иргэдээс гаргасан өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж байна.

Энэ онд ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн жижиг зээлийн эргэлтийн сангаас 87 тахир дутуу хүнд 15,6 сая төгрөгийн зээл олгож, өрхийн орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, байнгын ажлын байраар хангах 22 төслийг хэрэгжүүлж байна.

Дөрөв. Тахир дутуу иргэдийн боловсрол, соёл урлаг, биеийн тамирын арга хэмжээний талаар

Жил бүр уламжлал болгон зохиогддог дэлхийн цагаан таягтны өдрийг энэ онд “Гэрэл гэгээ хайрлацгаая”, тахир дутуу хүмүүсийн өдрийг “Энэрэнгүй үйлсийг бүх нийтээр дэмжицгээе” уриан дор зохион явууллаа.

Нийслэл, дүүргийн биеийн тамир спортын хороодоос тахир дутуу иргэдийн дунд суугаа волейбол, байт харваа, аялал, гүйлтийн тэмцээнүүдийг зохион байгуулж, нийслэлийн Засаг даргын захирамжаар тахир дутуу хүмүүст зориулсан “Шинэ үе продакшн” хошин урлагийн тоглолтыг үнэгүй үзүүлэх ажлыг байр ашиглалт, түрээсийн 900,0 мянган төгрөгийн төлбөрөөс чөлөөлөн дэмжив.

Тахир дутуу иргэдийг жилийн ажлын хүрээнд нийслэл, дүүргүүдэд зохиогдож байгаа ажлын талаар төвийн болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах ажлыг байнга сурталчилж байна.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ  
ЖИЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
НИЙСЛЭЛИЙН САЛБАР ХОРОО.

## ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН , ЦААШДЫН ЗОРИЛТЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн Үндэсний Байгууллага тахир дутуу иргэдийн асуудалд ихээхэн анхаарал тавьж 1993 - 2002 оныг Ази, номхон далайн бүс нутгийн орнуудын тахир дутуу иргэдийн 10 жил болгон зарлаж олон талт ажиллагааг явуулж байгаад манай орон идэвхитэй оролцож ирлээ. Үүний нэг нь тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрх ашгийг хамгаалахад төрөөс дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас 2001 оныг` Тахир дутуу иргэдийг дэмжих жил `болгон зарласан явдал юм.

Тахир дутуу иргэдийг дэмжих жил`-ийн хүрээнд тэдний аж байдлыг сайжруулах, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж , иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар нилээд ажлыг хийж зохих үр дүнд хүрлээ.

### НЭГ : УДИРДЛАГА , ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР :

Засгийн газрын тогтоолоор` Тахир дутуу иргэдийг дэмжих жил`-ийн хүрээнд хийх ажлыг зохион байгуулах Үндэсний хороог 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, түүнд шаардагдах 121.0 сая төгрөгийг улсын төсвөөс гаргаж өгсөн. Орон нутагт жилийн ажлыг зохион байгуулах салбар хороодыг Засаг даргын орлогчоор ахлуулан, Үндэсний хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу ажиллуулж ирлээ

Үндэсний хорооны хурлыг 2 сар тутамд хуралдуулан, жилийн ажлын явц тайлан, төлөвлөгөөний биелэлт, жилийн ажлыг эрчимжүүлэх талаар болон цаашид анхаарах асуудлууд, Нийслэлийн засаг даргын тамгийн газрын болон Хан-Уул, Баян-Зүрх, Сүхбаатар дүүргүүдийн салбар хороодын хийсэн ажлын мэдээллийг сонсон, жилийн ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл , үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Тахир дутуу иргэдийг дэмжих жил`-ийн ажлын хүрээнд 29 ажил төлөвлөгдсөнөөс сонсголгүй, тахир дутуу иргэдэд зориулсан жолооны курс нээн хичээллүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх гэснээс бусад ажлууд нь бүрэн хэрэгжиж, жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 96.5 хувиар, аймаг, орон нутгийн салбар хороодын төлөвлөсөн ажлууд 90.0 - 95.5 хувиар тус тус биелжээ. (Төлөвлөгөөний биелэлт, төсвийн тайланг хавсаргав.)

### ХОЁР : ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР :

Хөдөлмөр эрхлэх бололцоогүй бие , эрхтний согогтой иргэдийн амьдралын эх үүсвэр нь тэтгэвэр тэтгэмж болж байна . Иймээс Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 88 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа 39.9 гаруй мянган иргэдийн тэтгэврийг 2001 оны 4 дүгээр сарын 15-наас эхлэн дунджаар 10 хувиар , 166 дугаар тогтоолоор 10 сарын 1-ний өдрөөс тахир дутуугийн бүрэн тэтгэврийн доод хэмжээг дахин 6,5 хувиар нэмэгдүүлж 18850 төгрөгт хүргэх арга хэмжээнд

21457 иргэн буюу нийт тахир дутуугийн тэтгэвэр авагчдын 53,3 хувь нь хамрагдаж, 73.0 сая төгрөг нэмж зарцуулсан байна. Эдгээр арга хэмжээний дүнд тахир дутуугийн тэтгэвэр авагчдын дундаж тэтгэвэр 8,2 хувиар өслөө.

Нийгмийн халамжийн сангийн 2001 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр 23.3 мянган тахир дутуу хүнд 2.5 гаруй тэрбум төгрөгийн тэтгэвэр, 11.3 мянган тахир дутуу иргэнийг 445.2 сая төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээнд хамруулан, хэвтрийн тахир дутуу хүүхдээ асардаг 887 асран хамгаалагчид 60.8 сая төгрөгийн тэтгэмж, 4566 тахир дутуу хүний түлээ, нүүрс, орон сууцны хөнгөлөлтөнд 123.2 сая төгрөг, нэн ядуу амьдралтай тахир дутуу 422 иргэнд 64.1 сая төгрөгийн зориулалтын тэргэнцэр олгосон байна.

Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлд заасан Тахир дутуу буюу одой хүний хөдөлмөрийн тухай заалтыг мөрдөх журмыг НХХ-ийн болон СЭЗ-ийн сайдын хамтарсан 72/209 тоот тушаалаар шинэчлэн боловсруулж 2001 оны 8 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж 319 тахир дутуу иргэнийг ажлын байраар ханган 137 тахир дутуу иргэнийг мэргэжил олгох сургалтанд хамруулж, Тахир дутуу, одой иргэдийн хөгжлийн сан-д 2001 онд 366.0 мянган төгрөг төвлөрөөд байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөн тахир дутуу болсон иргэдэд нөхөн төлбөр олгох ажилд ахиц гарлаа. Налайхын нүүрсний уурхайд ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон 723 хүнд 243.7 сая төгрөгийн нэг удаагийн нөхөн төлбөрийг Засгийн газраас олгоод байна.

Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвөөс 2001 - 2002 оны хичээлийн жилд оёдолчин, мужаан, талх нарийн боовчин, компьютерын операторч, гар хивсчин-сүлжмэлчин, үсчин, гоо сайхан, цэцэгчин-ногоочны зэрэг мэргэжлээр 97 сурагч элсүүлсний 34 нь хэлгүй дүлий, 33 нь оюун ухааны хөнгөн хомсдолтой, 20 нь хөдөлгөөний хомсдолтой, 2 нь сул хараатай, 8 нь нэн ядуу амьдралтай иргэд байна. Протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэх түүхий эд, материалыг ОХУ-аас олж нийлүүлэх арга хэмжээ авч, 18.0 сая төгрөг зарцуулсан ба 2 жил хэрэглэх материалын нөөцтэй боллоо.

Аймаг, орон нутагт ажиллах тусгай сургуулийн болон дүлий хүүхдийн багш бэлтгэх сургалтыг 29 дүгээр сургууль дээр 2 удаа 21 хоногийн хугацаатайгаар зохион байгуулж, нийт 40 гаруй багш, мэргэжилтэн бэлтгэн үнэмлэх, сертификат олгоод байна. Олон улсын дохионы хэлний сурах бичгийг монгол хэл дээр орчуулан 300 ширхэгийг хэвлүүлэн аймаг, орон нутагт хүргүүллээ.

Улаанбаатар хотод сэргээн засалтын үндэсний төвийн иж бүрэн цогцолбор / эмнэлэг, сургууль, үйлдвэр, оюутны байр, спорт заал, усан бассейн / барих, 5 аймагт салбар байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах чиглэлээр 8.1 сая ам. долларын өртөг бүхий төсөл боловсруулсныг Монгол Улсын Засгийн газар дэмжиж Япон Улсын Засгийн газрын тусламжийн арга хэмжээнд оруулан судлуулж байна.

Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын сантехникийн засварт 20,0 сая төгрөг, асрамжийн анги нээхэд 20.0 сая төгрөг зарцуулж үйл ажиллагааг сэргээснээр тархины саажилттай 60 гаруй хүүхэд хамрагдаж байгаагийн 20 нь байнгын ажиллагаатай асрамжийн ангид асруулах бололцоог бий болгоод байна. Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээхэд жилийн ажлын төсвөөс 25,0 сая төгрөг, нийслэлийн төсвөөс 27.0 сая төгрөг зарцуулж үйлдвэрлэлийн ажиллагааг хэвийн болгосноор тэнд 95 хүн ажиллаж байна.

Зарим албан байгууллага, үйлчилгээний газруудад тахир дутуу иргэд чөлөөтэй нэвтрэх боломж бүрдүүлэх, зам, дохиолол, гарц байгуулах зорилтын хүрээнд НХХЯ, УНХГ, 29 дүгээр тусгай дунд сургууль, ХХХСҮ, зэрэг газруудад харааны хүндрэлтэй болон тэргэнцэртэй тахир дутуу иргэдэд зориулсан зам, гарцыг шинээр тавьсан нь дээрх иргэдийн дэд бүтэцийн асуудлыг шийдвэрлэх анхны ахлам боллоо.

Аймаг орон нутагт ч нилээд ажлууд хийгдлээ. Тухайлбал АЙФО төслийн хүрээнд Өвөрхангай, Завхан, Говь-Алтай аймгууд, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн 138 тахир дутуу иргэнд 18.9 сая төгрөгийн зээл олгосон, Дундговь аймагт тахир дутуу иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор 30 хүнийг ногоон хувьсгал, 50 хүнийг цагаан хувьсгал хөдөлгөөнд хамруулсан, Баянхонгор аймагт тахир дутуу иргэдийн үйлдвэрлэл, үйлчилгээний төв байгуулан 20 гаруй тахир дутуу хүнийг ажиллуулан, төвийн дэргэд тахир дутуу иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах дэлгүүр нээсэн, Дорноговь аймгийн НХҮТ дээр зөөлөн оёдол, гутлын цехийг 6 хүнтэй ажиллуулсан, Архангай аймагт хүнсний болон барааны зах дээр ажилладаг тахир дутуу иргэдийн лангууны түрээсийг чөлөөлж дэмжлэг үзүүлсэн зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Аймаг, орон нутгийн төсвөөс нийт 37.7 сая төгрөгийг жилийн арга хэмжээнд зарцуулсан тооцоо гарч байна.

“ Тахир дутуу иргэдийг дэмжих жил ”-ийн ажлын хүрээнд нийт иргэдийн дунд тахир дутуу иргэдээ дэмжин туслах, хамтран ажилах, сэтгэлийн дэм өгөх замаар нийгмийн сэтгэл зүйн зэрэг орчин бүрдүүлэхийн тулд нилээд ажлуудыг зохион байгуулж зохих үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

“ Тахир дутуу иргэдийг дэмжих жил ”-ийн ажлын нээлтийн ажиллагааг Төрийн ордонд зохион байгуулж, Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ –ын дарга, Ерөнхий сайд болон аймаг, нийслэлийн засаг дарга нар, тахир дутуу иргэдийн төлөөлөгчид 1000 гаруй хүн оролцож, төр, засгийн бодлого, энэ жилд хийх ажлын чиглэлийг тодорхойлж, бие эрхтний согогтой боловч авьслаг, бүтээлч хамт олон, уран сайханчдын тоглолтыг үзэж сонирхсон нь тэдний ирээдүйд итгэх итгэлийг нэмэгдүүлж, урам зориг өгсөн арга хэмжээ болсон гэж дүгнэж байна.

Тахир дутуу иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хатагтай нарын “ Энэрэхүйн айлсалт буяны үдэшлэг ”-ийг зохион байгуулж, тэргүүн хатагтай болон улс төрч, төрийн өндөр албан тушаал хашиж байгаа эмэгтэйчүүд, томоохон, нэр хүндтэй компанийн эзэд



хатагтай нар оролцож 2000 ам. доллар , бусад эд зүйлсийн хандив, тусламжийг цуглуулсан нь цаашдын арга хэмжээг зохион байгуулахад ихээхэн тус нэмэр болсон юм. Тухайлбал дээрх хөрөнгөөр 2001 оны 5 дугаар сарын 31-нд `` Тахир дутуу хүүхдүүдээ халамжлая `` сэдэвт тахир дутуу хүүхдүүдийн цэнгээнт өдөрлөгийг зохион байгуулж, 1000 тахир дутуу хүүхдэд баярын бэлэг, хичээлийн хэрэглэл, хувцас, хадгаламжийн дэвтэр, хүүхдийн гэнэтийн осолын даатгалын гэрчилгээ зэргийг гардуулж, нийт 16.0 сая төгрөгийг зарцууллаа.

`` Тахир дутуу иргэдийг дэмжих жил ``-ийн ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгч Н. Багабанди тахир дутуу иргэдийн зарим байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, жилийн ажлын талаар болон тахир дутуу иргэдийн өмнө тулгамдаад байгаа зарим асуудлаар санал солилцон, зөвлөлгөө өглөө.

`` Бид бүхнийг чадна `` сэдэвт тахир дутуу иргэдийн урлаг, хөдөлмөр, уран бүтээлийн өдөрлөгийг зохион байгуулж, 13 аймаг, дүүргүүдээс урлаг, уран бүтээлээрээ шалгарсан 450 гаруй тахир дутуу иргэдийн 3000 гаруй бүтээл тавигдсан уран бүтээлийн үзэсгэлэн худалдаа гаргаж, 2.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, цаашид хамтран ажиллах, бүтээгдэхүүнээ борлуулах гэрээг зарим аж ахуйн нэгжүүдтэй хийж хамтран ажиллах боллоо. Энэхүү арга хэмжээний үеэр байгууллага, пүүс компани, хувь хүмүүсээс 5.0 сая төгрөгийн хандив цугларч , 11.6 сая төгрөгийн гэнэтийн ослын даатгалын болон хадгаламжийн дэвтэр нээж өгөн, 3.4 сая төгрөгийн хувцас, хичээлийн хэрэглэл, хүнсний зүйлсийн тусламжийг тахир дутуу иргэдэд олгосон нь иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн идэвхийг өрнүүлэхэд тус дөхөм болсныг харуулж байна. |

Тахир дутуу иргэдийг шуурхай бодит мэдээлэлээр хангах зорилгоор Монголын Үндэсний Телевизийн `` Цагийн хүрд `` мэдээллийн хөтөлбөрийг 7 хоногт 3 удаа дохионы орчуулгатайгаар нэвтрүүлж байна. Мөн Ийгл телевиз, Налайх, Дархан-Уул аймгийн орон нутгийн телевизийн мэдээллийн хөтөлбөр дохионы орчуулгатайгаар явагдаж эхлээд байна. Жилийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Монголын Радиогоор сард 4 удаагийн, Үндэсний телевизээр 8 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн явуулж, 3 удаа хэвлэлийн бага хурал зохион байгууллаа.

Өнөөдрийн байдлаар тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалсан 36 Төрийн бус байгууллага бүртгэгдэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор НХХЯ, МТДИБҮХ-той хамтран ажиллах гэрээг 2001 оноос байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу МТДИБҮХ-ны байрны түрээс, цалин, засвар, холбоо болон мэдээлэл, сурталчилгаа, бичиг хэргийн зардалд 2.0 сая төгрөгийн санхүүжилт олгосны сацуу тус холбооны хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан 2.0 сая төгрөгийн техник хэрэгсэл, компьютер, принтер, факсын аппарат зэргийг жилийн арга хэмжээний зардлаасаа олголоо.

Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох зорилгоор төсөл хэрэгжүүлэх, зээл тусламж авах асуудлыг гадаад, дотоодын байгууллагад тавьснаар зарим асуудлууд шийдвэрлэгдэж эхлээд байна. Тухайлбал: Японы Засгийн газрын Ядуурлыг бууруулах

сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 1.0 сая ам. долларын өртөгтэй `` Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь `` төслийг хэрэгжүүлэхээр боллоо. Мөн Япон улсын Засгийн газрын `` Өвсний үндэс `` хөтөлбөрийн хүрээнд ХХХСҮ дээр оёдлын тасгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, ажиллагчдад мэргэжлийн сургалт явуулах чиглэлээр 27.5 мянган ам. долларын өртөг бүхий төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Түүнчлэн энэ хөтөлбөрөөс Тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоонд 17.2 мянган ам. долларын өртөг бүхий төсөл хэрэгжүүлэхээр боллоо.

НХХЯ, `` Тусламжийн тэргэнцэр сан ``-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, тус сангийн шугамаар АНУ-ын `` Хүмүүнлэгийн тэргэнцэр сан ``-гаас ирүүлсэн тахир дутуу хүний зориулалтын 150 тэргэнцэр, 150 төрөл бүрийн таяг, дасгалжуулагч аппарат зэрэг тахир дутуу хүний тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлүүлэх арга хэмжээ авч ачиж, буулгах болон хадгалах байрны түрээсийн зардалд 0.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээд байна. Итали улсын Ром хотноо энэ оны 7 дугаар сарын 18-наас 8 дугаар сарын 1-ний өдрүүдэд болсон `` Дэлхийн дүлий иргэдийн зуны спортын XIX тоглолт ``-д чөлөөт болон сонгомол төрлөөр оролцох тамирчдын зардалд Засгийн газраас 15.2 сая төгрөг зарцуулан, уг тоглолтонд манай 3 тамирчин амжилттай оролцож медаль хүртлээ.

#### **ГУРАВ : `` ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ ``-ИЙН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЛААР :**

`` Тахир дутуу иргэдийг дэмжих жил ``-ийн ажлын хүрээнд нийт ард түмний дунд тахир дутуу иргэдээ дэмжин туслах , хамран ажиллах, дэмжих зорилгоор олон нийтийг хамруулсан өдөрлөг, уулзалт ярилцлага, сургалт семинар, үдэшлэг урлаг, спортын тоглолт, уран бүтээлийн үзэсгэлэн, хандив, тусламж цуглуулах арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд нийгмийн сэтгэл зүйн эерэг орчин бүрдэх эхлэл тавигдлаа гэж үзэж байна.

Жилийн ажлыг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэл, дүүрэг орон нутгийн Засаг дарга нар захирамж гарган, жилийн ажлыг зохион байгуулах салбар хороод санаачлага, идэвхи зүтгэлтэй оролцлоо. Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Увс аймгууд, Нийслэлийн ЗДТГ-ын салбар хороо, Баянгол, Налайх, Чингэлтэй дүүргүүд зохион байгуулалт сайтай, хийсэн ажлын үр дүн арвинтай ажилласан байна.

Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж аж ахуйн нэгж байгууллагууд тахир дутуу иргэдийг ажлын байраар хангах нааштай эхлэлүүд гарч эхлээд байна. Мөн тахир дутуу иргэдийн боловсрол, мэргэжлийн сургалт, мэргэжил эзэмшүүлэх түвшинд ахиц гарч байна.

Тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалсан Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжин, чадавхийг нэмэгдүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх чиглэлээр нилээд ажил хийгдлээ.

Жилийн ажлын хүрээнд зохион байгуулсан олон арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллага, хамт олон, иргэд, хувь хүмүүс ивээн тэтгэж 20.0 гаруй сая төгрөгийн эд материалын болон мөнгөн тусламж олгосон нь

ямар их нөөц бололцоо байгааг харуулж, ихээхэн ажил зохион байгуулах шаардлагатайг тодорхойлж өглөө.

#### **ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУДЫН ТАЛААР :**

Жилийн ажлын хүрээнд олсон амжилт, ажлынхаа эхлэлийг улам эрчимжүүлэн, цаашид тахир дутуу иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, тэдний суралцах, хөдөлмөрлөх бололцоог нэмэгдүүлэх замаар тэднийг нийгмийн идэвхитэй амьдралд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай байна.

Тахир дутуу иргэдийг дэмжих жил -ийн ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгч нийслэл дахь тахир дутуу иргэдийн зарим байгууллага, үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаад тахир дутуу иргэдийн өмнө тулгамдаад байгаа зарим асуудлуудыг судлан шийдвэрлэх үүргийг Засгийн газарт өгсөн нь бидний цаашид хийх ажлын чиглэл боллоо.

Энэхүү жилийн ажлын явцад гарсан бэрхшээл, тавигдаж байгаа зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

1. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвд хөдөө орон нутгаас ирж суралцаж байгаа оюутны дотуур байрны асуудлыг судлан шийдвэрлэх. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвд жил тутам 100-150 тахир дутуу хүн суралцаж мэргэжил эзэмшиж байгаа боловч сүүлийн жилүүдэд оюутны дотуур байр байхгүйгээс орон нутгаас суралцаж байгаа тахир дутуу иргэдэд нилээд хүндрэл бэрхшээл учирч байна. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвд хөдөө орон нутгаас суралцагчдыг бусад сургуулийн оюутны дотуур байранд болон төвийн ойролцоо орон сууц хөлслөн суулгах замаар оюутны байрны асуудлыг шийдвэрлэхэд жил бүр 2.6 сая төгрөг шаардагдаж байгааг тус төвийн жил тутмын төсөвт нэмж тусгах саналтай байна.

2. Дээрх төвийг Олон улсын сэргээн засалтын холбоонд гишүүнээр элсэхийг дэмжиж, тус холбоонд төлөх гишүүний татварыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байх. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв нь Олон улсын сэргээн засалтын холбоонд гишүүнээр элссэнээр тус холбоонд жилд төлөх татвар нь 500 - 1000 ам. доллар байдаг бөгөөд манай орныг хөгжиж буй оронд оруулан хөнгөлөлт үзүүлбэл жилд 500 ам. долларын татвар төлөх юм.

3. Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2002 оноос эхлэн тус үйлдвэрийн цахилгаан дулаан, уур ус, холбоо, захиргааны ажилтны цалингийн зардлыг Нийслэлийн төсвөөс бүрэн санхүүжүүлж байх. Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийг Засгийн газрын 1997 оны 37 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын харъяалалд шилжүүлж уг үйлдвэрийн халаалт, цахилгаан, холбоо, уур усны зардлын 50 хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлж байхаар шийдвэрлэсэн. Гэвч 1998 оны санхүүжилт 5.0 сая төгрөгийг дутуу олгосноос он дамжсан өртэй болсон,

2000 онд тус үйлдвэр цэвэр бохир усанд 10.5 сая, дулаанд 0.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 1.9 сая төгрөгийн өртэй гарч байсан бөгөөд тус үйлдвэрийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон хүнд үед нь " Тахир дутуу иргэдийг дэмжих жил " -ийн ажлын хүрээнд тус үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан энэхүү жилийн ажлын төсвөөс 25.0 сая төгрөгийн, Нийслэлийн төсвөөс 27.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож үйл ажиллагааг нь хэвийн болгосон.

Гэвч үйлдвэрт ажилладаг хараагүй нэг ажилтан сард 18000 төгрөгийн цалин авдаг байсныг 2001 оны 10 дугаар сараас эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүргэн 24750 төгрөг болгон нэмэгдүүлсэн, 2001 оноос ус, халаалт, цахилгааны үнэ нэмэгдсэн зэргээс 2001 оны эцэст дулаан халаалтын зардалд 7.2 сая, цэвэр бохир усны зардалд 3.5 сая төгрөгийн өртэй болж санхүүгийн байдал нь улам хүндэрч байна. Нийслэлийн төсвөөс 2002 онд 20.0 сая төгрөг тус үйлдвэрт олгохоор тусгасан боловч нэмж 32.2 сая төгрөгийн санхүүжилт дутагдах тооцоо гарч байна. Цаашид улсын хэмжээнд байгаа тахир дутуу хүмүүсийн ганц үйлдвэрийг дэмжих, хэвийн ажиллагааг нь хангах зорилгоор Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2-т " хараагүй, дүлий болон эрхтэн дутуу хүмүүсийн санаачлагаар, эсвэл тэдэнд зориулан төрөөс үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй шаардлагатай бол Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлэх буюу улс, орон нутгийн төсвөөс зохих алдагдлыг нөхөн санхүүжүүлж болно " гэсэн заалтыг үндэслэн нийслэлийн төсвөөс үйлдвэрийн халаалт, цахилгаан, холбоо, уур ус, захиргаа аж ахуйн ажилчдын цалингийн зардлыг 2003 оноос эхлэн бүрэн санхүүжүүлж байх саналыг оруулж байна.

4. Нийслэлд тахир дутуу иргэдийн сэргээн засалтын иж бүрэн цогцолбор, 5 аймагт салбар байгуулах асуудлыг Япон улсын Засгийн газарт тавьж эрчимжүүлэх арга хэмжээ авах. Иж бүрэн цогцолбор / эмнэлэг, сургууль, үйлдвэр, оюутны байр, спорт заал, усан бассейн / барих, техник тоног төхөөрөмжөөр хангах чиглэлээр 8.1 сая ам. долларын өртөг бүхий төсөл боловсруулсныг Монгол Улсын Засгийн газар дэмжиж Япон Улсын Засгийн газрын тусламжийн арга хэмжээнд оруулахаар зарчмын хувьд тохиролцсоныг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Эдгээр асуудлуудыг " Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын дүнгийн тухай " Засгийн газрын тогтоолын төсөлд тусган энэхүү хуралдаанд оруулж байна. Энэхүү тогтоолын төслийн талаар яамд, Нийслэлийн засаг даргын тамгын газрын саналыг нэгтгэн хавсаргав.

Уг тогтоолыг дэмжин шийдвэрлэн өгч тахир дутуу иргэддээ дэмжлэг туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Тахир дутуу иргэдийн өмнө тулгамдаад байгаа бүхий л асуудлыг ганцхан жилд шийдвэрлэх бололцоо, боломжгүй бөгөөд тахир дутуу иргэдийг дэмжих ажил зөвхөн ганц энэ жилээр хязгаарлагдах бус, цаашид улам өргөжүүлэн хийгдэх болно.

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**

ХУҮЦЭЛЭЛЭНГЭЙН СҮХБ ААТГАР  
ДУУРТУЙН ХУҮТМУЙН  
ДААТГАЛЫН ӨДӨЛГӨӨ  
2001-2002 ОХД ӨНӨӨ  
АЖЛЫН ТАУЛАХ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**Нэг. Ерөнхий зүйл**

Тус хэлтэс нь сүүлийн 2 жилд дүүргийн нутаг дэвсгэрийн хүрээнд харьцаж буй аж ахуйн нэгж байгууллагад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгалын сангийн орлогыг бүрдүүлэн, орлогын төлөвлөгөөг сар бүр жигд биелүүлж, шимтгэл төлөлтийн сар улирлын тайлан тооцоог хүлээн авч баталгаажуулах, өр авлагыг бууруулах, хамралтыг нэмэгдүүлэх, үндсэн мэдээллийг компьютерт бүрэн зөв шивж оруулах нийгмийн даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэхэд ажлаа чиглүүлж, тодорхой үр дүнд хүрч ажиллаа.

**Хоёр. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар**

Нийгмийн даатгалын хэлтэс нь шимтгэлийн орлогын төлөвлөгөөг байцаагч бүрээр улирал, сараар нарийвчлан тооцож хувиарлан биелэлтийг нь өдрөөр тооцон ажиллаж ирсний үр дүнд сүүлийн 2 жилийн төлөвлөгөө сар бүр биелж ирлээ.

2001 онд 30 хоногийн өмнө 2002 онд 62 хоногийн өмнө шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлээ.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ**

*Орлогын дүнг 2002 оны 11-р сарын 29 -ны байдлаар авлаа. /сая төгрөгөөр/*

Д/д	Он	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөөнөөс давуулсан
1	2001	5274,8	6418,4	121,7	1143,6
2	2002	5985,9	6423,0	107,3	437,1
<b>ДҮН</b>					<b>1580,7</b>

**ӨР АВЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлт	2001	2002
Шимтгэлийн орлого	6418,4	6423,0
Өр авлага	404,8	570,0
Нийт авлагад эзлэх хувь	6,3	8,8

Өр авлагын хувьд нийт орлогын 10 хувиас хэтрэхгүй байгаа нөхцөлд урсгал өр гэж системийн хэмжээнд үзэж байгаа болно.

2002 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар нийтдээ 570,0 сая төгрөгний авлага байна. Энэ өр авлагын 380,5 сая төгрөгний урсгал өр юм.

**Нийгмийн даатгалын хэлтсийн 2001 -2002 онд хийсэн ажлын тайлан**

Өр барагдуулах ажлын хүрээнд хур өр буюу үүсээд удсан өрнөөс 132,7 сая төгрөгний өрийг барагдууллаа.

Шимтгэлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж өр авлагатай 92 ажил олгогчийн дансыг хааж, тайлан мэдээ хугацаа хоцруулсан 14 ажил олгогчид 425,0 мян/төгрөгний торгууль тавьж бүх өртэй газар алданги тооцож албан бичиг хүргүүлэв.

Ихээхэн өртэй 19 ажил олгогчийн дарга захиралтай хэлтсийн дарга биечлэн уулзаж хэлцэл хийж протокол үйлдлээ. Оны эхний өрийг 225,3 сая төгрөгөөр буюу 55,7 хувиар буулгасан байна. 2002 оны 4-р улирлын байдлаар шимтгэлийн авлагын 245,3 сая буюу 41,3 хувь нь сар дамжсан өр байна. Энэ хугацаанд 6 байгууллагын 88,4 сая төгрөгийн өрийг шийдвэрлүүлэхээр прокурор, шүүхийн байгууллагад шилжүүлсэн болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албатай хамтарч ажиллан 10,8 сая төгрөгийн өрийг барагдуулсан юм. ШШБГ-ын төлөөлөгчтэй баасан гариг бүр хамтарч явж ажиллаж байна.

8,1 сая төгрөгийн найдваргүйд тооцогдох авлагатай 43 ажил олгогчийг эрэн сурвалжлуулахаар эрүүгийн цагдаагийн газарт материалыг бүрдүүлэн хүргүүлээд байна.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 839 иргэнийг хамруулж нийт 20,4 сая төгрөгний орлого оруулсан байна.

Тус хэлтэс нь сүүлийн 2 жилд Нийслэлийн нийгмийн даатгалын газарт төвлөрүүлэх хөрөнгийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн юм.

**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙДАЛ**

Д/д	Он	Нийслэлийн нийгмийн даатгалын газарт төвлөрүүлсэн хөрөнгө / сая төгрөг/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөнөөс давуулсан хувь	Хувь
1	2001	2801,2	3456,0	654,8	123,4
2	2002	3087,0	3571,8	484,8	115,7
ДҮН		5888,2	7027,8	1139,6	

**Гурав: Тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт олголтын талаар**

Тэтгэврийн талаар

Нийт 16 хорооны 10019 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг хариуцан өөрчлөлт сунгалт тооцоо хийлээ. Үүнд:

**Өөрчлөлт сунгалтын тооцооны талаар:**

**ТЭТГЭВРИЙН СУНГАЛТ, ХӨДӨЛГӨӨН**

Үзүүлэлт	2001	2002
ТД,ТА-ны тэтгэврий сунгалт	1614	2245
Шилжиж ирсэн	581	533
Шилжиж явсан	419	377
Тэтгэвэр зогсоогдсон	466	592
Тэтгэврийн өөрчлөлт	7939	11076

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 193 дугаар тогтоолын дагуу тэтгэврийн өөрчлөлтөөр 10 сард олгож байсан тэтгэвэр 50,5 сая төгрөгөөр нэмэгдлээ. Мөн жил бүр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэж тус хэлтэс өөрийн бүрдүүлсэн сангаас тэтгэвэр, тэтгэмжийн бүрэн гомдол чирэгдэлгүй олгох арга хэмжээг байнга авч ирсэн.

**ШИНЭ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСОН БАЙДАЛ**

Д/д	Он	Өндөр насны		Тахир дутуу	Тэжээгчээ алдсны	Цэргийн албан хаагчийн	Бүгд
		Шинэ	ХЗАлбанаас				
1	2001	353	112	154	83	40	742
2	2002	366	85	190	124	41	806

**Тэтгэвэр олголтын талаар :**

Тус дүүргийн хэмжээнд нийт тэтгэвэр авагчдын сарын тэтгэврийг тооцооны 5 кассаар олгож үйлчилж байгаа бөгөөд тэтгэврийг сар бүрийн эхний хоногуудад саадгүй тавьж байна.

**ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ОЛГОЛТ**

Д/д	Тэтгэвэр тэтгэмжийн төрөл	2001		2002	
		Хүний тоо	Дүн /сая төг/	Хүний тоо	Дүн /сая төг/
1	Өндөр насны тэтгэвэр	6769	2044,8	6969	2056,9
2	Тахир дутуугийн тэтгэвэр	1137	211,0	1165	321,0
3	Тэжээгчээ алдсны тэтгэвэр	1146	205,4	1175	301,1
4	ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ТД-н тэтгэвэр	119	40,0	124	45,0
5	ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ТА-ны тэтгэвэр	24	7,1	29	9,0
6	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	824	323,2	843	422,0

Улаанбаатар хот 2002 он



**Нийгмийн даатгалын хэлтсийн 2001 -2002 онд хийсэн ажлын тайлан**

7	Оршуулгын тэтгэмж	396	46,5	410	68,8
8	ХЧТА-ны тэтгэмж	4031	62,5	3638	75,1
9	Жирэмсэн амаржсаны тэтгэмж	383	67,7	296	75,0
10	ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧТА-ны тэтгэмж	57	6,4	30	44,0
11	Ажилгүйдлийн тэтгэмж	755	234,6	545	131,0
12	Сургалтын төлбөрт	11	0,212	21	1,0
	<b>Бүгд</b>	<b>15652</b>	<b>3249,4</b>	<b>15245</b>	<b>3549,9</b>

Тэтгэврийн тогтоолт олголтын тайланг хугацаанд нь хороо кассаар нэгтгэн гаргаж тэдгээрийг даатгалын сангийн харилцахын дүнтэй тохируулан ерөнхий ня-богоор баталгаажуулж санхүүгийн баримтанд хавсаргав.

**Тэтгэврийн хяналт шалгалтын талаар:**

Тэтгэврийн олголтыг сар бүр дискээр зөөн авчирч шалгалт явуулан дүнгээ тааруулж, тэтгэврийг массивтай нь тулган зөрүүтэй, дэвтэр олдоогүй, сунгалтын хугацаа дууссан зэрэг зөрчилтэй тэтгэвэр авагчдыг шүүж касснаас тодруулан тэтгэврийг нь зогсоон тооцоо хийв.

**ШАЛГАСАН МАТЕРИАЛЫН СУДАЛГАА**

Үзүүлэлт	2001	2002
Материалын үндэслэлийн шалгасан тоо	24	26

**ЗӨРҮҮТЭЙ ОЛГОГДСОН ТЭТГЭВРИЙН СУУТГАЛЫН СУДАЛГАА**

Үзүүлэлт	2001		2002	
	Хүний тоо	Дүн /мян төг/	Хүний тоо	Дүн /мян төг/
Тэтгэвэр олголтыг массивтай тулган зөрүүтэй олгогдсон тэтгэврийн суутгал	29	935,3	7	825,1

"Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай" 2002 оны 6-р сарын 20-ны өдрийн хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх УНДЕГазрын даргын 2002 оны 63-р тушаалын дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосны дараа 1995 оноос хойш ажил хөдөлмөр эрхлэж Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх журмын дагуу 9-р сарын 1 -ний байдлаар 305 хүний тэтгэврийг өөрчлөн 1,2 сая төгрөг нэмж олгоод байна.

**Дөрөв: Эрүүл мэндийн даатгал**

**ЭМД-ЫГ ТӨР ХАРИУЦАХ ИРГЭДЭД ҮЙЛЧИЛСЭН ТОО**

Д/д	Үзүүлэлт	2001	2002
1	16 хүртэлх хүүхэд	37350	39892
2	Тэтгэрээс өөр орлогогүй иргэн	8652	9080
3	Хүүхдээ асрах чөлөөтэй эхчүүд	866	969
4	ТД-ийн тэтгэвэр авагч иргэн	1536	1555
5	Халамжийн тэтгэвэр авагч иргэн	829	852
	Бүгд	49233	52348

Эрүүл мэндийн даатгалыг төр хариуцах даатгуулагчдын үндсэн мэдээллийг бүрдүүлэн баталгаажуулах, сунгах, иргэдийг шинээр хамруулах, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бүх мэдээллийг бүрэн оруулан эрүүл мэндийн сайн дурын даатгалын тооцоог өдөр бүр ерөнхий ня-бо-н харилцахын дүнтэй тохируулан тооцоо нийлж ирлээ.

Мэргэжлийн сургуульд суралцагч оюутан сурагчдыг эрүүл мэндийн даатгалд заавал хамруулах ажлыг зохион байгуулж сургуулиудад бичиг явуулах сурталчилгааг явж хийх, мөн оюутны холбоотой хамтарч ажиллаа.

**ОЮУТАН СУРАГЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАЛТ**

*/сая төгрөгөөр/*

Он	2001	2002
Оюутан сурагчдын тоо	1813	1330
Хураамж	8,5	5,0

**ЭМД-ЫН ГЭРЧИЛГЭЭГ СУНГАЖ БАТАЛГААЖУУЛСАН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ХӨДӨЛГӨӨН**

*/Хүний тоогоор/*

Д/д	Үзүүлэлт	2001	2002
1	ЭМД-ийн гэрчилгээ сунгасан тоо	13565	12082
2	Шилжиж ирсэн	835	909
3	Шилжиж явсан	576	505

Даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хугацаа тэтгэмж олголтонд хяналт тавьж дүүргийн хэмжээнд эмнэлэг хөдөлмөр магадлалын ажлыг зохион байгуулж үйлдвэрлэлийн ослын талаар ажил олгогчийн гаргасан баримт бичиг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан акт дүгнэлтийг үндэслэж ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэн хяналт тавьж тэтгэмж олголттой холбогдсон бүртгэлийг хөтөлж тайлан мэдээ гаргах, ажил олгогч эмнэлгийн байгууллагад мэдээлэх сурталчилгаа хийх, олгож байгаа эмнэлгийн хуудсанд хяналт тавьж ажиллаж ирлээ.

**ЭМД-ЫН САЙН ДУРЫН ДААТГАЛ**

Үзүүлэлт	2001		2002	
	Хүний тоо	Дүн /сая төг/	Хүний тоо	Дүн /сая төг/
Сайн дурын даатгал	3352	30,9	3192	29,0
Оюутан	1813	8,5	1311	5,5
Бүгд	5165	39,4	4504	34,5

Даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хугацаа тэтгэмж олголтонд хяналт тавьж дүүргийн хэмжээнд эмнэлэг хөдөлмөр магадлалын ажлыг зохион байгуулж үйлдвэрлэлийн ослын талаар ажил олгогчийн гаргасан баримт бичиг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан акт дүнэлтийг үндэслэж ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэн хяналт тавьж тэтгэмж олголттой холбогдсон бүртгэлийг хөтөлж тайлан мэдээ гаргах, ажил олгогч эмнэлгийн байгууллагад мэдээлэх сурталчилгаа хийх, олгож байгаа эмнэлгийн хуудсанд хяналт тавьж ажиллаж ирлээ.

Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл дээрхи Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд тогтмол оролцон хяналт тавьж байна.

**ГРУПП ТОГТООЛГОСОН ХҮНИЙ ТОО**

Он	2001	2002
Хүн	1450	1547

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийг шинэчилэн баталж ажиллуулсан болно.

**ТЭТГЭМЖИЙН ТАЛААР**

Д/д	Тэтгэмжийн төрөл	2001		2002	
		Хүний тоо	Дүн /сая төг/	Хүний тоо	Дүн /сая төг/
1	ХЧТАлдсны	4031	62,5	4360	72,1
2	Жирэмсэн амаржсаны	383	67,7	361	75,3
3	ҮОМШӨ-ний даатгалын сангаас ХЧТА	57	6,4	37	3,8
4	Ажилгүйдлийн	755	23,5	613	21,8

**Тав: Хяналт шалгалт, сурталчилгааны талаар**

Нийгмийн даатгалын хэлтэс нь дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллага дээр нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилт, шимтгэл оногдуулалт, сар улирлын хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж буй эсэх, шимтгэл төлөлтийг

сар улирлын тайлан тооцоо анхан шатны бүртгэлийн хөтлөлт тэтгэврийн материалыг үнэн зөв бүрдүүлж байгаа эсэх, Нийгмийн даатгалын дэвтрийн хөтлөлт баталгаажуулалт зэрэг асуудалд хяналт шалгалтын ажлыг чиглүүлэн зохион байгуулах зорилт тавьж ирлээ.

Хэлтсийн зүгээс хийж буй хяналт шалгалтын ажлын баримтын болон шалган зааварлах хэлбэрээр, хамтарсан /2 -оос дээш хүнтэй/ байдлаар хийсэн.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН СУДАЛГАА**

Он	2001	2002
Шалгасан ажил олгогчийн тоо	159	198
Илрүүлсэн төлбөр зөрчил	55154.4	31281.9
Актын биелэлт %	98.1	100,0

Хэлтэс нь ажил олгогчийн шимтгэл төлөлтийн сар улирлын тайланг хугацаанд нь бүрэн гүйцэт авч тооцоог бодоход хяналтын ажлыг чиглүүлж байгаа бөгөөд шимтгэл төлөлтийн сарын тайлан авалт 60 - 91,5 хувийн биелэлтэй явж ирлээ.

Нийгмийн даатгалын хэлтсээс шалгалт хийсэн бүх байгууллагадаа ямар нэгэн хэмжээгээр НД-ын хууль, тэтгэврийн шинэчлэл, нэрийн дансны хуулийг сурталчлан танилцууллаа.

Тус хэлтсээс тайлангийн хугацаанд 14311 хүнд нэрийн данс нээхээс 12885 хүнд нэрийн данс нээлээ. НД-д хамруулах ажлын хүрээнд нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлан ойлгуулах ажлыг зохион байгуулан 960 аж ахуйн нэгжид сурталчилгаа хийж гарын авлага тарааж олгов.

Радио телевиз хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг тогтмол явуулан хэлтсийн ажлын мэдээллийг тухай бүр мэдээлж ажиллаж байна.

Ажил олгогч, даатгуулагчдад хуулийн зөвлөмж гарын авлагын асуулт хариултын хэлбэрээр гаргаж хүргүүлж ирлээ.

Дээрхи ажлуудын үр дүнд шимтгэлийн орлого, ажил олгогч, даатгуулагчийн тоо жил бүр өссөн юм.

**АЖИЛ ОЛГОГЧ ДААТГУУЛАГЧИЙН ТОО**

Он	Ажил олгогч	Заавал даатгуулагч	Сайн дурын	Бүгд
2001	1309	37394	606	42733
2002	1415	39590	839	44891

**Зургаа: Нийгмийн даатгалын сангийн тайлан мэдээ хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаа дотоод ажлын талаар**

Тус хэлтэс нь НД-ын сангуудын болон үйл ажиллагааны тайлан мэдээг зохих журам аргачлалын дагуу гаргаж НД-ын тухай хуулинд заасан хугацааны дотор ННДГ-т тушааж тайлагнаж ирлээ.

НДын сангуудын болон хэлтсийн үйл ажиллагааны харилцах дансны хуулгыг санхүүгийн үндсэн баримттай нь тулган шалгаж, боловсруулалт хийж улмаар ня-бо бүртгэлийн үндсэн маягт ба ерөнхий дэвтрийг бүрэн хөтлөж хэвшсэн юм.

Ажил олгогчоос тус хэлтсийн харилцах дансанд шилжүүлсэн шимтгэлийн үндсэн баримтыг үндэслэн компьютерт шивж тооцоог бодож, харилцахын орлого зарлагын тайланг нэгтгэж гаргаж байна.

Түүнчлэн харилцахын орлогыг байцаагч нараар өдөр өдрөөр нэгтгэн гаргаж мэдээллээр ханган ажилладаг.

ННДГ-ын санд хөрөнгө төвлөрүүлж зохицуулах ажлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэж байна.

Шимтгэлийн орлого зарлагын сарын мэдээг хугацаа хожимдуулахгүй өгч мэдээнд дүгнэлт гарган ажиллаж ирлээ.

Ажилчдын нийгмийн асуудалд анхаарч жил бүр гэр хороололд амьдардаг ажилтануудад тус бүр 30000 төгрөгийн түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт олгодог ба 2002 онд ажилчдад зуслангийн байшин барих 1600м газрын зөвшөөрөл авч өгөөд байна.

Хэлтсийн ажилтануудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн судалгаатай болов.

Ажилтануудыг спортын зааланд 7 хоног бүр тоглуулах боломжоор хангалаа.

Жил бүр ажлаар түрүүлсэн ажилтануудыг байгалийн сайханд аялуулж хэвшлээ.

Хэлтсийн даргын тушаал, хэлтсийн ажлын төлөвлөгөө , дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтэнд байнгын хяналт тавин, хариутай бичиг иргэдийн өргөдөл гомдолыг шийдвэрлэх ажлын гүйцэтгэлийг ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулж хүн бүрээр тооцож байна.

Хэлтсийн дотоод журам, дүрмийг хөдөлмөрийн болон төрийн албаны хуульд нийцүүлэн шинэчлэн хийж дүүргийн Засаг даргаар батлуулаад байна.

Тайлангийн хугацаанд жил бүрийн үйл ажиллагааны зардлыг хэтрүүлээгүй эд хариуцагчийн касс, материалын тайланг сар бүр орлого зарлагын баримттай нь тулган шалган авч тооцоог бодож ирсэн байна.

Няравын хариуцаж буй үнэт цаас, маягтыг улирал бүр тоолж тооцоог бодож хэвшлээ.

2002 онд тус хэлтсээс Эрүүл мэндийн тэргүүний ажилтанаар 1, Хөдөлмөр нийгэм хамгааллын тэргүүний ажилтанаар 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 1 хүн шагнагдсан байна. Мөн энэ хугацаанд 4 хүн ямар нэгэн дээд боловсролыг эзэмшлээ.

2002 онд Удирдлагын акедемид 1хүн, /өмнө нь худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль төгссөн/ Санхүү эдийн засгийн дээд сургуульд 1 хүн суралцаж /МУИС-ийн математик -физик төгссөн/ байна.

Үйлчилгээний ажилчин 4 хүнээс бусад нь дээд мэргэжилтэй 9 эрэгтэй 17 эмэгтэй ажиллаж байна.



“ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙСЛЭЛИЙН САЛБАР  
ХОРООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2001-12-13.

Монгол улсын Засгийн Газрын 2001 оны 16 дугаар тогтоолын дагуу нийслэлийн Засаг даргын 115 тоот захирамж гарч, “Тахир дутуу иргэдийг дэмжих жил”-ийн ажлыг нийслэлд зохион байгуулах салбар хороо, дүүргүүдэд салбар зөвлөл байгуулагдан, жилийн ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж ирлээ.

“Тахир дутуу иргэдийг дэмжих жил”-ийн ажлын нээлтийн ажиллагааг 3 дугаар сарын 11 нээс 4 дүгээр сарын 12-ны хугацаанд нийслэл, дүүргүүдэд нийт 1600 гаруй хүнийг оролцуулан соёл урлагийн болон хандив тусламжийн арга хэмжээг зохион байгуулан сурталчлав.

Нийслэлийн салбар хорооны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хариуцах байгууллага, албад, дүүргийн салбар зөвлөлийн дарга нарыг оролцуулсан өргөтгөсөн хурал, нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөлгөөнөөс жилийн ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг даалгаврыг тогтмол өгч, тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах Үндэсний хороонд тогтоосон хугацаанд ажлаа тайлагнан, тус хорооны 11-р сарын 1-ний өдрийн хуралд Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдээс нэрэмжит жилийн ажлыг зохион байгуулж байгаа тухай сонсгол мэдээллийг хэлэлцүүлж дүгнүүллээ.

Мөн жилийн ажлыг зохион байгуулах Үндэсний хороо, аймаг нийслэл, дүүргүүдийн хамтран зохион байгуулсан урлаг хөдөлмөр бүтээлийн “Бид бүхнийг чадна” өдөрлөгийн ажиллагаанд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүргүүдийн салбар зөвлөлүүд идэвхтэй оролцож, тахир дутуу иргэдийг өргөн хамруулав.

Нэг. Нийслэл дэх тахир дутуу иргэдийн өнөөгийн байдал

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистик, мэдээлэл судалгааны газрын 2001 оны эхний хагас жилийн мэдээгээр Улаанбаатар хотод нийт 14797 тахир дутуу хүн байгаа, үүнээс 7488 нь эмэгтэй, 605 нь хэлгүй, дүлий, үүнээс 249 нь эмэгтэй, хараагүй 282, үүнээс 101 нь эмэгтэй, 13910 нь бусад эрхтний согогтой тахир дутуу хүмүүс байна.

Нийт тахир дутуу хүмүүсийн 2588 нь төрөлхийн, 12209 нь олдмол шинж чанартай, үүнээс 1998 нь үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан, сэтгэцийн өвчтэй 3338, хөдөлмөрийн чадвараа 50-70 хувь алдсан 7226 хүн байгаа юм.

Тахир дутуу хүмүүсийг насны ангиллаар авч үзэхэд 0-15 насны 722, хөдөлмөрийн насны 13156, хөдөлмөрийн нас хэтэрсэн 919 хүн байна.

Цаашид тахир дутуу иргэдийн судалгааг бодитой болгох зорилгоор нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр нийгмийн хамгааллын албанаас Стастикийн албатай хамтран боловсруулсан аргачлалыг үндэслэн, шинэчилсэн мэдээллийн сантай болов.

## Хоёр. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын талаар

Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд нийгмийн даатгалын хамгаас 11967 тахир дутуу хүнд 1200,0 сая төгрөгийн, нийгмийн халамжийн хамгаас 3293 хүнд 211,9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, үүнээс 542 хүнд байнгын асрамжинд байдаг тахир дутуу хүүхдээ асарсны тусламжинд 16,9 сая төгрөгийн, 365 хүнд 6,2 сая төгрөгийн байрны талбайн хөлсний, 1064 хүнд 26,5 сая төгрөгийн түлээ нүүрсний, 265 хүнд 15,4 сая төгрөгийн протези тоотопедийн хэрэгсэлийн үнийн хөнгөлөлт үйлчилгээг үзүүлж, магнитофон сонсголын аппарат олгох, телефон утасны, рашаан сувилалд сувилуулах бардлын 50 хувийн нэг удаагийн хөнгөлөлт зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд Олон улсын Энэрлийн байгууллага, бусад байгууллагын шугамаар хүнд, бүгд нийт 151,7 сая төгрөгийн үнэтэй тэргэнцэрийг 428 хүнд, 921 хүнд 32,2 сая төгрөгийн сонсголын аппарат олгоод байна.

Одоогоор нийслэлийн хэмжээнд дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдлүүдийг түшиглэн тахир дутуу иргэдийн нөхөн сэргээх эмчилгээний 8 кабинет, төв ажиллаж байгаа бөгөөд энэ онд одоогийн байдлаар бүгд 6607 хүн эмчилүүлснээс, 4059 нь амбулаторийн, 1387 нь хэвтэж, 2705 нь нөхөн сэргээх эмнэлгийн үйлчилгээнд хамрагджээ.

Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших тулгар эрхтний согогтой хүүхдийн сувиллын 10-р яслийн үйл ажиллагааг өргөжүүлэн 2 анги нээн ажиллуулахад засгийн газраас 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт авч, дүүргийн төсвөөс 2,0 сая төгрөг гарган зарцуулав.

“Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн холбогдох заалт, дэмжих жилийн ажлын хүрээнд нийслэлийн хот байгуулалт эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зайлшгүй шаардлага хэрэгцээтэй зарим байгууллага, нийтийн үйлчилгээний газруудад тахир дутуу хүмүүст зориулсан шат, зам гарц байгуулах ажлын зураг, төсөв төлөвлөн хэрэгжүүлснээр одоогийн байдлаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр эрхлэлтийн газар, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар, Улсын нийгмийн халамжийн газар, Сансрын үйлчилгээний төв зэрэг газруудад тахир дутуу иргэдийг зорчиход зориулсан шат, гарц байгуулагдав.

## Гурав. Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын нэг үндсэн чиглэл нь тэдний ажиллах чадвар, мэргэжил бололцоонд тулгуурласан хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нийслэл, дүүргийн Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлэх явдал байв.

Тахир дутуу иргэдийг ажлын байраар хангах “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 111 зүйлийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба, дүүргийн Хөдөлмөрийн албадад тодорхой чиглэл өгч ажилласнаар энэ онд 50-иас дээш ажилтантай 438 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийж, 203 хүнийг хөдөлмөрт зуучлан, 154 хүнийг ажлын байраар хангаж, 74 хүнийг мэргэжлийн сургалтанд хамруулсан байна.

Үйлдвэрлэлийн осол, аваараас урьдчилан сэргийлэх, ажиллагсдын хөдөлмөрийн нөхцлийг хангах зорилгоор нийслэлийн бүх дүүргүүдэд





## Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр Occupational Training Enterprise for the Blind People

200.2 оны 11 дугаар  
сарын 18 - ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар 210136  
Утас: 344701, 341573, 341657

### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Тахир дутуу иргэдийг дэмжих жил  
2001 оны ажлын тайлан

Тус үйлдвэр 1990-ээд онд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны /хуучин нэрээр/ харьяанд байснаа Засгийн газрын 1997 оны 37 дугаар тогтоолоор Нийслэлийн засаг даргын харьяалалд шилжсэн тахир дутуу иргэдийг зохион байгуулалттайгаар ажлын байраар хангадаг төрийн өмчит улсын үйлдвэрийн газар юм.

2001 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар тус үйлдвэрт 95 хүн ажиллаж байгаагийн 80 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр авахын зэрэгцээгээр үйлдвэрт ажилладаг тахир дутуу хүмүүс юм. Үйлдвэрийн удирдах болон аж ахуй үйлчилгээний хэсэг, эсгий цехэд нарийн мэргэжил шаардагдах зарим орон тоонд 30 гаруй хараатай хүн ажилладаг.

Үйлдвэрийн ажилчдын 48-н айлын орон сууцанд хараагүй ажилчдын 70-н өрх, тэдгээрийн гэр бүлийн 360 гаруй хүн амьдардаг.

Одоо жижиг эдлэл, мужаан, оёдол, эсгий зэрэг тасаг ажиллуулж эсгий, иж бүрэн монгол гэр, гэрийн бүх төрлийн бүрээс, ажлын бээлий, хөшиг, ор хөнжлийн даавуу, зулхай хөнжил, эсгий гудас, хөдөлмөр хамгааллын хувцас, хялгасан хошлон, оосор, чагтага, дэрс, хялгас, мяндсан шүүр, цас арилгагч зэрэг 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Үйлдвэрийн дэргэд ажилчдад хөнгөлөлттэй хоолоор үйлчилдэг гуанз, соёл үйлчилгээний болон чийрэгжүүлэх танхим, үйлдвэрийн эмч ажилладаг.

Монгол улсын засгийн газраас 2001 оныг тахир дутуу иргэдийг дэмжих жил болгон зарлан зохион байгуулж төр засаг, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн хамт олны зүгээс тахир дутуу иргэдэд сэтгэл санаа, эд материалын дэмжлэг туслалцаа үзүүлж, олон талт арга хэмжээ авсны дотор нийгмийн зүгээс тахир дутуу иргэдэд хандах хандлага, сэтгэл зүйн эерэг, нааштай өөрчлөлт гарсан хамгийн чухал зүйл юм. Засгийн газраас манай үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, санхүүгийн гуламж үзүүлэх зориулалтаар 25 сая төгрөг олгосон нь тус үйлдвэрийг цаашид хэвийн ажиллах боломжийг бүрдүүлэв.

Энэ тусламжаас үйлдвэрийн байр, ажилчдын орон сууцны барилгын засвар, гадна дулааны холболтын засварт 4.3 сая, үйлдвэрлэлд 7.7 сая төгрөг зарцууллаа. Жилд 11.0 мянган метр эсгий үйлдвэрлэх хүчин

чалалтай эсгийний цех ашиглалтад орсноор тус үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт борлуулалтын хэмжээ дахин нэмэгдэх боломжтой болов,

2001 онд тус үйлдвэр 27 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 24.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оныхоос өсөлттэй байна. Тахир дутуу иргэдийг дэмжих жилд зориулсан “Бид бүхнийг чадна” сэдэвт өдөрлөгт тус үйлдвэр бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, урлагаар амжилттай оролцож тэргүүн байр эзэллээ.

Монгол улсын Ерөнхийлөгч Б.Багабанди 2001 оны эцсээр манай үйлдвэрт хүрэлцэн ирж хараагүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдалтай танилцан үйлдвэрийн хэтийн чиглэл, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар засгийн газарт чиглэл өгсөн нь чухал үйл явдал болов.

2001 онд манай үйлдвэр дээр Япон, Солонгос, Орос улсын тахир дутуу иргэдийн байгууллагуудын төлөөлөгчид ирсний зэрэгцээ Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөр тус үйлдвэрийн оёдлын цехэд 27.5 мянган ам долларын төсөл хэрэгжүүлж эхлээд байна.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын хүрээнд гарсан бас нэг ололт нь тус үйлдвэрийн нийт ажилчид, ажил хариуцсан хүмүүс үйлдвэрийнхээ төлөө, хараагүй хүмүүсийн төлөө ажиллаж амьдарч байгаагаар чин сэтгэлээсээ мэдэрч тэдний идэвх зүтгэл, санаачлага, хариуцлага, сахилга батад нааштай эхлэл, өөрчлөлт гарч үйлдвэрийн үйл ажиллагаа цаашид хэвийн явагдах эхлэл суурь тавигдсан явдал юм.

Хараагүй 100 шахам хүнийг ажлын байр, орон сууцаар ханган төрөөс тэдэнд үзүүлэх халамж үйлчилгээг хэрэгжүүлж байдаг тус үйлдвэрийн дулаан, цахилгаан, уур усны зардлын 50 хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлж байхаар Монгол Улсын Засгийн Газрын 1997 оны 37 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолын дагуу зөвхөн өнгөрсөн онд Нийслэлийн төсвөөс 26 сая төгрөг гаргаж тус үйлдвэрийн дулаан, уур усны төлбөрийг хаахад туслалцаа үзүүлсэн.

Нийслэлийн Засаг Дарга 2001 оны 5-р сард нийслэлийн төсвөөс санхүүждэг сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хот тохижуулах газрын хэрэгцээт ажлын хувцас, ор хөнжлийн даавуу, цэвэрлэгээний материал, багаж хэрэгслийг манай үйлдвэрээр бэлтгүүлэн нийлүүлж байх заалт бүхий захирамж гаргасан нь чухал арга хэмжээ болов. Энэ захирамжийг хэрэгжүүлэхэд БГД-ийн Засаг дарга н.Зоригт ихээхэн санаачлага гаргаж манай ажилчдын үйлдвэрлэсэн 200 ш цас цавчигчийг дүүргийнхээ хот тохижуулах алба, хороодод хуваарилан олгосноор 600.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн борлогдсон. Гэвч бусад дүүргүүдийн Засаг дарга нар, холбогдох хүмүүс энэхүү захирамжийг хэрэгжүүлэхэд төдийлөн анхаарал тавихгүй байна.

Үйлдвэрийн Захиргаа ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тахир дутуу иргэдэд үзүүлэх халамж үйлчилгээг сайжруулах нь 2001 оны хувьд чухал ач холбогдолтой гэж үзэж энэ чиглэлээр дараах ажлыг зохиов.

Манай үйлдвэр орлогоороо зарлагаа нөхөж ажиллах ёстой боловч тахир дутуу хүмүүст нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө

алдагдалтай ажиллаж байгаа хэдий ч тахир дутуу иргэдийг дэмжих жилийн хүрээнд эрсдэлтэй гэмээр алхам саяхан хийлээ.

Үйлдвэрт ажилладаг хараагүй нэг ажилчин сард цаг, зэргийн цалин 18000 төгрөг авдаг байсныг 2001 оны 11-р сарын 01-нээс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүргэж 24750 төгрөг болгож нэмэгдүүллээ. Ингэснээр сарын цалингийн фонд 600000 төгрөгөөр өсч байгаа юм. Энэ өсөлтийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр хангах тооцоо хийсэн.

2001 онд үйлдвэрийн зардлаар 80 гаруй ажилчдыг Нарийний сүүний сувилалд 2 хоног амраасны зэрэгцээ Улсын Нийгмийн халамжийн газарт хүсэлт тавьж 12 ажилчныг тус сувилалд хөнгөлөлттэй сувилууллаа. Мөн Сэргээн засварлах Клиникт хараагүй, тахир дутуу 6 хүнийг 14 хоногийн хугацаатай үнэ төлбөргүй эмчлүүлэв.

БГД, СБД-ээс мэргэжлийн эмч урьж давхардсан тоогоор 120 хүнийг нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэгт хамруулсны зэрэгцээ эх, нялхсын баяраар үйлдвэрийн 48-н эмэгтэй, 72 хүүхдийг хүлээн авч 70.0 мянган төгрөгийн бэлэг дурсгал, хичээлийн хэрэгсэл олгов.

Үйлдвэрт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч 200.0 мянган төгрөгийн хүнсний зүйл өглөө. Мөн ивээн тэтгэгч гадаадын болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хандивласан 1 тн шахам цагаан будаа, 800 кг гоймон болон 1.6 сая төгрөгийн хүнсний зүйл, бэлэн хувцсыг ажилчид, тэдний хүүхдэд олгожээ.

Ажилчид, тэдгээрийн гэр бүлийн 120 гаруй хүний үсийг үнэ төлбөргүй засуулсныг цаашид уламжлал болгох юм.

Дэлхийн цагаан таягтны өдөр, Эмэгтэйчүүдийн баяр, Залуучуудын байгууллагын 80 жилийн ой зэрэг тэмдэглэлт өдрүүдэд ажилчдын дунд уулзалт, үдэшлэг зохиож бүжиг, шатар, даам, үндэсний бөх, гүйлтийн тэмцээн зохион байгууллаа.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлыг дүгнэх, 2002 оны шинэ жилийн баярыг урьд жилүүдээс нилээд өвөрмөц хэлбэрээр тэмдэглэлээ.

Үйлдвэрийн аврагаар 5 хүнийг шалгаруулж, тэргүүний 15 ажилтанд үйлдвэрийн оёдолчдоор хувцасны хослол хийлгэж шагнаж урамшуулсны зэрэгцээ “Хүний төлөө” сангийн тэргүүн, тэргүүн хатагтай н.Оюунбилэгийн өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг 80-н хүнд гардуулав.

Ардын хувьсгалын 80 жил, Монголын хараагүйчүүдийн ҮI их хурлын үеэр хөдөлмөрийн хүндэт медиалаар 2 хүн, Ардын хувьсгалын 80 жилийн ойн медиалаар 70 хүн, НХХЯам, Нийслэлийн Засаг даргын шагналаар 5 хүнийг шагнуулж урамшуулжээ.

Гэр, оронгүй 3 хараагүй ажилчинд орон сууц, гэр олгосон. Нийтдээ ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 2001 онд 1400.0 мянган төгрөг зарцуулжээ.

Хараагүй хүнд зориулж үйлдвэр, ажилчдын байр, хоолны газрыг холбосон тусгай зориулалтын 100 гаруй метр зам тавигдсанаас гадна дунд гол дээрх манай ажилчдад зориулсан гүүрийг УИХ-ын гишүүн О.Сүрэнгийн санаачлагаар УБ хотын суудлын вагон депогийнхон төмөрлөж өгсөн юм.

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын хүрээнд ХХХС-ын үйлдвэрээс зохиосон ажлыг товч тайлагнахад ийм байна.

Цаашид НХХЯам, Нийслэлийн зүгээс тус үйлдвэрийн талаар дараах арга хэмжээ авахыг хүсч байна.

1. Үйлдвэрийн ирээдүйн чиглэлийг зөв тодорхойлох, хараагүй хүмүүс хийж чадах шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн дорвитой үнэлгээ судалгаа хийх, хараагүй залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах, тэдний эрүүл мэнд, ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулахад гадаад дотоодын ивээн тэтгэгчид, олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байна. Үүний тулд МТДИҮХолбооны шугамаар Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх 1 сая ам долларын төслөөс тус үйлдвэрт дээрх чиглэлээр 50.0 мянган ам долларын төсөл хэрэгжүүлэх

2. 2002 онд Нийслэлийн төсвөөс манай үйлдвэрийн уур, ус, дулаан, цахилгааны зардлыг хаахад 20.0 сая төгрөг батлагджээ. Энэхүү төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж зөв ашиглах нь бидний үүрэг гэдгийг ойлгож байна.

Харин Ерөнхийлөгч Б.Багабанди, Нийслэлийн Засаг дарга М.Энхболд нарыг 2001 оны 12-р сард тус үйлдвэр дээр ирэх үед тус үйлдвэрийн Захиргааны ажилтны 2002 оны жилийн цалингийн сан 8.0 сая төгрөгийг Нийслэлэийн төсвөөс санхүүжүүлж өгөхийг хүссэн бидний хүсэлтийг хэрэгжүүлж энэ онд нийслэлийн төсвөөс 28.0 сая төгрөгийн санхүүжилт хийхийг хүсч байна.



ЗАХИРАЛ

Л.Дүгэрсүрэн

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

**Сүхбаатар дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний  
төвийн 2002 оны ажлын тайлан**

2002. 12. 15.

Улаанбаатар хот

Манай хамт олон 2002 онд Монгол улсын нийгмийн халамжийн, ахмад настгны, тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулиуд, Засгийн газрын 1999 оны 36-р болон 2002 оны 72, 194 дүгээр тогтоолууд, НХХЯ, УНХГ, дүүргийн ИТХ, Засаг даргын шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа удирдлага болгон дараах ажлыг хийж гүйцэтгэв.

**Нэг. Зохион байгуулан хийсэн ажил**

1. Хийх ажлаа жил, улирлаар төлөвлөн хамт олны хурлаар хэлэлцэн баталж, зохион байгуулан гүйцэтгэж, дүнг сар бүр УНХГ, НХНХА, дүүрэгт мэдээлэн ажиллав. Энэ онд зохион байгуулалтын 9, судалж сурталчлах, хянаж шалгах 13, бусад 4, бүгд 36 ажлыг 100 % гүйцэтгэж биелэлтийг гаргалаа.
2. Нийгмийн ажилтан 6, ажилчин 5 бүгд 11 хүн хөдөлмөрийн гэрээгээр хариуцаж хийх ажил, үүргийн хуваарьтай ажилласны дотор халамжийн тэтгэвэр, хөнгөлөлт хариуцсан байцаагч Н. Дуламсүрэн "Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан" цол тэмдэг, ахмадын хорооны хүндэт тэмдгээр, аж ахуйн эрхлэгч Р. Пүрэвсүрэн "Ахмад дайчин" цол тэмдгээр, нягтлан бодогч Ц. Дуламжав Сангийн яамны "Хүндэт жуух" бичгээр ~~цаа~~агнагдаж, санхүүгийн хувьд өр авлагагүй, ямар нэг зөрчил дутагдалгүй байгууллага, хамт олон боллоо.
3. Энэ хугацаанд холбогдох дээд газруудаас 86 бичиг хүлээн авч мөрөөр нь тодорхой ажил зохиож, биелэлтийг гарган хариуг мэдээлэв Засгийн газрын 2002 оны 72-р тогтоолын дагуу Монгол улсын баатар 1, хөдөлмөрийн баатар 15, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн 17, нийт 33 хүнд 11500.0 мянган төгрөг олгов.
4. Ахмад настны хуулийн дагуу ахмад дайчин 267, хөдөлмөрийн баатар 15, ардын цолтон 6, гавъяат 65 хүнд мөнгөн тэтгэмж 23278.0 мянган төгрөг олгов. Мөн ахмад настан 258 хүнд 11976.0 мянган төгрөгний орон сууцны, 105 хүнд түлээ, нүүрсний үнэ 4997.4 мянган төгрөг 142 хүнд рашаан сувиллын хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэв.
5. Харьяалалгүй 133 ахмад настныг өөрийн байгууллагын харъяалалд авч дээрээс нь 117 ахмад бүгд 250 хүнд цагаан сараар хүндэтгэл үзүүлж цайлж хүн тус бүрт 10 кг дээд гурил өглөө.
6. Энэ онд тэжээгчээ алдсан 0-16 насны 210 хүүхэд, нийгмийн даатгалаас эрх үүсээгүй өндөр настан 108, тахир дутуу 745, бүгд 1063 хүнд халамжийн тэтгэвэр сар бүр олгож 114.9 сая төгрөг өглөө.
7. Төрөлхийн болон нийгмийн даатгалаас эрх үүсэхгүй хөдөлмөрийн чадвараа 70 хувиас дээш алдсан тахир дутуу 19 хүнд орон сууцны хөнгөлөлт 483.0 мянган төгрөг, 373 хүнд түлээ нүүрсний үнэ 21.6 сая төгрөг, 2 хүнд рашаан сувиллын үнэ 36100 төгрөг 21 хүнд хөл гарын протезийн үнийн хөнгөлөлт олголоо.
8. Ахмад настан, тахир дутуу иргэдэд хуулийн дагуу 19 хүнд 2800.0 мянган төгрөгний тэргэнцэр, 95 хүнд 3674.0 мянган төгрөгний сонсголын

- аппарат, таяг 60-ийг олгож, 385 хүнд 9221.3 мянган төгрөгний хиймэл шүд, 120 хүнд 560.4 мянган төгрөгний нүдний шил, 34 хүнд 2890.0 мянган төгрөгний нүдний болор суулгасны үнэ олгож үйлчлэв.
9. Тахир дутуу 3 хүнд 116953 төгрөгний телефоны хөнгөлөлт үзүүлж шилжиж ирсэн нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон олон хүүхэдтэй эх, өндөр настан 29 хүнд түлээ нүүрс олголоо.
  10. Нийгмийн халамжийн тэтгэмжийг жирэмсэн 950 хүнд 47025.0 мянган төг, амаржсан 967 хүнд 47866.5 мян төг, хүүхэд асарсан 3025 хүнд 36643.7 мян төг, 4 хүүхэдтэй 27 хүнд 3186.0 мян төг, 5-аас дээш хүүхэдтэй 109 эхэд 3612.8 мянган төг, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөж буй 28 хүнд 1386.0 мян төг, тахир дутуу хүүхдээ асарч байгаа 58 хүнд 1026.6 мян төг, нийт 140746.6 мян төгрөг олгож, алдарт эхийн 1-р зэргийн одон авсан 4 эх, 2-р зэргийн одон авсан 29 эхэд 740.0 мян төгрөг өглөө.
  11. Дүүргийн Засаг дарга, УНХГ-ын удирдлагын дор 54-р цэцэрлэгт халамжийн 24 цагийн хоёр бүлэг шинээр нээн ажиллуулж, нэн ядуу амьдралтай, олон хүүхэдтэй өрхийн 50 хүүхдийг хамруулан сургаж, хоолны зардлыг төлж байна.
  12. Нэн ядуу өрхийн сургуулийн насны 19 хүүхдийг хүүхдийн "Соёл" зусланд явуулж, хоолны зардалд 478800 төгрөг олгов.
  13. Дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан орон нутгийн төсвөөс 11 сая төгрөг гаргуулан халамж үйлчилгээний төвөөрөө дамжуулж орон гэргүй 10 өрхөд гэр, өвчтэй, хэвтрийн 55 хүнд эм тарианы үнэ 885.0 мян төгрөг, 25 хүнд оршуулгын зардал 1905.3 төгрөг, 100 хүнд нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж 1620.0 мян төгрөг, 10 хүнд хоол хүнс, хувцас, гэрийн бүрээсийн үнэ 362.0 мян төгрөг олгож, өдрийн сувилалд 323 ахмад настан, 30 тахир дутуу хүнийг явуулж, дүнгээр бүгд 353 хүнд 11 сая төгрөг зарцуулаад байна.
  14. Дүүргийн хүн амын эмзэг бүлгийн 192 хүнийг хамран УЗХ-той хамтарч хувцас олгох, ЭМН-тэй хамтран эмч нарын үзлэгт хамруулж, өндөр настан Бадам, Нямхүү, сэтгэл мэдрэлийн өвчтэй иргэн Шоовдорсүрэн нарыг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэв. Мөн ХЭА-тай хамтран 16 хороодод "Ажлын байр - халамж" сэдэвт өдөрлөгүүд зохиож, тэдний санал хүсэлтийг авч мөрөөр нь ажил зохиов.
  15. Хог түүдэг 25 хүүхдийг байгууллагынхаа халуун усанд тогтмол оруулж, гэр хорооллын нэн ядуу өрхийн өндөр настан, тахир дутуу иргэдийг үнэ төлбөргүй халуун усанд оруулан 310 хүнд үйлчлээд байна.
  16. Дүүргийн ахмадын хороотой хамтран ахмадын өдрөөр "Морь жилтэн"-ний өдөрлөг зохиож, нэн ядуу ахмадуудад буцалтгүй тусламж үзүүлэн 16 хүнд нүдний шил, сонсголын аппарат олгож халамжийн үйлчилгээ үзүүлэв.
  17. Эх үрсийн баяраар 80 хүүхэд хүлээн авч, 1000 төгрөгний бэлэг, 2000 төгрөг бэлнээр хүүхэд бүрт олгож, урлаг, уран сайхны тоглолт үзүүлж, олон улсын тахир дутуугийн "Бид бүхнийг чадна" сэдэвт өдөрлөгөөр тахир дутуу иргэдийн хийсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гарган шалгаруулж, шалгарсан 3 бүтээлд нийт 45 мянган төгрөгний шагнал олгов.
  18. Дүүргийн засаг дарга, УНХГ-ын шийдвэр гаргуулан 3 хүнийг Батсүмбэр дахь улсын асрамжийн газарт хүргэн өгөв.

19. АНУ-ын олон улсын Энэрлийн байгууллагатай хамтран ажиллаж, эмзэг бүлгийн 160 өрхөд үзэм, 200 хүнд ариун цэврийн оо, саван, сойз, хувцас олгож, нэн ядуу, олон хүүхэдтэй өрхийн 25 хүүхдийг байнга хооллож байна. "Нинжин сан" ХХК-аас / дарга нь Э. Ганболд / костюм, пиджак, гадуур цув, пальто өгч хүмүүст өгч тарааж өглөө.
20. Байгууллага дээрээ "Халамж – 2002" өдөрлөг зохион байгуулж зохиосон ажлаа тайлагнаж, улмаар тэргэнцэр 7, сонсголын аппарат 28, гэр 3, тусламжийн будаа 160 хайрцаг, 80 кг үзэм, хос костюм, хавар намрын пальто, гутал, юбка зэрэг хувцас олголоо.

### **Хоёр. Судалж сурталчлах, хянаж шалгах ажил**

1. Манай байгууллага 2002 онд НХС-аас 464.3 сая төгрөгний санхүүжилт авч, давхардсан тоогоор 42898 хүнд үйлчилснээс халамжийн тэтгэвэрт 114.9 сая төгрөг, тэтгэмжинд 221.7 сая төгрөг, хөнгөлөлтөнд 127.7 сая төгрөг зарцуулав.
2. Байгууллага үйл ажиллагааны зардалд дүүргээс 18.7 сая төгрөгний санхүүжилт авч 11 хүний орон тоотой ажиллаж, өөрийн орлого 900.0 мянган төгрөг оруулав
3. Улирал бүр ажлын тайлан, санхүүгийн баланс, сар бүр сангийн тайлан мэдээ гаргаж УНХГ, НХНХА, дүүрэгт мэдээлж байна.
4. Дүүргийн хүн амын доотор буй АБТДО-той өндөр настан, нийгмийн даатгалаас эрх үүсэхгүй тахир дутуу иргэд, өнчин, хагас өнчин О – 13 насны хүүхэд, орон гэргүй тэнүүчлэн амьдардаг хүмүүс, нэн ядуу өрхийн судалгаа хөтөлж компьютерт суулган хяналт тавьж байна.
5. Хамт олны дотор байцаагчид, нягтлан бодогч, ажилтнуудын ажлын тайлан хамгаалах өдөрлөг зохиож, дүгнэлт өгч байна.
6. Нийгмийн халамжийн хуулийн сурталчилгааны 2 самбар хийсэн ба байцаагч нар баримт бичгийн бүрдлийн булан байгуулан хөдөлмөрчдөд ил тод байрлуулан ашиглаж байна.
7. 1997 оноос 2002 оны НХС-ийн орлого, зарлагын байдлыг халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн төрлүүдээр хүснэгтлэн судалгаа, диаграмм гаргаж авлаа.
8. Байгууллага, хамт олноо сурталчилсан самбар, альбом, гэрэл зургийн цомогтой боллоо.
9. 2002 онд хөдөлмөрчдөөс тэтгэмжийн 1154, тэтгэврийн 109, хөнгөлөлтийн 18, бусад 232 өргөдөл, хүсэлт хүлээн авч шийдвэрлэв. ЗДТГ-аас шилжин ирсэн 32 өргөдлийг цаг хугацаанд нь шийдвэрлэв.
10. 2002 онд манай хамт олон телевизороор 3 удаа, Монголын радиогоор 2, "Өнөөдөр" сонинд 1 удаа хийж байгаа ажлаа сурталчлав. Мөн дүүргийн 16 хороон дээр хөдөлмөрчдөд ажлаа сурталчлан халамж үйлчилгээ үзүүлэв
11. Дүүргийн 16 хороо тус бүрт 1 дэвтэр тараан өгч хөдөлмөрчдийн санал хүсэлтийг бичүүлэн авч мөрөөр нь ажил зохион байгуулж, цаашид зохиох ажлын чиглэл гарган ажилладаг боллоо. Энэ үндсэн дээр энэ онд 29 өрхөд түлээ, нүүрс зайлшгүй олгох асуудлыг шийдвэрлэв.
12. Ажиллагсдын ажиллах нөхцлийг ханган байгууллага дээрээ 2 ширхэг толь, 2 зураг, 1 баг байрлуулж, нийгмийн халамжийн өдөр, шинэ жил,

ээлжийн амралтын үеэр байгууллагын өөрийн орлогоос 312260 төгрөг зарцуулав.

13. Байгууллагаас тавих хяналт шалгалтыг сайжруулан 2002 онд 141 удаа шалгалт хийж, хороод, айл өрхөөр явж гэр орон, амьдралын нөхцөл, өрхийн орлого, тахир дутуугийн байдал, өвчлөл зэргийг үзэж мөрөөр нь ажил зохиож байв.
14. Байгууллага 3 сонин, 1 сэтгүүл, "Төрийн мэдээлэл"-ийг захиалан шинэ хууль шийдвэрийг судлан, хүмүүсийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхаарч байна.

#### Гурав. Бусад ажил

1. Байгууллагын тохижилт, ариун цэврийн байдалд анхааран 4 мод. зүлэг суулгаж, нурсан газарт шавардлага хийж, халуун усны өрөө, жижүүрийн өрөөний засвар хийж 169.8 мянган төгрөгний тохижилт хийв.
2. Шүдний эмнэлэг, гараашийн түрээсийн гэрээ хийх, гал тогооны ашиглалтаас 900.0 мян төгрөгний өөрийн орлого оруулж, төсвийг 500.0 мян төгрөгөөр хэмнэв.
3. Холбоо, гэрэл бахилгаан, халаалт, цэвэр, бохир усны байгууллагуудтай гэрээ байгуулан өглөг, авлагын тооцоог сар бүр хийж, ямар нэг зөрчилгүй ажиллаж байна.
4. Цонх шиллэх, сантехникийг засварлах, худаг цэвэрлэх, дулаалга, цэвэрлэгээ хийх зэргээр өвөлжилтийн бэлтгэл хангаж, байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.
5. Канон, компьютер засуулах, автомашиныг техникийн үзлэгт оруулах, ашиглах нөхцлийг хангах, сувиллын өрөөнд хаалт, даралтын аппарат авч өгөх, тохижилт хийх, цэвэрлэгээний материал, бичгийн хэрэгслээр хангах ажлыг цаг тухай бүр хийж байна.

ДАРГА

 Б САНДАГ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



**“ ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН АЖ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН СБД-ИЙН ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙГ НХОТСЗ “ ТЭГШ ДҮҮРЭН “ ТӨСЛӨӨС 2002 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН.**

**Зорилго:** ТДИ-г нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах замаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино. Уг хөтөлбөр нь 2 үе шаттай хэрэгжих ба 2-р үе шат нь 2002-2004 оныг хамарна.

**Зорилт:** 1. Нийгэм хамт олон гэр бүлийн хүрээнд ТДИ-ийн эрүүл мэнд, сэтгэл зүй, оюун санааны нөхөн сэргээлтийн үйлчилгээг сайжруулах.

2. ТДИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсролын тусгай орчинг бүрдүүлэх.

3. ТДИ-ийн мэрэгжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг сайжруулах

4. ТДИ-ийн бие эрхтний согог засах, протез, ортопедийн хэрэгслэлийн хангамжийг сайжруулах. Зорчих, мэдээлэл солилцох боломжийн нэмэгдүүлэх.

6. ТДИ-ийн амьдралын баталгааг дээшлүүлэхэд чиглэгдсэн нийгмийн хамгаалал, халамжийн үйл ажиллагааг сайжруулах.

7. ТДИ-ийн үүсгэл санаачлагын байгууллага, хөдөлгөөнийг дэмжих, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой:

№	Асуулт	2001 он		2002 он	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	Хүүхэд өсвөр үеийнхнээс замын хөдөлгөөний осолд орсны улмаас гэмтсэн хүний тоо, хувь	310	0,86	78	0,32
2.	Хүүхэд өсвөр үеийнхнээс замын хөдөлгөөний осолд орсны улмаас нас барсан хүний тоо, хувь	2		1	
3.	Их, дээд сургуульд хамрагдсан тахир дутуу хүний тоо хувь	15	0,61	10	0,78
4.	Нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан тахир дутуу хүний тоо, хувь	584	23,6	589	46
	Үүнээс: Эмнэлзүйн нөхөн сэргээх арга/хэм хамрагдсан ТДИ-н тоо, хувь	234	-	249	19,4
	Үүнээс сэргээгдсэн эрүүл болсон хүний тоо хувь	120	51,2	141	56,6
5.	Мэрэгжлийн чиг баримжаа эзэмшсэн ТДИ-н тоо, хувь	4	0,16	13	1,01
6.	Нийгмийн халамж асрамжийн үйлчилгээнд хамрагдсан ТДИ-н тоо,	331	13,3	98	7,6

“Сүхбаатар” Эрүүл Мэндийн Нэгдэл

	хувь					
7	Рашаан сувилалд сувилуулсан тахир дутуу иргэдийн тоо, хувь	65	2,6	84	6,5	
8	Тусгай боловсрол эзэмшүүлэх чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн багш сурагч нарын тоо, эзлэх хувь	2		2		
9	Цэцэрлэг, ясли	-д хамрагдаж буй тахир дутуу хүүхдийн тоо, хувь	23	0,3	24	0,52
	Сургууль		38	-	47	0,19
10	Тусгай мэргэжлийн боловсрол эзэмшсэн тахир дутуу иргэд	7	-	8	0,6	
11	Тусгай мэргэжлийн боловсрол олгосон, төрөл хэлбэрийн өсөлтийн хэмжээ	8 хэлбэр	-	8 хэлбэр	-	
12	ТДИ-ийн зориулалттай тоног төхөөрөмжийн хангалтын байдал	Тэргэнцэр	60	1,6	8	0,62
		Протез	30	-	19	1,48
		Сонсголын аппарат	191		7	
13	Протез, ортопедийн үйлчилгээний төрөл, чанарын өсөлтийн байдал	Хиймэл хөл	10		Хиймэл хөл	2
		Гутал	7		Гутал	7
		Гар	8		Гар	-
		Нурууны бүс	1		Нурууны бүс	1
		Сонсголын аппарат	191		Сонсголын аппарат	7
		Чиг	2		Чиг	-
		Түнхний сойлт	2		Түнхний сойлт	-
Тахир дутуугийн жил байсан						
14	ТДИ-ийн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	16824928		2652810		
15	Нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр, тэтгэмж авч буй ТДИ тоо, эзлэх хувь	700		740		
16	Ясли	Хамрагдах хүүхдийн тоо	654		587	
	Цэцэрлэгт		4861		3989	
17	Хүүхэд, өсвөр үеийнхний (0-20 нас) нийт бодит тоо	21675		24133		
18	Харъяаллын нийт хүн амын тоо	96447		98673		
19	Нийт ТДИ-ийн тоо	2472		1280		
20	0 –15 насны хүүхдийн тоо	342		330		

“Тэгш дүүрэн” төслийн хорооны бүх гишүүдийн хурлыг 3 удаа хийж, 2002 онд хийх ажлын төлөвлөгөөны дагуу ажиллаж ирлээ.

- Хөтөлбөрийн талаар нийт эмч нарт 3 удаа, 1.2.3.4.5.9.13-р хорооны өрхийн эмнэлэгийн эмч, ажилчид, 10-16-р хорооны ТДИ-ийн төлөөлөгч бүгд 178 хүнд сурталчилгаа явуулав.
- Тархины саатай 0-5 насны 5 хүүхдийг эцэг, эхийн хамт 5 хоногийн сургалтанд, 13-р хороон дээр 9-16-р хорооны ТДИ-ийн төлөөлөгч 35 хүнийг ТДИ-дэд “Нөхөн үржихүйн боловсрол” олгох монголын ТДЭХолбооны 1 өдрийн сургалтанд, ТДИ-ийн МССЗҮ нийт төв дээр сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтанд 1 хүн, хараагүй иргэдтэй ажиллах сургалтанд 2 хүн, хүнд хэлбэрийн ТДИ-г сэргээн засах сургалтанд-10 хүн, бүгд-53 хүнийг сургалтанд хамруулав.
- Хөдөлмөрчид ТДИ-ийн дунд зохиогдсон 4 удаагийн өдөрлөгт 90 хүнийг оролцуулав. (13-р хороон дээр-35, СБД дээр-10, Сүхбаатарын талбай дах өдөрлөгт-8 хүнийг)
- Сайн дурын идэвхтэн 2 бэлтгээд байгаа бөгөөд цаашид хороо бүрээс идэвхтэн бэлтгэх төсөл өгөөд байна.
- ТДИ-ийг илрүүлэх судалгааны хуудсыг өрхийн эмч бүрт өгч судалгааг гаргуулан ТДИМССЗҮ-ийн төвд өгөөд байна.
- ТДИ-ийн хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход тусалж зээл олгох ажиллагааг үргэлжлүүлж, нийт 27 хүнд, шинээр 5 хүнд зээл олгоод байна. (Бүгд-27 хүн) Тус сангийн үйл ажиллагааг СБД-ийн санхүүгийн хяналтын алба, ТДИМССЗҮТөвөөс 2 удаа шалгаж хорооны гишүүдтэй уулзаж зөвлөсөн ба өрхийн эмч нараас ОНТСЗ үйл ажиллагааны талаарх мэдлэгийг тестээр шалгав.
- НХОТСЗ-ийн хөтөлбөрийн самбарыг шинэчилсэн ба фото альбом хийж ТДИ-ийн үйл ажиллагааг сурталчилж байна.
- ТДИ-ийн МССЗҮ төвтэй хамтран 5 хүнийг сургалтанд хамруулсан ба тахир дутуу Амгаланбаатарт Францын эмч нараар мэс засал хийлгэхэд хөрөнгийн талаар зуучлуулав.  
АУИС-ын “Багш шавийн эрдмийн уулзалтын” ОПБХ-д цус харвалтын дараах сэргэн засалт сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн.
- Тус дүүргийн хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар 2002 оны 10-р сарын -18 нд Монголын радиогоор сурталчилла.
- Италийн ТДИ-ээс илгээсэн тусламжийн ноосон хөнжил бусад зүйлсийг тахир дутуу 27 хүнд тараагаад байна.

#### Дүгнэлт:

ТДИ-г НХОТС засах “Тэгш дүүрэн” төсөл тус дүүрэгт хэрэгжиж, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулснаар дээрх ажлын амжилтууд гарсан бөгөөд ТДИ-ийн судалгааг жилээс жилд үнэн зөв гаргаж, ТДИ-г ойлгох хамт олон гэр бүлийн гишүүдийн ойлгот сайжирч тэдэнд үзүүлэх олон талт ажиллагаа жигдэрч хөдөлмөр эрхлэх аж байдлаа сайжруулах. сурч боловсрох мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог өргөтгөхөд тэднийг дэмждэг болж байна. Үүний дүнд ТДИ-гэд ч өөрсдөө аливаа зохиогдсон ажилд идэвхтэй оролцдог болж ирлээ.

СБЭМН-ийн дарга

М.Чимгээ

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ТАХИР  
ДУТУУ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД ЭХНИЙ  
ХАГАС ЖИЛД ЗОХИОСОН АЖЛЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ  
ХИЙХИЙН ӨМНӨ ТА БҮХЭНД СҮХБААТАР ДҮҮРЭГТ  
БАЙДАГ ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН ТАЛААР  
ТОВЧХОН ТАНИЛЦУУЛЪЯ

2001.10.31

Тус дүүрэгт тахир дутуу 1472 хүнээс 1082 хүн тэтгэвэр тэтгэмж авч  
байна. Үүнээс:

1. Тахир дутуу иргэдийг хороогоор нь авч үзвэл:

1-р хороо 44	5-р хороо 40	9-р хороо 79
2-р хороо 54	6-р хороо 44	10-р хороо 30
3-р хороо 59	7-р хороо 106	11-р хороо 102
4-р хороо 43	8-р хороо 84	12-р хороо 97
13-р хороо 67	Бүгд 1082 хүн	
14-р хороо 40		
15-р хороо 98		
16-р хороо 95		

2. Үүнээс: Эрүүл мэндийн чиглэлээр нь авч үзвэл:

Хараагүй хүний тоо: 1084  
Хэлгүй, дүлий 635  
Оюуны хомсдолтой 78  
Хөдөлгөөн хязгаарлагдмал 306

3. Насны үечлэлээр нь авч үзвэл:

0-7 насны хүүхдийн тоо 18  
сургуулийн насны хүүхэд бүгд 92  
18-30 насны 169  
30-40 насны 227  
40-60 насны 328  
60-аас дээш насны 103

Бүгд 937

4. Тахир дутуу хүмүүсийн нийгмийн хамгаалалд хамаарах  
чиглэлээр нь авч үзвэл:

тахир дутуу, тэтгэврийн хүмүүсийн тоо, 1188,, 1082  
ТД: Өрх толгойлсон эмэгтэй 77  
ТД: Өндөр настай 44  
ТД: Олон хүүхэдтэй ядуу гэр бүлийн тоо: 118  
ТД: Хөдөлмөрийн чадвартай ажилгүй 417

UIN.MN  
СҮДАЛГААНЫ САН

**5. Нэмэлт төхөөрөмж шаардлагатай хүний тоо 193**

а/ Ортопед 27

б/ протези 7

в/ Нэмэлт туслах төхөөрөмж 159

Үүнээс: Харааны зориулалтын багаж хэрэгсэл 6,  
сонсголын аппарат хэрэгсэл 89,  
хөдөлгөөний аппарат хэрэгсэл 64.

**6. Боловсролоор нь авч үзвэл:**

боловсролгүй 114

бага боловсролтой 164

бүрэн дунд боловсролтой 385

тусгай дунд боловсролтой 216

дээд боловсролтой 58

**7. Амьдралын түвшингээр авч үзвэл:**

Тахир дутуу хүний тоо 937

Хэвийн амьдралтай 414

Эрүүл мэндийн үйлчилгээ шаардах 523

Гэрт амьдардаг 372

Орон сууцанд амьдардаг 552

Орон гэргүй 13 байна.

**8. Ажил хийх сонирхолтой тахир дутуу иргэд 63 байна.**

*Нэг. Зохион байгуулалтын талаар:*

1.1. Монгол улсын засгийн газраас 2001 оны тахир дутуу иргэдийг дэмжих жил болгосонтой холбогдуулан дүүргийн тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын зохион байгуулах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2001 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 105 тоот захирамжаар байгуулах ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж энэ жилд зохиох ажлын төлөвлөгөөний талаар болон, цаашид зохиох ажлыг улам эрчимжүүлэхээр холбогдох хэлтэс албадуудад албан даалгавар өгөн ажиллаж байна.

1.2. Дүүргийн тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын нээлтийн арга хэмжээний үеэр, тахир дутуу иргэдтэй уулзалт ярилцлага зохион байгуулж дээрх жилийн ажлын хүрээнд зохион байгуулах ажлын талаар тэдний санал бодлыг сонсож, гаргасан санал хүсэлтийг ажлын төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. Уулзалт ярилцлагад 100 гаруй хүний оролцоо.

1.3. Дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний төвийн ажилтнуудад тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын хүрээнд Халамж үйлчилгээний төвөөс ямар ажил зохион байгуулах талаар зөвлөгөө өгсөн.

*Хоёр. Бусад ажлын талаар:*

2.1. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын нээлтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, эзлэлийн арга хэмжээний үеэр том хүнд 1, хүүхдэд 1, бүгд 2 ширхэг тэргэнцэр, 32 хүнд сонсголын аппарат олгож 16 хүнд дүүргийн Халамжийн үйлчилгээний төвийн сувилалд амруулах эрхийн бичиг олгож төгсгөлд нь Дүүргийн Ардын урлагийн их наадамд шалгарсан ардын авъяастнуудын нэгдсэн концерт тоглуулж сонирхууллаа.

2.2. Дүүргийн хэмжээгээр тахир дутуу иргэдийн судалгааг гаргасан.

2.3. Тахир дутуу 20 хүүхдийг дүүргийн Халамж үйлчилгээний төвийн сувилалд 10 хоног сувилуулж амраасан болно.

2.4. 16 хүнд орон сууцны хөнгөлөлт, 834623 төгрөг /давхардсан тоогоор 35 хүн/ үзүүлснээс гадна нийслэлийн хөдөлмөрийн алба Тахир дутуу иргэдийн МС, засал үйлчилгээний төвтэй хамтран 5 хүнд орон сууцны хөнгөлөлт нэмж олгосон.

2.5. Тахир дутуу 50 хүүхдийг 2001 оны 05 дугаар сарын 31-нд хүлээн авч нийт 150,000 төгрөгний мөнгөн тусламж олгосон.

2.6. Тахир дутуу 8 хүнд 420,000 төгрөгний хөнгөлөлт үзүүлсэн.

2.7. Дүүргийн хэмжээнд ажил эрхлэх сонирхолтой Тахир дутуу иргэдийн судалгааг гарган ажиллаж байна.

2.8. Одоогийн байдлаар 9, 13, 14 дүгээр хороодын тахир дутуу иргэдэд нийт 73,5 метр куб модыг олгоод байна.

2.9. 6 хүнд "Тэгш дүүрэн" төслөөс 1 сая 200,000 төгрөгний зээлийг өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор олгоод байна.

2.10. "Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх" төслөөс хүнд 5... 40... төгрөгний зээлийг өгсөн.

2.11. Дашчойлон хийдтэй хамтран "Бидний тус" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр 16 хүнд тэргэнцэр, 80 хүнд сонсголын аппарат, 16 хүнд 320,000 төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж, 9 хүнд хүнсний бүтээгдэхүүн, өрх толгойлсон 80%-ийн групптэй 2 эмэгтэйд гэр тус тус олголоо.

2.12. Зуны улиралд 25 хүүхдийг зусланд амрааж, 29 ахмад настан тахир дутуу иргэдийг рашаан сувилалд амраасан.

2.13. Ахмадын сувилалд нийт 36 хүнийг хүлээн авч 10 хоног бариа засал хийлгэх, зүү төөнүүр тавих, эм тан уулгах, хийн дасгал зэргээр эмчилж, илчлэг халуун хоол, цайгаар сувилсан.

2.14. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан 72/209 тоот тушаалыг хэрэгжүүлж дүүргийн хэмжээнд 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжийн судалгааг гаргахад 109 байгууллагад 320 хүн ажиллах судалгаа гарсан ба холбогдох шийдвэрийг ажил олгогчдод сурталчилан ажилласнаар одоо 79 аж ахуйн нэгжид 101 тахир дутуу, одой 2 хүн ажиллаж байна.

2.15. Тахир дутуу иргэдийн холбоонд ажил хийх сонирхолтой тахир дутуу иргэдийн үйлчилгээний төв байгуулахад нь зориулж газрын асуудлыг шийдвэрлэж өгсөн.

*Монгол Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан 72/209 тоот тушаалыг хэрэгжүүлж дүүргийн хэмжээнд 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжийн судалгааг гаргахад 109 байгууллагад 320 хүн ажиллах судалгаа гарсан ба холбогдох шийдвэрийг ажил олгогчдод сурталчилан ажилласнаар одоо 79 аж ахуйн нэгжид 101 тахир дутуу, одой 2 хүн ажиллаж байна.*

2.16. Үндэсний лото тоглоомонд 5 дугаар хороонд 5 хүн ажиллаж байна.

2.17. Дүүргийн тахир дутуу иргэдэд нийслэлийн ХНХАлбанаас 12 тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт сэргээн засалтын үндэсний төвөөс, УИХ-ын гишүүдээс 10, бүгд 67 тэргэнцэр одоогоор олгоод байна. Үүнээс хүүхдэд 3 ширхэгийг олгосон.

2.18. Сонсголын аппарат 112, 4 хүнд утасны хөнгөлөлт 84610 төгрөг, хөлний портез 9 хүнд 1 сая 294,0 төгрөг, шүд 6 хүнд 140,064 төгрөг, гутал 7 хүнд 370,000 төгрөг, гар 2 хүнд 235,000 төгрөг дүүргээс олгосон 19 тэргэнцэр 2 сая 850,000 төгрөг, хүнсний бүтээгдэхүүн 47 хүнд 224,300 төгрөг эм тариа 32 хүн 542,000 төгрөг тус тус олгоод байна.

2.19. Гэр оронгүй тэнэмэл хүүхэдтэй 9 хүнд гэр олгосон.

2.20. Улсын асрамжийн газар 3 хүнийг шийдвэрлэж явуулсан.

Одоогийн байдлаар дүүргийн засаг даргын тамгын газраас тахир дутуу иргэдийн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна. Үлдсэн хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан асуудал бүрэн биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сүхбаатар дүүргийн Тахир дутуу иргэдийг  
НХОТСЗасах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн  
Хорооноос 2002 онд хийсэн ажлын  
Тайлан

Тус хөтөлбөр Сүхбаатар дүүрэгт 1996 оноос хэрэгжиж эхэлснээс хойш хөтөлбөрийн зорилго зорилтыг хангахаар жил бүрийн ажлын төлөвлөгөөг зохиож хорооны гишүүдийн хурлаар батлан ажиллаж ирэв. Энэ онд бүгд 19 ажил төлөвлөж хорооны гишүүд хариуцан ажиллаж бүрэн биеллээ. Хорооны бүх гишүүдийн хурлыг 3 удаа салбар хуралдааныг сар бүр хийж цаг үеийн асуудал болон зээл авах хүмүүсийн төслийг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэв.

Хөтөлбөрийн гол зорилгын нэг ТДИ–г НХОТСЗасах үйлчилгээнд 584 хүнийг хамруулснаас эмнэл зүйн сэргээн засалтад 234 хүн хамрагдаж эдгэрэлт сайжралт нь 89.5 хувь болов. Рашаан сувилалд 60 хүн, 1 хүнийг сэргээн засах мэс засалд (Амгаланбаатар) оруулж, нийгмийн халамж асрамжийн үйлчилгээнд 98 хүнийг хамруулав.

ТДИ–г илрүүлэх судалгааг шинэчилсэн маягтаар өрхийн эмч нараар гаргуулж ТДИМССЗҮТөвд өгсөн ба 1280 хүн илэрсний 663 нь эрэгтэй, 617 эмэгтэй байв. Хэлбэрээр нь үзвэл:

1. Харааны өөрчлөлттэй	247
2. Сонсгол хэл ярианы өөрчлөлттэй	189
3. Бие бялдарын өөрчлөлттэй	269
4. Унадаг	46
5. Сэтгэцийн өөрчлөлттэй	147
6. Оюун ухааны хомсдолтой	98
7. Бусад төрлийн	284

илэрсэн нь дүүргийн хүн амын 1.2 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ судалгааг цаашид үргэлжлүүлэн хийж байна. Судалгаанаас харахад өрхийн эмч нарын хөтөлбөрийн талаарх мэдлэг сул, сургалтанд хамрагдсан эмч нар шилжиж ихэнх нь шинэчлэгдсэн, судалгааг айлаас айлд орж хийхгүй байгаа нь мэдрэгдэж байна.

Өөрийн байгууллагад ажиллаж буй ТДИ–н судалгааг гаргаж (нийт 8 хүн) урьдчилан сэргийлэх үзлэгт сэргээн засах эмчилгээнд хамруулж, хөтөлбөрийн арга хэмжээнд оролцуулж байна.

ТДИ, тэдний гэр бүл, асран хүмүүжүүлэгчдийг сурч боловсроход

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



анхаарч ирлээ. Ерөнхий боловсролын энгийн сургуульд 47, тусгай сургуульд 38 ТДИргэд суралцаж байгаа ба тархины саатай 0–5 насны 5 хүүхдийг эцэг эхийн хамт 5 хоногийн сургалтанд, 13–р хороон дээрТД эмэгтэйчүүдийн холбооноос зохиосон Нөхөн үржихүйн боловсрол олгох 1 өдрийн сургалтанд 9–16–р хорооны ТДИ–н төлөөлөгч 35 хүнийг, ТДИМССЗҮТөвийн дамжаанд 4 хүнийг (Амгаланбаатар, Ууганбаяр, Батбаатар, Ариунбат) сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтанд 1 хүн (Насан), харааны бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах сургалтанд 2 хүн, Хүнд хэлбэрийн ТДИ–г сэргээн засах сургалтанд 10 сувилагчийг сургасан ба ТДИ Амгаланбаатар “Future”сургалтын төвийн компьютерийн дамжаанд, Мижиддорж Дэлхийн зөн байгууллагын албан бус сургалтанд суралцаж байна.

Хөтөлбөрийн талаар эмч ажилчдад 3 удаа, 10–16–р хорооны ТДИ–н төлөөлөгч, хөдөлмөрчид бүгд 178 хүнд сурталчилгаа хийж, ТДИ–г 3 удаагийн хамруулж, Монголын радиогоор хөтөлбөрийн дагуу хийж буй ажлын талаар нэвтрүүлэг явуулав (2002–10–18).

Хөтөлбөрийн самбарыг шинэчилж, зээл авсан ТДИ–н үйл ажиллагааг фотоальбомоор сурталчилж байна.

ТДИ–н хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход тусалж зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг үргэлжлүүлж шинээр 9 хүнд 100000–200000 төгрөгийн зээл олгосон ба (бүгд 27 хүнд) АЙФО–гоос 1999, 2000, 2001 онд тус тус шилжүүлсэн 1500 \$ буюу 1549032 төгрөгийн ЗЭС–г тооцоход 5135350 төг–н зээл олгож, 4245787 төг–г хүүгийн хамт эргэн төлүүлж ЗЭС–д 5794819 төг–тэй болсон бөгөөд одоо дансанд 659469 төг–тэй байна. Зээл авсан ТДИ төслийн дагуу ашигтай ажиллаж 12 хүн зээлээ хугацаанд нь бүрэн төлж, хугацаа болоогүй зээл 9, харин 6 хүн зээлийн хүүгээ болон зээлээ хугацаанд нь төлөөгүй байна.

ЗЭС, хөтөлбөрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хорооны даргын хамт өрхийн эмнэлгүүдээр 3 удаа (3, 6, 10 сард) хийж эмч ажилчид, үйлчлүүлэгчидтэй уулзаж санал бодлыг сонсож хөтөлбөрийн талаар сурталчилж, аргачлал, зөвлөгөө өгсөн бөгөөд сургалтанд хамруулах талаар саналаа хэлцгээж байв. Тус сангийн үйл ажиллагааг санхүүгийн улсын хяналтын алба, ТДИМССЗҮТөвөөс шалгаж,хорооны гишүүд,ТДИ–тэй уулзаж ололт, дутагдалыг хэлж дүнг танилцуулав.

АЙФО–гоор дамжуулж Италийн ТДИ–н илгээсэн тусламжийн барааг 29

хүнд гардуулаад байгаа ба 2 хүнд тэргэнцэр шилжүүлэв.

Хорооны гишүүн Ганболд ТДИ–н тэргэнцэртэй уралдаанд эх орондоо болон Япон, Тайландад амжилттай оролцсон ба уран сайханч Зориг бие даасан тоглолтоо хийв.

ОУ–н ТДИ–н эрхийг хамгаалах өдрөөр зээл авч төсөл хэрэгжүүлэгчдийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, урлагийн тоглолтыг 10 хүнд үзүүлэв.

Хөтөлбөрийн дагуу зохиосон аливаа ажлуудад хорооны дарга Ж.Өнөгэрэл, гишүүн Ц.Эрдэнэчимэг, Б.Цэндбазар нар идэвхтэй оролцож ирэв.

Бидний ажилд ололт амжилтууд байгаа ч цаашид анхаарах, санал болгох дараах асуудлууд байна:

– Сургалтууд зохион явуулах (эмч ажилчид, ТДИ, удирдах ажилтан, үе тэнгийнхэнд г.м)

–Хөтөлбөрийн болон ЗЭС–ийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих, зээлийн эргэн төлөлтөнд анхаарах, гэрээ журмыг шинэчлэх

–Дээрх ажлуудыг явуулахад шаардагдах зардал, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж өгөхийг дээд байгууллагад санал болгох

–ТДИ–н талаар тавих анхаарал халамжаа улам сайжруулах шаардлагатай байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Тайлан бичсэн Хөтөлбөрийн зохицуулагч Б.Галя

## Удирдамж

### 1. Судалгааны зорилго:

Тахир дутуу хүний эрхийн төлөв байдал, нийгмийн хамгааллыг судлах ажлын хүрээнд тэдэнд үзүүлдэг нийгмийн хамгаалал, халамж, хөнгөлөлт, үйлчилгээ, эрхийн хэрэгжилтийн байдал, эрх зүйн болон эдийн засаг, нийгэм, сэтгэл зүй, зохион байгуулалтын орчин нөхцлийг үндэсний хэмжээнд судлахад тогтооход энэхүү судалгааны зорилго оршино.

### Судалгааны аргачлал:

Судалгааны асуудал, зорилго, урьдчилсан /хүлээгдэж буй үр дүн/ үр дүнгийн онцлогийг харгалзан анкет асуулга, хоёрдогч буюу бэлэн статистик тоон мэдээллийг цуглуулах аргуудыг хослуулан хэрэглэнэ.

**2.1 Асуулгын арга:** Асуулгын аргаар судалгааны анхдагч мэдээллийг цуглуулна. Судалгааны асуулга нь 2 хэсгээс бүрдэнэ. Асуулгыг бөглөхдөө нээлттэй асуулга болон хариултын кодыг ашиглана.

**2.2 Баримт мэдээлэл цуглуулах:** Тусгай бэлтгэсэн хүснэгт ашиглан доорхи нэр бүхий албан байгууллага, албан тушаалтнуудаас судалгааны ажилд хэрэглэх тоон мэдээллийг авна

- ❖ Тухайн дүүрэгт байрладаг төрийн захиргааны байгууллага
- ❖ Нийгмийн халамжийн төвүүд
- ❖ Тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалсан ТББ
- ❖ Хорооны холбогдох байгууллагууд

### 3. Судалгаа явуулах хугацаа, хамрах хүрээ

Судалгааны ажлыг Улаанбаатар хотын 6 дүүрэгт 2003 оны 2-р сарын 9-нөөс 3-р сарын 20 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Судалгаанд Улаанбаатар хотын дүүрэг, нийгмийн халамжийн газар, тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалсан ТББ, тахир дутуу иргэдийн төлөөллийг хамруулна.

### 4. Судалгааны түүвэрлэлт:

Асуулгын судалгааны түүврийн хэмжээг нас, хүйс, оршин суугаа газар зэрэг нийгэм- хүн ам зүйн үндсэн үзүүлэлтийг үндэслэн тооцох бөгөөд зорилтот түүврийн аргыг ашиглана.

Судалгааны шинжилгээний нэгж нь тахир дутуу иргэд байх болно.

Судалгааны түүврийн зохистой хэмжээг тогтооходоо "Хүн ам, орон сууцны тооллого"-д тоологдсон нийт тахир дутуу иргэдийн 0.5 хувь байхаар баримжаалан тогтооно.

Нийт түүврийн хэмжээ 420 респондент байхаар тооцно.

Хүснэгт 1

Код	Аймаг нийслэлийн нэр	Код	Сум, дүүргийн нэр	Түүврийн хэмжээ		
				Асуулга	эр	эм
	Улаанбаатар	1	Баянгол	70	35	35
		2	Баянзүрх	70	35	35
		3	Сонгинохайрхан	70	35	35
		4	Хан-Уул	70	35	35
		5	Чингэлтэй	70	35	35
		6	Сүхбаатар	70	35	35
Нийт				420	210	210

УИН.МН  
СУДАЛГААНЫ САН

**4.1 Хүйсийн харьцаа: 50/50** ( Жишээлбэл, Баянзүрх дүүргээс 70 хүнээс судалгаа авахдаа үүний 35 нь эрэгтэй, 35 нь эмэгтэй хүн ам байхаар судалгааны мэдээллийг цуглуулна.)

**4.2 Нас: 14-61+** (Насны бүлгийг 14-17, 18-30, 31-40, 41-50, 51-60, 60+ гэж ангилан авна.)

**Судалгааны түүвэр хийх загвар:**

Дээрхи насны 6 билэгт, судалгааны тиврийн тоог эрэгтэй, эмэгтэйгээр нь тэгш хуваана. Судалгааны мэдээлэл цуглуулах явцдаа тооны ард \*-оор насны бүлэг, хүйсийн харьцаа тэнцүү бүхий хүн амаас судалгааны мэдээлэл авснаа тэмдэглэх нь аливаа түүврийн алдаа гарахаас сэргийлэх бөгөөд судлаачид хялбар байдаг.

Хиснэгт. 2

Хүйс/Нас	14-17	18-30	31-40	41-50	51-60	61+
Эмэгтэй	4	7	7	6	4	3
Эрэгтэй	4	7	7	6	4	3

Жишээлбэл, Баянзүрх дүүргийн 70 хинээ 6 насны билэгтээ хүйсийн 50/50 харьцаатайгаар хуваана.  $50/50:6=5.8$  хин нэг билэгт оногдоно.

“Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах”  
үндэсний хөтөлбөрийн биелэлт  
/2001-2002 онд/

№	Үзүүлэлт	2001 онд		2002 онд	
		Хүний тоо	Өртөг /мян. төг/	Хүний тоо	Өртөг /мян. төг/
01	02	03	04	05	06
1	Мэргэжлийн сургалтад хамрагдаж мэргэжлийн чиг баримжаа эзэмшсэн тахир дутуу иргэдийн тоо, эзлэх хувь	12	0.48	35	2.73
2	Халамжийн тэтгэвэр авдаг тахир дутуу иргэдийн тоо	673	74583.0	715	82757.2
3	Халамжийн тэтгэмж авдаг тахир дутуу иргэдийн тоо	21	4980.0	37	6592.0
4	Тахир дутуу иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт:				
	Байнгын асрамжинд байдаг тахир дутуу хүүхдээ асардаг	21	4980.0	37	6592.0
	Түлээ нүүрсний хөнгөлөлт авсан	153	8951.8	373	21302.7
	Орон сууцны хөнгөлөлт авсан	10	1526.9	19	2167.6
	Олгосон: Тэргэнцэр	23	3340.0	21	3100.0
	Таяг	-	-	39	234.0
	Сонсголын аппарат	40	1400.0	28	1064.0
	Протез, ортопед				
	хийлгэсэн тахир дутуу иргэн	32	2892.9	31	2438.3
	Автомашин				
	Бусад хөнгөлөлтөнд				
	хамрагдсан тахир дутуу иргэд	10	484.9	9	950.5
5	Гэрийн үйлчилгээнд хамрагдсан тахир дутуу иргэн				
6	Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамрагдсан тахир дутуу иргэн, эзлэх хувь	39	10.3%	36	9.9%
7	Тахир дутуу иргэний зориулалттай тоног төхөөрөмжийн хангалтын байдал				
8	Хөдөлмөр эрхэлж буй тахир дутуу иргэн	101		113	
9	Ажил хөдөлмөрт зуучлан оруулсан тахир дутуу иргэн	63		89	

ТДИ-ийн хөдөлмөр эрхлэх орлогоо нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгоход тусалж “Тэгш дүүрэн” төслийн хорооны зээлийн эргэлтийн сангаас шинээр 5 хүнд жижиг зээл олгож, нийт 27 хүнд зээл олгон хөдөлмөр эрхлүүлж байна.

Тахир дутуу иргэдэд зориулсан 4 удаагийн өдөрлөгт нийт 90 хүнийг оролцуулсан. Эх үрсийн баярын өдөрлөгийн үеэр Монголын тахир дутуу

иргэдийн холбооноос 10 хүүхдэд, Монголын тахир дутуу эмэгтэйчүүдийн холбооноос 16 хүүхдэд бэлэг, “Сайн сэтгэл” протезийн үйлдвэрээс 2 хүүхдэд тэргэнцэр, 10 хүүхдэд цүнх олгуулж, дүүргийн тахир дутуу хүүхдийн өдөрлөгийг зохион байгуулж, 80 хүүхэд хамруулсан бөгөөд хүүхэд бүрт дүүргийн Халамжийн төвөөс 1000 төгрөгийн, 2000 төгрөгийн бэлэг өгч, хүүхдүүдэд 135-р цэцэрлэгийн хүүхдүүдийн урлагийн тоглолтыг үзүүлээд байна.

ТДИ-ийн эрхийг хамгаалах дэлхийн өдрөөр “Бид бүхнийг чадна” Монголын Үйлдвэрчний эвлэлийн соёлын ордонд болсон өдөрлөгийн үеэр тахир дутуу иргэдийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн гарган шалгаруулж, шалгарсан 3 бүтээлд нийт 45.000 төгрөгийн шагналыг олгосон. Улсын циркт болсон өдөрлөгийн үеэр зээл авч хувиараа хөдөлмөр эрхэлж буй 15 иргэний бүтээлээр үзэсгэлэн гаргаж, өдөрлөгт оролцогсдод сонирхуулсан. Түүнчлэн СТА дуучин Ариунаагийн Монголын Залуучуудын холбоотой хамтран зохион байгуулсан хандивын тоглолтыг 20 тахир дутуу иргэнд үзүүлсэн.

“Тэгш дүүрэн” төслийн хорооноос жижиг зээл авч, бэлэг дурсгалын зүйл хийдэг 13-р хорооны иргэн Норовсүрэнгээс 18 дурсгалын хүүхэлдэйг 56.000 төгрөгөөр худалдан авсан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд Хөдөлмөр эрхлэлтийн албатай хамтран сургалтын өрөөг тохижуулан мэргэжил олгох сургалтыг зохион байгуулан явуулж байна.

Тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоотой хамтран хууль зүйн орчин болон нөхөн үржихүйн боловсролын талаар нийт 85 тахир дутуу иргэдэд 1 өдрийн сургалтыг явуулсан. Тархины саатай 5 хүүхдийг эцэг эхийн хамт 5 хоногийн сургалтанд явуулсан.

Монголын Скаутын холбоотой хамтран гэрийн асрамжинд байдаг 10 хүүхдийг тус холбооны төлөөлөгчидтэй уулзуулж хэрэгцээний судалгааг авахуулаад байна. Уулзалтын үеэр тахир дутуу хүүхдүүдэд гарын бэлэг өгч урамшуулсан. Дүүргийн Халамжийн төвөөс зардлыг нь гарган Албан бус боловсролын “Гэгээрэл хөгжил төв”-ийн “Өлзийт” зусланд 2001 онд 6 тахир дутуу хүүхдийг амруулсан.

Италийн Засгийн газрын бус байгууллага АИФО-гоос ирүүлсэн тусламжийн барааг 29 тахир дутуу иргэнд гардуулан өгсөн бөгөөд 2 хүнд гэрээний тэргэнцэрийг шилжүүлэн өгөөд байна.

2001 оноос тахир дутуу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн албанаас ихээхэн анхаарч ажилласнаар аж ахуйн нэгжид нормативын дагуу нийт ажиллагсдын 30 гаруй хувьд тахир дутуу одой иргэд ажил хөдөлмөр эрхэлж байна.

Дүүргийн зүгээс эмзэг бүлгийн тахир дутуу 8 иргэнд амьдарлын нөхцөлийг сайжруулах зорилгоор орон гэр олгоод байна.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

## **АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН 10 ЖИЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Төр, засгийн байнгын анхаарал халамжид байх шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг болох тахир дутуу иргэдийг нийгмийн амьдралд идэвхитэй татан оролцуулах, хөдөлмөр эрхлүүлж орлогыг нь нэмэгдүүлэх, тэдний амьжиргааны түвшинг баталгаажуулах нь төрийн бодлогын салшгүй чухал хэсэг юм.

Монгол Улсын тахир дутуу иргэдийн талаар авах төрийн бодлого нь 1948 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганаар баталсан Тахир дутуу хүмүүст адил боломж олгох үндсэн зарчим, 1993 онд баталсан Тахир дутуу иргэдийн тэгш эрхийн тухай НҮБ-ын хэм хэмжээний дүрэм, 1983 онд ОУХБ-аас баталсан Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон мэргэжлийн нөхөн сэргээлтийн тухай 159 дүгээр конвенци, Ази номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос 1993 - 2002 оныг Ази - Номхон далайн бүс нутгийн тахир дутуу иргэдийн 10 жил болгон тунхагласан шийдвэрүүд зэрэг НҮБ-ын бага хурлууд болон дээд хэмжээний уулзалтуудын үзэл санаа, тахир дутуу иргэдийн аж байдлыг дээшлүүлэх талаар олон улсын хэмжээнд зөвшилцсөн үндсэн зарчмуудад тулгуурлан хэрэгжиж байгаа болно.

Ази-Номхон далайн бүс нутгийн Тахир дутуу иргэдийн 10 жилийн ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг дараахи чиглэлүүд дээр товч танилцуулъя .

### **НЭГ : ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТАЛААР :**

Монгол оронд тахир дутуу иргэдийн тэгш эрхийг хангах, нийгмийн амьдралд татан оролцуулах, хөдөлмөр эрхлүүлэх, нөхөн сэргээх, нийгмийн баталгааг хангах талаар хууль эрх зүйн орчин бүрдсэн юм.

Тахир дутуу иргэдийн талаар гарсан төрийн бодлого, шийдвэр, тэднийг нийгмийн амьдралд оролцуулах, амьдралын баталгааг хангах асуудлууд нь `` Монгол Улсын Үндсэн хууль `` , `` Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль `` , `` Гаалийн тарифын тухай хууль `` , `` Боловсролын тухай хууль `` , `` Хөдөлмөрийн тухай хууль `` , `` Нийгмийн даатгалын тухай хууль `` , `` Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль `` , `` Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль `` , `` Эрүүл мэндийн тухай хууль `` , `` Нийгмийн халамжийн тухай хууль `` , `` Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль ``-иуд болон 1998 онд Засгийн газраас баталсан `` Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр `` , 2002 оны 7 дугаар сард баталсан `` Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр `` , Засгийн газрын болон холбогдох яамдын тогтоол шийдвэр, дүрэм, журам зэрэг хууль эрхийн актуудад тусгалаа олж хэрэгжиж байна.



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН ХЯНАН ШАЛГАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2001 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн арга хэмжээнд  
төсвөөс олгосон хөрөнгийн  
зарцуулалтын тухай

Нийгмийн халамжийн арга хэмжээнд 2001 онд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн шалгалтын дүнг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

2001 онд нийгмийн халамжийн арга хэмжээнд 13,7 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нэн ядуу иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ үндсэндээ жигд явагджээ.

Гэвч нийгмийн халамжийн санд төсвөөс олгох санхүүжилтийг зарим үед хугацаанаас нь хоцроож хийж байснаас 383,9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ ондоо багтаж олгогдоогүй байна.

Улсын нийгмийн халамжийн газарт төсвийн хуулийг зөрчин зохих шийдвэргүй хөрөнгө төвлөрүүлж, уг төвлөрүүлсэн хөрөнгөөр тэргэнцэр, сонсголын аппарат худалдан авах, дэвтэр маягт хэвлүүлэхдээ хуулийн дагуу төндөр зарлан гүйцэтгэгч сонгоогүй, олон нийтийн байгууллагын ажилтнуудын томилолтын зардлыг үйл ажиллагааны зардлаас тооцож олгосон, нийгмийн халамжийн сан болон үйл ажиллагааны зардлын төлөвлөлтийн үндэслэл муугаас ахиу төсөв авч зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Улсын нийгмийн халамжийн газар, аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний төвүүд үйл ажиллагааны зардлаа хэтрүүлэн зарцуулсан нь харьяа газруудын үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт шалгалтыг сулруулсан, удирдах албан тушаалтны ажлыг дүгнэх, ажлын хариуцлага тооцох талаар хангалтгүй ажилласантай холбоотой байна.

Аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд нэн ядуу иргэдэд үзүүлэх зарим үйлчилгээг эзэнд нь зохих тоо хэмжээгээр хүргээгүй, үргүй зардал гаргасан, зарим албан тушаалтан тэргэнцэр, сонсголын аппаратын үнийг хувьдаа завшсан, тэтгэвэр тэтгэмжийг дутуу олгосон зэрэг зөрчил илэрлээ.

Шалгалтаар нийт 61,3 сая төгрөгийн зөрчил илэрсний дийлэнхи нь орон нутагт гарчээ.

Төрийн хянан шалгах хорооноос ТОГТООХ нь:

0000083



Нэг.Шалгалтаар илэрсэн төлбөрийг барагдуулахаар хянан байцаагчдын тогтоосон актыг хавсралтаар баталсугай.


Хоёр.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт цаалгах нь:

1. Нийгмийн халамжийн сангийн төлөвлөлт, зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах, улсын төвлөрсөн төсвөөс нийгмийн халамжийн санд олгох санхүүжилтийг хугацаанд хийлгэж байх арга замыг Санхүү, эдийн засгийн яамтай зөвшилцөж хэрэгжүүлэх,
2. Батсүмбэр дэх асрамжийн газрын менежментийг сайжруулж, боловсон хүчнээр хангах, ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгө, материалын асуудлыг судлан шийдвэрлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

Гурав.Улсын нийгмийн халамжийн газрын дарга К.Хатанбаатарт даалгах нь:

1. Нийгмийн халамжийн сангийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, нийгмийн халамж, үйлчилгээний төвүүдээс хөрөнгө төвлөрүүлж, төлөвлөгдөөгүй зүйлд зарцуулахийг зогсоох,
2. Хөрөнгө оруулалт хийх, бараа материал, түүний дотор тахир дутуу хүмүүст олгох тэргэнцэр, сонсголын аппарат худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хуулийн дагуу тендер зарлан хэрэгжүүлж байх,
3. Дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүдээс нэн ядуу иргэдэд олгож байгаа нүүрсний хэмжээ, үнэ, тээврийн зардлын үндэслэлийг хянаж үзэх,
4. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, тогтоолын биелэлтийг Төрийн хянан шалгах хороонд 2003 оны 1 дүгээр сард багтаан ирүүлэх

ДАРГА



Л.ЖАВЗМАА

ЦНМН  
СУДАЛГААНЫ САН

УЛСЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГАЗАРТ ХИЙСЭН ШАЛГАЛТААР  
ИЛЭРСЭН ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

/мян.төг/

Д.д	Байгууллагын нэр	Хянан байцаагчийн нэр	Төлбөр хариуцагчийн		Төлбөрийн тсвч утга	Төлбөрийн	
			Овог нэр	Албан тушаал		дүн	төсөвт төлөх
1	УНХГазар	А.Сүхбаатар	Ж.Хатанбаатар Ц.Цэрэндорж	Дарга Нягтлан бодогч	Албан томилолтын зардал төлүүлэх	130.0	130.0
2	УНХГазар	Д.Манал	Ж.Хатанбаатар Ц.Цэрэндорж	Дарга Нягтлан бодогч	Хууль бус зарцуулсан хөрөнгө төлүүлэх	6,225.0	6,225.0
3	Батсүмбэр дэх Улсын асрамжийн газар	Р.Цолмон	Д.Цэндсүрэн Ц.Хоролдорж Г.Жигмидбаатар	Дарга Дарга асан Нягтлан бодогч	Үнийн зөрүү төлүүлэх	47.2	47.2
4	Батсүмбэр дэх Улсын асрамжийн газар	Р.Цолмон	Д.Цэндсүрэн Ц.Хоролдорж Г.Жигмидбаатар	Дарга Дарга асан Нягтлан бодогч	Үнийн зөрүү төлүүлэх	180.0	180.0
5	Батсүмбэр дэх Улсын асрамжийн газар	Р.Цолмон	Д.Цэндсүрэн Ц.Хоролдорж Г.Жигмидбаатар	Дарга Дарга асан Нягтлан бодогч	Зардал төлүүлэх	483.9	483.9
	ДҮН					7,066.1	7,066.1

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн халамжийн арга хэмжээнд  
төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт,  
түүний үр дүнг шалгасан тухай

Нэг.Шалгалтын зорилт, хамрах хүрээ,  
арга зүй

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны хүсэлт, Төрийн хянан шалгах хорооны 2002 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн хянан шалгах хорооны даргын баталсан хөтөлбөрийн дагуу нийгмийн халамжийн арга хэмжээнд төсвөөс 2001 онд олгосон хөрөнгийн зарцуулалтыг нийгмийн халамжийн байгууллагуудад шалгав. Ингэхдээ ТХШХ-ны хянан шалгах байцаагч нар Улсын нийгмийн халамжийн газар, Батсүмбэр дэх улсын асрамжийн газар, Тарни дахь ахмад настны амралтын газар, Аржанчивлин рашаан сувилалд, аймаг, нийслэлийн хянан шалгах хороод аймаг, нийслэлийн дүүргүүдийн халамж үйлчилгээний төвүүд болон сумын нийгмийн халамжийн ажилтны 10,0 орчим хувийн ажлыг 2002 оны 8 дугаар сарын 15-наас 9 сарыгээр сарын 20-ны хугацаанд тус тус шалган дүгнэлт хийв.

Шалгалтанд ёс журмын, санхүүгийн баримтын болон үйлцэтгэлийн шалгалтын арга техникийг хослуулан, шалгалтыг хийх, дүнг гаргах, тайлагнах бүхий л үйл ажиллагаанд төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, хянан байцаагч нар бүрэн эрхийнхээ дагуу байгууллагын удирдлага, албан тушаалтнаас шалгалтын ажилд холбогдох баримт материалыг гаргуулан авч судлах, мэдээ, судалгаа гаргуулах, ярилцлага хийх зэргээр мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх бүх аргуудыг ашигласан бөгөөд дээрх байгууллагын 2001 оны төлөвлөгөө, санхүүгийн баримт бичиг, үйл ажиллагааны үр дүнд холбогдох бусад материалыг хамаарч үзэв.

Хоёр.Улсын нийгмийн халамжийн газрын үндсэн  
чиг үүргийн хэрэгжилт, түүний үр дүнгийн талаар

Улсын нийгмийн халамжийн газар нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм. Энэ байгууллага нь зохион байгуулалтын хувьд удирдлагын босоо тогтолцоотой бөгөөд аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний 30 төв, сумын нийгмийн халамжийн 333 ажилтан, аймгийн асрамжийн газар 9, Батсүмбэрт улсын асрамжийн газар, Тарнид ахмад настны амралтын газар, Аржанчивлинд ахмад настны сувилалтайгаар үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь Нийгмийн халамжийн тухай, Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай, Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулиуд

болон бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлж, улс, орон дутгийн төсвөөс хуваарилагдсан хөрөнгийг холбогдох хууль, тогтосмжийн дагуу зориулалтаар нь зарцуулах, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоон олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх явдал юм. Улсын нийгмийн халамжийн газар УНХГ/ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. УНХГ нь нийгмийн халамжийн сангийн болон тус газрын үйл ажиллагааны зардлын төсвийг зохион батлуулж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамжийн сангаас аймаг, дүүргүүдийн нийгмийн халамжийн төвүүдэд олгох санхүүжилтийг хугацаанд нь Санхүү эдийн засгийн ямаар хийлгэхэд анхаарч ажилласнаар 2001 оны санхүүжилт үндсэндээ цаг хугацаандаа хийгдэж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нэн ядуу иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ сардаа багтан олгогдож 13,7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Улсын хэмжээнд 2001 онд 19206 хүн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг шинээр тогтоолгож энэ арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө өмнөх оныхоос 2,1 тэрбум төгрөгөөр өссөн байна./Судалгаа №1/

Нийгмийн халамжийн санд улсын төвлөрсөн төсвөөс 12,5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төсөвлөсөн боловч Засгийн газраас 2001 оныг ахмадын жил, тахир дутуу иргэдийг дэмжих жил болгосны хүрээнд зохиогдсон ажил болон Засгийн газрын 2000 оны 155 дугаар тогтоолоор цалингийн доод хэмжээг нэмэгдүүлсэн зэргээс төсвийн тодотгол хийж 2001 оны сангийн санхүүжилтийг 1,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, өнгөрсөн онд дутуу санхүүжүүлсэн 311,2 сая төгрөгийг нөхөн олгож нийтдээ 13995,6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Үүнээс 13744,6 сая төгрөгийг зарцуулж 383,9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг 2001 онд багтаан тавьж олгоогүйгээс 15502 иргэн тэтгэвэр, тэтгэмжээ авч чадаагүй байна. Энэ нь Санхүү эдийн засгийн яам санхүүжилтийг 12 дугаар сарын 29-нд хийсэнтэй холбоотой байна.

Гурав.Нийгмийн халамжийн сангийн төлөвлөлт,  
хуваарилалт, зарцуулалтын талаар

УНХГ нь нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах шаардлагатай иргэдийг тодорхойлох зөвлөмжийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, ахмад настан, тахир дутуу иргэд, хагас, бүтэн енчин хүүхэд, нэн ядуу амьдралтай иргэдийн судалгааг гаргуулан сангийн хөрөнгийн төлөвлөлтөд ашиглан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг төлөвлөлийн хөлсний доод хэмжээний түвшингийн өөрчлөлттэй үйлдүүлэн нэмэгдүүлэх тооцоо, судалгааг гаргаж 2001 оны төсвийн тодотголд тусгах, 2002 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт заасны

хууль нэмэгдүүлэх тооцоо, судалгааг гаргаж холбогдох хуулиудад хүргүүлэх, Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийг баталжүүлэхтэй холбогдсон аргачлал, журам, норм, нормативыг шинэчлэн тогтоож Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн /НХХ/-ийн үйлдлийн тушаал, мэдээ, тайлан гаргах журам, Тарни амралт, эмгэгчдийн сувиллын зар бичгийн үнийг шинэчлэн тогтоох зэрэг асуудлыг УНХГ-ын даргын тушаалаар батлан мөрджээ.

УНХГ нийгмийн халамжийн сан болон үйл ажиллагааны зардлыг сүүлийн 3 жилийн судалгаанд үндэслэн төлөвлөж НХХЯ, УИХ-аар хянуулан УИХ-ын чуулганаар батлуулан мөрдөж иржээ. 2001 онд нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг аймаг, дүүргүүдийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүдэд хуваарилж, УНХГ-т төвлөрүүлэн зарцуулах хөрөнгө төлөвлөөгүй байна. УНХГ нийгмийн халамжийн сангаас аймаг, дүүргүүдийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүдэд өгөх санхүүжилтийн хуваарийг гарган сар бүр Санхүү эдийн засгийн ямаар шилжүүлүүлж иржээ.

Улсын төвлөрсөн төсвөөс олгох санхүүжилт 2001 оны хувьд үндсэндээ хугацаандаа өгөгджээ.

УНХГ, аймаг, дүүргүүдийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүд улсын төвлөрсөн төсвөөс олгосон санхүүжилтийг үндсэндээ зориулалтын дагуу зарцуулсан байна.

Гэвч шалгалтаар дараах зөрчил илэрлээ. УНХГ нь 2001 онд төсөвт тусгагдаагүй 118,0 сая төгрөгийг Сүхбаатар, Чингэлтэй, Дархан-Уул, Хан-Уул, Сонгино хайрхан дүүргүүдээс төвлөрүүлэн тэргэнцэр бэлтгэхэд 16,5 сая, сонсголын аппарат бэлтгэхэд 2,0 сая, тэтгэврийн болон тэтгэмжийн дэвтэр, тэтгэвэр, тэтгэмж авагчдын хувийн хэрэг, эмнэлгийн хуудас хэвлүүлэхэд 47,7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус газар 2001 онд тэргэнцэр, сонсголын аппарат бэлтгэх, тэтгэвэр, тэтгэмжийн дэвтэр, тэтгэвэр, тэтгэмж авагчдын хувийн хэрэг, эмнэлгийн хуудас хэвлүүлэх, нүүрс бэлтгэх зэрэгт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай үзүүлийн дагуу тендерийн хороо байгуулж, тендерийн урилгыг төвлөл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж, тендерийн шалгаруулалт хийлгүйгээр дээрхи ажлыг хувь хүмүүс болон стандарт принтинг ХХК, НарМон ХХК-иар гүйцэтгүүлсэн байна. Ингэснээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай үзүүлийн 38 дугаар зүйлийн 3-ын 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Стандарт принтинг ХХК-иар 47,7 сая төгрөгийн хэвлэлийн үйлчилгээний гүйцэтгүүлснийг хянан үзэхэд уг компани нь Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй боловч 2001 онд татвар төлөөгүй, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдээгүй байв. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч гэж тооцож төлсөн 6225000 төгрөгийг төлүүлэхээр акт тогтоолоо. Сонсголын аппарат, тэргэнцэрийг хувь хүмүүс гадаадаас оруулж эхлэхэд гаалийн татвар төлдөггүй нь гаалийн тарифын тухай үзүүлийн 21 дүгээр зүйлийн 4-д тахир дутуу иргэдэд зориулсан техник хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд зориулсан түүхий эд,

царил гаалийн татвараас чөлөөлөгдөнө гэсэн заалттай боотой байна.

2001 онд 19 хүний нэр дээр 38 ширхэг тэргэг гэр, 66 ширхэг олголын аппаратын тайлан гаргаагүй байгааг холбогдох үүсээр нөхөн гаргууллаа.

Чингэлтэй дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний төв нь 2001 онд төвлөрсөн төсвөөс 500,9 сая төгрөгийн санхүүжилт авч ХР-т 32,5 сая төгрөг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйлдвэрээр дүүргийн халамж үйлчилгээний төвийн барилга барихад 26,9 сая төгрөгийг зарцуулан жилийн эцэст 45,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нийгмийн халамжийн сангийн зөвлөлт үндэслэл муутай хийгдсэний жишээ юм.

Нийгмийн халамжийн тухай хуульд нэн ядуу амьдралтай хүмүүсийг орон сууцтай болгох, орон сууцтай болоход нь хэмжээг үзүүлэх, гадаадад эмчилгээнд явах болон эмчилгээ үйлчилгээ хийлгэхэд шаардлагатай эм, тарианы мөнгөгүй хүмүүст буцалтгүй тусламж үзүүлэх тухай заалт байхгүй боловч УНХГ халамжийн зөвлөлийн хурлаараа хэлэлцэн жилийн төсөвт тусгагдаагүй арга хэмжээнд хөрөнгө зарахаар шийдвэрлэн уг хөрөнгийг халамжийн сангаас зарахыг аймаг, дүүргүүдийн халамж үйлчилгээний төвүүдэд зөвшөөрч байсан нь төсвийн хуулийг зөрчсөн арга хэмжээ болжээ. УИХ, Засгийн газар, Эрүүл мэндийн сайн зэрэг газрууд Улсын нийгмийн халамжийн газарт хуулиар хүлээсэн үүргээс нь гадуур ажлыг гүйцэтгүүлэхээр хүмүүсийн өргөдлийг шилжүүлж иргэдийг чирэгдүүлсэн, тус газрын бичиг баримтасны ажлыг нэмэгдүүлсэн явдал цөөнгүй гарсныг цаашид анхаарах нь зүйтэй байна.

2001 онд гэр, орон сууцгүй 18 хүнд 5400,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Гэтэл орон сууцтай болгож өгөхийг хүссэн болон орон сууцтай болоход тусламж үзүүлээч гэсэн олон өргөдөлд тус газар хуульд ийм заалт байхгүй гэсэн хариу өгсөн нь иргэдийг ялгаварласан зүйл болсныг цаашид анхаарах шаардлагатай байна.

2001 онд гадаад оронд эмчилгээнд явахад болон эм тарианы мөнгөтэй болоход буцалтгүй тусламж хүссэн 29 хүнд 2409,0 мянган төгрөгийн тусламж олгосон нь мөн л хуулинд заагдаагүй арга хэмжээ болсон байна.

Төрийн хянан шалгах хорооны хянан байцаагчид шалгалтын хүрээнд нийслэлийн Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдэд хийсэн шалгалтын дүнгээс үзэхэд нийслэлийн хэмжээнд нийгмийн халамжийн сангаас нэн ядуу иргэдэд үзүүлж байгаа зарим үйлчилгээ эзэндээ бүрэн хүрэхгүй байгаа нь харагдлаа. Тухайлбал нийслэлийн 6 дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний төвөөс 2001 онд 9031,6 тонн нүүрсийг НарМон ХХК-тай гэрээ байгуулан олгосныг шалгахад уг нүүрсний 40,0 хувь нь буюу 3600,0 тонн нүүрс хог нэрээр эзэндээ очоогүй бөгөөд энэ нь 72309600 төгрөг болж байна. Иргэдэд нүүрсийг ялгаж, салж олгож байгаа нь соёлтой мэт боловч бодит байдалд нүүрсийг хохироосон үйл ажиллагаа болсныг анхаарах шаардлагатай байна.

Улсын стандарт хэмжил зүйн үндэсний төвийн гаргасан тооцоогоор Багануурын уурхайн нүүрсний 3,0 хувь нь хаягдал болдог гэдэгтэй харьцуулж үзэхэд дээрх тооцоо нь дэндүү үндэслэлгүй болсон байна. Нүүрсийг савлахад 108372 ширхэг шуудай буюу 13,0 сая төгрөг зарцуулж байгаа нь үргүй зардал гэж үзэх үндэслэлтэй байна. Нүүрсний тээврийн зардлыг тооцоход нэг айлд нүүрс хүргэх дундач зайг 35 километрээр тооцож байгаа нь үндэслэл муутай байна. НарМон ХХК-ий нүүрс олгох цэгээс Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хэрэглэгчид 15 километрийн дотор, Сонгино хайрхан дүүргийн хэрэглэгчид 25 километрийн дотор байна гэсэн тооцоог үйлслэлийн хянан шалгах хороо гаргаснаас үзэхэд тээврийн зардлын тооцоо үндэслэл муутай болж нийгмийн халамжийн сангаас 10,0 орчим сая төгрөгийг үр дүнгүй зарцуулжээ гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна./Судалгаа №2/

Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 2001 онд нүүрсний тээврийн зардалд 30,9 сая төгрөг зарцуулжээ. Дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүдийн НарМон ХХК-тай байгуулсан гэрээнд нэг тонн нүүрсийг 12 шуудай, нэг шуудай нүүрсийг 50 килограммаар тооцохоор тусгагдсаныг нийслэлийн хянан шалгах хорооны хянан байцаагчид газар дээр нь хэмжиж үзэхэд 35-40 килограмм байснаар тооцоход иргэдэд 90,3-135,4 тонн нүүрс дутуу олгогдож, 1,8-2,7 сая төгрөгөөр хохироосон тооцоо гарч байна. Захуудын нүүрсний ченжүүд нэг шуудай нүүрсийг чанар байдлаас нь шалтгаалан 800-1200 төгрөгөөр зарж байгаа нь НарМон ХХК-ийн бэлтгэснээс 873-473 төгрөгөөр хямд байгааг хянан үзэж нүүрс бэлтгэх ажилд тендер зарлаж гүйцэтгүүлэх шаардлагатай болсон байна.

#### Дөрөв. Үйл ажиллагааны зардлын талаар

2001 онд УНХГ-ын үйл ажиллагааны зардалд 32,0 сая төгрөг батлагдсанаас 44,3 сая төгрөг зарцуулж 38,4 хувиар хэтрүүлсэн байна. Энэ нь тус газар 2001 онд төлөвлөгдөөгүй засварын ажил хийж, байгууллагын хэрэгцээнд эд хөрөнгө худалдан авсан зэрэгтэй холбоотой бөгөөд энэ нь нийт хэтрэлтийн 62,9 хувийг эзлэж байна. Шатахуун, албан томилолт, шуудан холбооны зардал 150,0-890,0 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. 2001 оны 12 дугаар сард Тэргэнцэрийн сан олон нийтийн байгууллагын 2 ажилтны Архангай, Өвөрхангай аймгуудад ажилласны томилолтын зардалд 130,0 мянган төгрөгийг байгууллагаас олгосныг төлүүлэхээр акт тогтоолоо. Аймаг, дүүргүүдийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүдээс нийгмийн халамжийн санд төвлөрүүлэх ёстой маягт, дэвтрүүдийн үнэ 15,1 сая төгрөгийг УНХГ 2001 онд бусад орлогоор төвлөрүүлж төсөвт зардалд зарцуулсан нь Монгол улсын төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3-ын 1 дэх "... хуваарилан хургүүлсэн төсөв ...-ийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөнд хянан байцаагчийн албан шаардлага өглөө.

Тав. Дотоод хяналт шалгалтын тогтолцос,  
түүний үр дүнгийн талаар

УНХГ нь 2001 онд нийгмийн халамжийн сангийн зарцуулалтанд тавих дотоодын хяналт шалгалтын байцаагчийн хя тоогүй явж ирсэн байна. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтад тавих дотоодын хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор УНХГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу аймаг, дүүргүүдийн нийгмийн халамжийн төвүүд дотооддоо 1-2 удаа, УНХГ-аас 11 аймаг, 3 дүүрэгт шалгалт хийж 36,7 сая төгрөгийг зөрчил, дутагдал илрүүлж, 31,8 сая төгрөгийг барагдуулж, 4,9 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шүүжүүлсэн байна.

Аймаг, дүүргүүдийн нийгмийн халамжийн төвүүдэд хийгдсэн шалгалтаар бүрдэлгүй баримтаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгосон 612 зөрчлийг илрүүлж тэтгэвэр, тэтгэмжийг зогсоох арга хэмжээ авчээ. Мөн шалгалтаар төсвийн төлөвлөгөөг орон нутагт бодитой зохиогоогүй, сангийн хөрөнгийг бусдад зээлдүүлсэн, нийгмийн даатгалд даатгуулсан үргэдэд халамжийн тэтгэвэр тогтоосон, сангийн хөрөнгөөр эд хөгжил худалдан авсан, сангийн хөрөнгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.

УНХГ 2002 оноос хяналт шалгалтын байцаагчтай болж төлөвлөгөөт шалгалтыг хийж эхэлсэн байна.

Зургаа. Амралт, сувилал, асрамжийн газарт  
хийгдсэн шалгалтын талаар

1. Тарни амралт 2001 онд улсын төсвөөс 40,3 сая, амрах зорхойн бичгийн үнээс 40,2 сая, туслах аж ахуйгаас 5,4 сая нийтдээ 85,9 сая төгрөгийн орлого, санхүүжилттэй ажиллаж төсөвт зардалд 71,7 сая төгрөг зарцуулж, 1900 амрагчийг амруулж төлөвлөснөөс 650 амрагч илүү амруулсан байна. Тус амралт 2001 онд 5 ханатай иж бүрэн гэр 5, модон ор 100, ямаа хөгжим 1, мах, сүүний мал худалдан авах, 3 га-д хүнсний ногоо тариалах зэргээр материаллаг баазаа бэхжүүлэх арга хэмжээг авсан байна.

Шалгалтаар бараа, материалыг орлогод хий авч, авлага хаасан, удирдлагын шийдвэргүй болон үндсэн баримтгүйгээр бэлэн мөнгө зарцуулсан, нягтлан бодогч нь няравтайгаа хуйвалдан 926,0 мянган төгрөгийг хувьдаа ашиглан нуун дарагдуулсан, худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд хүн амын орлогын албан татвар ногдуулаагүй зэрэг зөрчил илэрсэн байна. Шалгалтын хугацаанд өмнөх шалгалтын актын төлбөрийн үлдэгдэл 1211,1 сая төгрөгийг барагдууллаа.

2. Аржанчивлин рашаан сувилал 2001 онд 3015 сувилуулагч, 128 хүүхэд хүлээн авч сувилан төлөвлөгөөг 103,0 хувь биелүүлжээ. Тус сувилал 2001 онд төсвөөс 44,2 сая, эрүүл мэндийн даатгалаас 27,8 сая, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас 56,0 сая, туслах аж ахуйгаас 3,8 сая төгрөгийн орлоготой



жиллаж, төсөвт зардалд 142,7 сая төгрөг зарцуулжээ. Түлш, халаалт, тээвэр, шатахуун, хоол, эм, бусад зардал 25,3-8188,8 мянган төгрөгөөр хэтэрч зарцуулагдсан болон төсөвт зарцуудаагүй мал, тоног төхөөрөмж худалдан авах, хөрөнгө зориулалт хийсэн зэрэг нь төсөв 9,0 сая төгрөгөөр хэтрэх үндэслэл болсон байна. Тус сувилалд төрийн өмчийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалт шалгалтгүйгээс Зил-130 автомашин, автобус зэрэг 9,2 сая төгрөгийн техник 2 жил ажиллаагүй ч түүнд хэдэн зуун мянган төгрөгийн сэлбэг зарцуулсан, 1999 онд худалдан авсан 1516,0 мянган төгрөгийн үнэтэй тавган антен, 1330,0 мянган төгрөгийн үнэтэй "ЭКГ" зүрхний бичлэгийн аппарат эвдэрч ашиглалтгүй болсон, 2001 онд худалдан авсан 3500,0 мянган төгрөгийн үнэтэй "ЭХО" аппарат ажиллуулах хүнгүйгээс ашиглалтгүй байна.

Касст хийсэн тооллогоор нярав А.Туулаас 254,0 мянган төгрөг дутагдсан байна. Нягтлан бодогч Г.Эрдэнэцэцэг нярвын байлалтын 014 тоот падан дээр цохолт хийж 200,0 мянган төгрөгийн үнэтэй гүний худгийн насосыг зарлага болгосон байна. Сувиллын даргаар ажиллаж байсан Г.Мижидсамбуу гар утас болон бусад баримтыг хүлээлгэж өгөөгүй байна.

3.Батсүмбэр дэх улсын асрамжийн газар 2001 онд 127,0 сая төгрөгийн орлого санхүүжилттэй ажиллаж төсөвт зардалд 119,0 сая төгрөг зарцуулж нэг асруулагчид хоногт 2203 төгрөгийн зардал гаргажээ. Тус байгууллагад хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт шалгалт сулаас "ЭС энд ЭМ" ХХК-иас нэг бүр нь 2,5 сая төгрөгийн үнэтэй угаалгын машин 2-ыг худалдан авч уг машинууд шаардлага хангаагүйн улмаас буцаасан мөнгө мөнгөө аваагүй байна. Тус амралтын дарга байсан Д.Хоролдорж, Г.Жигмидбаатар нар тэмээний махны үнэд 47,2 мянган төгрөг, хөвөнтэй дээлийн үнэд 180,0 мянган төгрөг вийлүүлэгч байгууллагад илүү төлсөн байв. Дэлгүүрийн худалдагч байсан Н.Ишка 483,9 мянган төгрөгийн хүнсний материалыг орлогод аваагүй, кассын нярав Д.Чимидийн тооцоо бодолтоор 91,8 мянган төгрөг дутагдсан зэрэг зөрчил илэрсэн байна. Ерөнхий эмч С.Амгалан тус асрамжийн газарт 30 жил ажиллаж байгаа ч ажлын идэвхи санаачлага сул, өвчтнүүдэд эмчилгээний карт хөтөлдөггүй, асруулагчдыг өдөр бүр үзлэгт оруулж эмчилгээ хийдэггүйгээс өвчтнүүдийн биеийн байдал сайжрахгүй байна. Асрамжийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай боловсон хүчнээр хангах, ашиглалтгүй болсон болон өөрийн онцлогт тохируулан өөр зориулалтаар ашиглах үндсэн хөрөнгө, материалын асуудлыг судлаж шийдвэрлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хангалтгүй анхаарчээ.

Улсын төсвийн ачааллыг багасгах үүднээс асрамжийн газрыг зах зээлийн нөхцөлд тохирсон арга хэлбэрээр хувьчлах асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагатай байна. Шалгалтаар 18,4 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч 711,1 мянган төгрөгийн акт тогтоогдсон байна.

Долоо.Аймаг, нийслэлийн ХШХ-доос хийсэн  
шалгалтын дүнгийн талаар

Аймаг, нийслэлийн ХШХ-дын шалгалтанд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний төв, сумын нийгмийн халамжийн ажилтны 50,0 хувь хамрагдлаа. Шалгалтаар нийт 54306.2 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 18317.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдлоо. Ажлын дутагдал заргасан 10 хүнийг 200.0 мянган төгрөгөөр торгож албан дүрэгтээ хариуцлагагүй хандсан 6 хүнд хариуцлага тооцож хариу мэдэгдэх хугацаатай үүрэг өгсөн байна.

Шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Галуут суманд хүүхэд асарсны тэтгэмжийг эрх үүсээгүй хүмүүст, Өлзийт суманд тахир дутуугийн группийн хугацаа дууссан хүнд тэтгэмж олгожээ.

Говь-Алтай аймгийн Халиун, Дэлгэр сумын халамжийн сангаас группийн хугацаа дууссан 7 хүнд 400.0 мянган төгрөг олгосноос гадна Халиун, Дэлгэр, Хөхморьт сумын байцаагч нар эмнэлгийн хуудасгүй болон хуудсыг засварлах замаар 447.0 мянган төгрөг ашигласан байна.

Дорноговь аймгийн НХҮТ үйл ажиллагааны болон халамжийн сангийн хөрөнгийг хооронд нь хольж зарцуулан, Даланжаргалан, Сайншанд суманд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур тэтгэмж тогтоосон зэрэг зөрчил илэрсэн байна.

Ховд аймгийн хэмжээгээр халамжийн тэтгэвэр авагч 1620 гаруй хүн байгаа боловч тэдгээрийн хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй, баяжилт хийгээгүй, үнэмлэх, регистрийн дугааргүй, засаг даргын тодорхойлолт байхгүй, тэр ч бүү хэл нас барсан 2 хүний нэр дээр 2-7 сарын тэтгэвэр олгожээ.

Ховд, Баян-Өлгий аймгуудын НХҮТөвүүд халамжийн сангаас өөрийн үйл ажиллагааны зардалд 1378.7-2550.0 мянган төгрөгийг зарцуулаад эргүүлж санд төвлөрүүлж тооцоо хийгээгүй байна.

Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, Төв аймгийн шалгагдсан сумдын халамжийн байцаагчид 2-37 хүнд 164.2-2243.4 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг бүрдэл дутуу баримтаар, давхардуулан илүү, дутуу олгосон байна.

Тэтгэвэр, тэтгэмжийг тайлан, тэнцэлд тусгахгүй орхих дутагдал зарим аймагт гарчээ. Жишээ нь: Архангай аймгийн Жаргалант сум 2000 онд олгогдох олон хүүхэдтэй эхийн тэтгэмж 2118.3 мянган төгрөгийг 2001 оны 6 дугаар сард олгосон нь оны эцсийн тайлан тэнцэлд тусгагдаагүй, Говь-Алтай аймгийн НХҮТ 167 хүнд олгох 3931.3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тайланд өглөгөөр тусгаагүй, Баянхонгор аймгийн НХҮТ сангийн хөрөнгөнөөс 1301.0 мянган төгрөгийг хүмүүст зээлээр олгоод данс бүртгэлд тусгаагүй байжээ.

Тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, халамжийн төвийн ажилтнууд хувьдаа ашигласан, дутагдуулсан зэрэг зөрчил шалгалтаар илэрлээ. Тухайлбал: Баянхонгор аймгийн Халамж үйлчилгээний төвөөс тахир дутуу

эргэдэд үнэгүй олгох сонсголын аппаратны үнэ 1600.0 мянган төгрөгийг аймгийн халамж үйлчилгээний төвийн нягтлан бодогч Ц.Доёд, Н.Эрдэнэцогт нар Баацагаан сумын халамжийн сангаас гаргуулан авч хувьдаа ашигласан байна.

Төв аймгийн Баянцогт сумын халамжийн сангаас 500,0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн санд 16 хоногоор ашиглуулсан, Эмнеговь аймгийн НХҮТ бэлнээр нөхөн олговорт олгохоор авсан 185,0 мянган төгрөгийг дутагдуулсан, Увс аймгийн НХҮТ УНХГ-ын 2001 оны 530 тоот зөвшөөрлийг үндэслэн 15.0 сая төгрөгийг конторын барилгын санхүүжилтэнд зарцуулж өөрийн үйл ажиллагааны зардалд тусгаж халамжийн хууль зөрчжээ.

Дархан-Уул аймгийн НХҮТ УНХГ-ын даргын шийдвэрээр ахмадын амралт, сувилалын барилгын их засварт 30.0 сая төгрөгийг авч 20.7 сая төгрөгийг засварт, 3.5 сая төгрөгийг үндсэн хөрөнгө бэлтгэхэд, 3.2 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгө бэлтгэхэд тус тус зарцуулжээ.

Орхон аймгийн НХҮТ хиймэл шүд хийлгэсний төлбөр 260.0, хүүхэд асарсны тэтгэмжийн мөнгө 147.0 мянган төгрөгийг хувийн харилцах дансанд шилжүүлснийг шалгаж үзэхэд үндсэн байгууллагад ороогүй хувь хүнд ашиглагдаж байжээ.

Нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөр төсөвлөсөн хэмжээнээс илүү хөрөнгө бэлтгэж нөөцлөх, үйл ажиллагааны зардлын санхүүжилт дутуу олгосон, үйл ажиллагааны зардлаа хэтрүүлж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр дүн муутай ашигласан зөрчил Сүхбаатар, Сэлэнгэ, Завхан, Дархан-Уул аймгийн НХҮТ-үүдэд гарчээ. Эдгээр аймгууд халамж үйлчилгээний төвүүдэд 1546.3-2892.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгож батлагдсан төсвийг Архангай, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Увс, Ховд, Хэнтий аймгуудын НХҮТ-үүд 76.9-3545.9 мянган төгрөгөөр, Улаанбаатар хотын дүүргүүд 193.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Баянхонгор аймгийн НХҮТ төсөвтөө 3.0 сая төгрөгөөр 60 ширхэг сонсголын аппарат авахаар төсөвлөсөн байхад Халамжийн төвийн дарга Ц.Эрдэнэ-Очир, нягтлан бодогч Ц.Доёд нар 12.9 сая төгрөгөөр 258 ширхэг аппарат худалдан авч төсөвт зардлыг 4.3 дахин хэтрүүлэн зарцуулжээ. Мөн төвийн байр, суудлын автомашин худалдан авах, үндсэн хөрөнгө бэлтгэх, шатахуун авах зэргээр 36515.0 мянган төгрөгийг УНХГ-ын даргын зөвшөөрлөөр зарцуулж халамжийн хуулийг зөрчжээ.

Увс аймгийн НХҮТ-ийн дарга Г.Ууганбаяр 2001 онд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлаар ОХУ-ын Алтайн хязгаарт томилсолтоор явж 798.4 мянган төгрөгийн зардал гаргасан боловч гэрээ нь хэрэгжээгүй үр дүн гараагүй байна.

Булган аймгийн НХҮТ УНХГ-ын даргын зөвшөөрлөөр суудлын авто машин худалдан авах, семинар, шагнал, засвар, тохижилтын зардалд 5522.6 мянган төгрөгийг, Завхан аймгийн НХҮТ сонин захиалах, сургалт семинар, ширээ, ном худалдан авах зэргээр 1203,2 мянган төгрөгийг, Өвөрхангай аймгийн НХҮТ халамжийн сангаас 388,1 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны зардалд

халамжийн хууль, сангийн журам зөрчин зориулалт бусаар зарцуулжээ.

Нийгмийн халамж үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байхад нийгмийн халамжийн сангаас үйл ажиллагааны зардалд мөнгө нэмж суваарилан өгч байгаа нь сангийн хөрөнгөнд үрэлгэн хандах, бизнес хийх эх үүсвэр болж байгаад УНХГ, СЭЗЯ анхаарч ажиллах зардлагатай байна.

#### Найм.Шалгалтаас хийх дүгнэлт

Улсын нийгмийн халамжийн газар, аймаг, дүүргүүдийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүд, сумдын нийгмийн халамжийн ажилтнууд нийгмийн халамжийн санг үндэслэлтэй төлөвлөх, төвлөрсөн төсвөөс олгосон хөрөнгийг үр дүвтэй, хэмнэлттэй, аж ахуйчаар зарцуулах талаар зарим ажил эсхиож байгаа боловч Нийгмийн халамжийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай зэрэг дуулиудыг зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, хувьдаа ашигласан, халамжийн сангийн хөрөнгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан, эрх хэмжээгээ хэтрүүлж илүү хөрөнгө бэлтгэсэн, бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа тендер зарлаагүй, нүүрс бэлтгэх гэрээг байгуулахдаа тооцоо судалгаа муутай хандсанаас нэн ядуу иргэдийг хохироосон зэрэг зөрчил, дутагдал Төрийн хянан шалгах хороо, аймаг, нийслэлийн хянан шалгах хорооны шалгалтаар илэрлээ.

Мөн харьяа газруудын үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт шалгалт сул, удирдах албан тушаалтны ажлыг дүгнэх, хариуцлага тооцох талаар хангалтгүй ажилласан байна.

#### Ес.Цаашид авах арга хэмжээний талаар санал

##### 1.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд:

а.НХХ-ийн сайдын 2001 оны 24 дүгээр тушаалаар баталсан хөнгөлөлттэй үнээр олгох протез, ортопедийн хэрэгслийн жишиг үнийн жагсаалтад тусгагдсан тэргэнцэр, сонсголын аппаратын үнийг Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх заалтын дагуу хянан үзэх;

б.Нийгмийн халамжийн санг төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор улсын төвлөрсөн төсвөөс нийгмийн халамжийн санд олгож санхүүжилтийн гэрээг Санхүүгийн засгийн яамтай оны эхэнд байгуулж, гэрээний хариуцлагыг тооцож ажиллах;

в.Асрамжийн газрыг боловсон хүчээр хангах, ашиглалтгүй болсон болон өөрийн онцлогт тохируулан өөр зориулалтаар

шиглах үндсэн хөрөнгө, материалын асуудлыг судлан шийдвэрлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

## 2. Улсын нийгмийн халамжийн газарт:

а. Аймаг, дүүргийн халамж үйлчилгээний төвүүд болон Улсын нийгмийн халамжийн газраас нийгмийн халамжийн сангийн төвлөлөлтийн үндэслэлийг сайжруулж, батлагдсан санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, дүүргүүдийн нийгмийн халамж үйлчилгээний төвүүдээс хөрөнгө төвлөрүүлэн авч төсөвлөөгүй зүйл зарцуулдгийг зогсоох;

б. Улсын нийгмийн халамжийн газрын хэмжээнд тухайн жилд шийдгэх хөрөнгө оруулалт, техник хэрэгсэл бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн дагуу тендерийн урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж, тендер шалгаруулан шийдвэрлэж байх;

в. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн сонголын аппарат, тэргэнцэр зэрэг техник хэрэгслийг албан тушаалтны ам шийдвэрээр зарцуулж, тайлан гаргуулдаггүй дутагдлыг арилгах;

г. Нийгмийн халамжийн хуульд заагдаагүй арга хэмжээнд халамжийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай Нийгмийн халамжийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн практикийг өөрчилж хуульд нийцүүлэх;

д. Нийслэлийн дүүргүүдийн халамж үйлчилгээний төвүүдээс үнэн ядуу иргэдэд нүүрс олгож буй байдал, нүүрсний үнэ, үнээврийн зардал тогтоосон гэрээний үндэслэлийг бодит байдалд нийцүүлж, иргэдийг хохироох явдал гаргахгүй байх;

Хяналт шалгалтын хоёрдугаар газар

2002 оны 9 дүгээр сарын 23

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН